**МОНГОЛ УЛСЫН**
**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**

14251 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,
Утас: (976) 51-267168, Факс: (976) 11-312315,
E-mail: info@mrtd.gov.mn, http://www.mrtd.gov.mn

2022-03-22 № 03/1280

танай ________ -ны № ________ -т

“АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ”
ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ Б.ГҮРСОРОНЗОН
ТАНАА

Тус яамтай “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын байгуулсан “Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ”-г хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт болон тус газрын үйл ажиллагаанд 2022 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын товч тайланг хүргүүлэв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлантай танилцаж, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана уу.

Хавсралт 68 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА С.БАТБОЛД

9020050420 5919487 СБА7589

080001132

Боловсруулсан: [signature]
Хянасан:
Хувь: 2
Огноо: 2013.03.21

## “АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨҮГ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

2022.12.27 Улаанбаатар хот

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго**

Зам, тээврийн хөгжлийн яамнаас “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-тай байгуулсан “Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ”, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт болон тус газрын үйл ажиллагаанд 2022 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар зөвлөмж боловсруулах замаар яам болон “АТҮТ” ТӨҮГ-ын удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах, гарсан дүгнэлт зөвлөмжийг дараагийн бодлого, шийдвэр, төлөвлөгөөнд тусгах, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулахад энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

**Хоёр. Үндэслэл, арга зүй**

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2021 оны 374 дүгээр тогтоол, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг тус тус баримталсан.

Тус газрын үйл ажиллагааны үр дүнг үнэлэхэд дараах баримт бичгийг хамруулсан. Үүнд:

-“Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ”-г хэрэгжүүлэх 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт;
-Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт;
-Монгол улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний биелэлт;
-Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт;
-Зам, тээврийн хөгжлийн Сайдын тушаалын биелэлт;
-Сайдын зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэрийн биелэлт;
-Зам, тээврийн хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын зам, тээврийн салбарт 2021-2024 онд хамтран ажиллахаар байгуулсан “Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт;
-Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтийн үнэлгээ;
-Шилэн дансны мэдээлэл гэсэн 9 үзүүлэлтийг хамруулсан.

**Гурав. Танилцуулга**

Тус газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ дээрх 9 үзүүлэлтээр дүгнэлээ. Үүнд:

**3.1. “Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ”-г хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт:**

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 76 дугаар тушаалаар Автотээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхээс 7 чиг үүргийг гэрээний үндсэн дээр “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-т шилжүүлэн гүйцэтгүүлж байна.

Энэ хүрээнд Зам, тээврийн хөгжлийн яам “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-тай “Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ”-г жил бүр байгуулж, гэрээг хэрэгжүүлэх үйл

ажиллагааны төлөвлөгөөг батлуулдаг ч 2022 оны гэрээ, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг өнөөдрийг хүртэл батлуулаагүй ажилласан.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 76 дугаар тушаалаар гэрээгээр гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний чанар, гүйцэтгэлийн байдалд жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ өгч ажиллах үүрэг өгсний дагуу “Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ”-г хэрэгжүүлэх 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг жилийн эцсийн байдлаар үнэллээ.

Уг төлөвлөгөөнд 21 зорилтын хүрээнд 72 арга хэмжээ тусгаснаас 2022 оны жилийн эцсийн байдлаар “үр дүнтэй” буюу бүрэн хэрэгжсэн 30, “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 90 хувьтай 18, 70 хувьтай 20, “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 50 хувьтай 2, “үр дүнгүй” буюу 30 хувьтай 2 арга хэмжээ байгаа ба төлөвлөгөөний хэрэгжилт **85.8** хувьтай байна.

“Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ”-г хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг 2022 оны жилийн эцсийн байдлаар хүснэгтээр харуулбал:

| № | Төлөвлөгөөнд тусгагдсан нийт арга хэмжээ | Үүнээс хэрэгжилтийн байдал /хувиар/ | | | | | | Биелэлт /хувиар/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 100 | 90 | 70 | 50 | 30 | 0 | |
| 1 | 72 | 30 | 18 | 20 | 2 | 2 | - | **85.8** |

**“Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 50 хувьтай 2 арга хэмжээ:**

**1.Ховд болон Орхон аймагт автобуудлын барилгыг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд барьж байгуулах (1.11.1)** *Зорилтот түвшин:* 2 аймгийн Автобуудлын барилгыг ашиглалтад оруулсан байна.

***Биелэлт:*** *Орхон аймгийн автотээврийн төвийн автобуудлын барилгын ажлыг тус аймгийн орон нутгийн санхүүжилтээр 2022-2023 онд барьж байгуулахаар төлөвлөж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдөр шалгаруулахад “Шинжүү” ХХК шалгарч гэрээ байгуулан барилгын ажлыг 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдөр эхлүүлсэн бөгөөд 621 м.кв талбайн суурийг ухаж ул бетон авах бэлтгэл ажил төлөвлөгөөний дагуу хийгдсэн.2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар барилгын ажил 20 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Зоорийн болон 1-р давхар цутгагдсан. 2022 оны төлөвлөгөөт ажил хийгдэж, дууссан.*

*“Зорчигч тээврийн Ховд” ХХК нь компани гв өөрийн хөрөнгө оруулалтаар Ховд аймагт автобуудал барьж байна. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 85%-тай байна.*

**2 Байгууллагынхаа хэмжээнд кибер (мэдээллийн) аюулгүй байдлын эрсдэлийн иж бүрэн шинжилгээ, үнэлгээ хийлгэж, кибер (мэдээллийн) аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо бүрдүүлэх, аюулгүй байдлын архитектураа төлөвлөх талаар цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх (1.21.2)** *Зорилтот түвшин:Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо бий болгоход шаардлагатай эрх зүй, бодлого, зохицуулалтын орчныг бүрдүүлсэн байна.*

***Биелэлт:*** *Уг ажлын хүрээнд Кибер аюулгүй байдал, мэдээллийн технологийн аудит, консалтингийн чиглэлээр үйлчилгээ, сургалт явуулдаг “Систем центр” ХХК–иас сургалт авч үйлдвэрийн газрын мэдээллийн технологийн өнөөгийн байдал болон цаашид шаардлагатай байгаа чиглэлээ тодорхойлон тус компаниас систем, өгөгдлийн сангуудаа мэдээллийн технологи, кибер аюулгүй байдлын үнэлгээ, шинжилгээ хийлгэх үнийн санал авч удирдлагуудад танилцуулаад байна.*

**“Үр дүнгүй” буюу 30 хувьтай 2 арга хэмжээ:**

**1. Байгууллагынхаа нийт компьютерын 30-аас дээш хувийг албан ёсны байнгын ашиглах эрх (лиценз)-тэй үйлдлийн систем болон оффисын программ хангамжтай болгож, аюулгүй байдлыг хангах. (1.21.3)** *Зорилтот түвшин:* Зорилт, арга хэмжээг 100% хэрэгжүүлсэн байна.

***Биелэлт:*** *Үйлдвэрийн газарт ашиглагдаж байгаа зөөврийн болон суурин компьютерүүдийн 30 хувь буюу 140 ширхэг компьютерт шаардлагатай лицензийн үнийн*

*саналыг "Zeissoftware Digital Limited" LLC, "Экзотик девелопмент" ХХК, "Ашим" ХХК, "Мобинет" ХХК зэрэг албан ёсны лиценз нийлүүлэгч аж ахуй нэгжүүдээс үнийн санал аван төсөвт тодотгол оруулах саналыг хүргүүлээд байна.*

**2.Үйлдвэрийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийх /1.1.6/** *Зорилтот түвшин:* Захирлын зөвлөлд тайлагнаж, холбогдох нэгжид зөвлөмж хүргүүлсэн байна.

***Биелэлт:*** *Хяналт-шинжилгээ, дотоод аудитын албаны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.1.3, 1.1.4 дэх заалт, дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөний 1.3, 1.6 дахь заалтуудыг үндэслэн Зорчигч тээврийн хэлтсийн Мэргэшсэн жолоочийн тасаг, Сонгинохайрхан зорчигч тээврийн төв, Сонгинохайрхан техникийн хяналтын үзлэгийн төв,* Захиргаа, сургалт, хүний нөөцийн хэлтсийн Худалдан авах үйл ажиллагаанд, Баянзүрх техникийн хяналтын үзлэгийн төвд *санхүүгийн аудит хийж холбогдох зөвлөмжүүдийг өгч ажилласан байна.*

**3.2. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт:**

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд автотээврийн чиглэлээр 4 арга хэмжээ тусгагдсанаас 2022 оны жилийн эцсийн байдлаар "үр дүнтэй" буюу зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн 1, "тодорхой үр дүнд хүрсэн" буюу 70 хувьтай 2, "эрчимжүүлэх шаардлагатай" буюу 50 хувьтай 1 арга хэмжээ байгаа ба хэрэгжилт **72.5** хувьтай байна.

| Нийт арга хэмжээ | Үүнээс хэрэгжилт (хувиар) | | | | | | Биелэлт (хувиар) |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 100 | 90 | 70 | 50 | 30 | 0 | |
| 4 | 1 | - | 2 | 1 | - | - | **72.5** |

**"Эрчимжүүлэх шаардлагатай" буюу 50 хувьтай 1 арга хэмжээ:**

**Замын-Үүд, Сэлэнгэ, Булган, Орхон, Говь-Сүмбэр, Дорнод, Сүхбаатар, Дундговь, Өвөрхангай, Ховд, Говь-Алтай аймгийн төвд зорчигч тээврийн автобуудал байгуулна;** *Зорилтот түвшин:* 3 аймгийн автобуудал ашиглалтад оруулна.

***Биелэлт:*** *Улсын төсвийн 5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 онд Орхон аймагт автобуудал барих төсөл хэрэгжиж байна. Автобуудлын барилга угсралтын ажил 20%-ийн гүйцэтгэлтэй, төлөвлөгөөний дагуу хоцрогдолгүй явж байна. "Зорчигч тээврийн Ховд" ХХК нь компанийн өөрийн хөрөнгө оруулалтаар Ховд аймагт автобуудал барьж байна. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 85%-тай, энэ онд багтаан ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй байна."Бүрд чандмань" ХХК Хэнтий аймгийн Хэрлэн сумд автобуудал, мөн "Гэзэгт" ЗГБХН-ээс Говьсүмбэр аймгийн төвд одоогоор үйл ажиллагаа явуулж байгаа байранд өргөтгөл хийж автобуудал байгуулах санал, ТЭЗҮ ирүүлснийг хэрэгжих боломжтой гэж үзэн хамтран ажиллах гэрээ байгуулсан.*

**3.3. Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний биелэлт:**

| Нийт арга хэмжээ | Үүнээс хэрэгжилт (хувиар) | | | | | | Биелэлт (хувиар) |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 100 | 90 | 70 | 50 | 30 | 0 | |
| 1 | - | - | 1 | - | - | - | **70.0** |

## 3.4. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт:

Тайлант хугацаанд тус газарт хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр 5 үүрэг өгөгдсөнөөс "бүрэн хэрэгжсэн" 1, "хэрэгжих шатанд" буюу 70 хувьтай 2, "хэрэгжилт хангалтгүй" буюу 30 хувьтай 1 арга хэмжээ байгаа ба хэрэгжилтийн дундаж **67.5** хувьтай байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг эрхзүйн актуудаар ангилан хувиар илэрхийлбэл:

| № | Эрхзүйн актын нэр | Нийт арга хэмжээ /заалт/ | Үүнээс хэрэгжилтийн байдал /хувиар/ | | | | | Биелэлт /хувиар/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 | 70 | 30 | 0 | Хугацаа болоогүй | |
| 2. | Ерөнхийлөгчийн зарлиг | 3 | - | 1 | 1 | - | 1 | 50.0 |
| 5 | Засгийн газрын тогтоол | 2 | 1 | 1 | - | - | - | 85.0 |
| | **Дүн** | **5** | **1** | **2** | **1** | **-** | **1** | **67.5** |

**"Хэрэгжилт хангалтгүй" 30 хувьтай 1 арга хэмжээ:**

**2018_46. Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай 2018-05-23 Ерөнхийлөгчийн зарлиг.** 3.Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай.

***Биелэлт:*** *Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ нь байгууллагынхаа гадна нэр, хаягийг кирилл болон үндэсний бичгээр бичиж, байршуулсан. Мөн үйлдвэрийн газрын Улаанбаатар хот дахь техникийн хяналтын үзлэгийн болон зорчигч тээврийн төвүүдийн хаягийг кирилл болон үндэсний бичгээр бичиж, шинэчилсэн. Түүнчлэн орон нутгийн зарим салбар төвүүдийн хаягийг үндэсний бичгээр бичиж байршуулаад байна. Үйлдвэрийн газрын цахим хуудасны "Ил тод байдал" цэсний "Хүний нөөц хэсэг"-т "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр" дэд цэс нээж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 46 дугаар зарлиг, Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III", Монгол бичгийн цуврал хичээл, монгол бичгийн гарын драйвер болон фонт суулгах заавар, монгол бичгээр хэрэглээний програм бичих заавар зэргийг байршуулсан.*

## 3.5. Сайдын тушаалын биелэлт:

Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар тус газарт үүрэг өгсөн 80 арга хэмжээ 2022 оны жилийн эцсийн байдлаар хяналтад байгаагаас "бүрэн хэрэгжсэн" 55, "хэрэгжих шатанд" буюу 70 хувьтай 20, "хэрэгжилт хангалтгүй" буюу 30 хувьтай 2, "хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй" 2, хүчингүй болсон 1 арга хэмжээ байгаа ба хэрэгжилт **90.4** хувьтай байна.

| Нийт заалт | Үүнээс хэрэгжилтийн байдал (хувиар) | | | | | Хүчингүй болсон | Биелэлт (хувиар) |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 100 | 70 | 30 | 0 | Хугацаа болоогүй | | |
| 80 | 55 | 20 | 2 | - | 2 | 1 | **90.4** |

***"Хэрэгжилт хангалтгүй" 2 арга хэмжээ:***

**1. Тушаалын хэрэгжилтийг сайжруулах зарим арга хэмжээний тухай 2020.10.29 №А/202** 1.Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны "Сахилга хариуцлага-хөдөлмөрийн аюулгүй байдлын жил болгон зарлах тухай" А/01 дугаар тушаалын хэрэгжилтийг шалгах ажлын удирдамжийн дагуу хийгдсэн шалгалтын дүнг хавсралтад дурдсанаар үнэлсүгэй. 3. Илэрсэн зөрчлийг арилгасан тухай тайланг 2020.11.20-ны дотор ХШҮДАГ-т ирүүлэх, цаашид сахилга, хариуцлага, хөдөлмөрийн аюулгүй байдлын чиглэлээр хяналт шалгалтыг харьяа байгууллага бүр дотооддоо зохион байгуулж байхыг холбогдох байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

***Биелэлт:** Орхон аймгийн автотээврийн төвийн автобуудлын барилгын ажлыг тус аймгийн орон нутгийн санхүүжилтээр 2022-2023 онд барьж байгуулахаар төлөвлөж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан ба "Шинжүү" ХХК барилгын ажлыг гүйцэтгэж байна. Барилгын ажлын гүйцэтгэл 20 хувьтай байгаа ба шинээр автобуудал баригдаж байгаа тул хуучин автобуудалд хөрөнгө оруулалт шаардлагагүй, эдийн засгийн үр ашиггүй гэж үзсэн.*

**2. Төлөвлөгөө батлах тухай 2021.02.09 №19**. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөөг 1 дүгээр хавсралтаар, зам, тээврийн салбарт 2020-2024 онд хэрэгжүүлэх дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах 2. батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлж, биелэлтийг улирал бүр тайлагнаж ажиллахыг холбогдох газар, хэлтсийн дарга нарт даалгасугай.

***Биелэлт:** Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тус газраас хариуцан хэрэгжилтийг зохион байгуулах 4 арга хэмжээ тусгагдсан ба 2022 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилт 72.5 хувьтай байна. Тус төлөвлөгөөний биелэлтийг улирал бүр яаманд тайлагнаж үнэлүүлж ирсэн.*

## 3.6. Сайдын зөвлөлийн хуралдааны шийдвэрийн биелэлт:

Сайдын зөвлөлийн хуралдааны 2021 оны шийдвэрээс тус газрын хариуцан хэрэгжүүлэх 1 арга хэмжээ 2022 оны жилийн эцсийн байдлаар хяналтад байгаа ба 1 арга хэмжээ **100** хувь хэрэгжсэн байна.

## 3.7. Зам, тээврийн хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын зам, тээврийн салбарт 2021-2024 онд хамтран ажиллахаар байгуулсан "Санамж бичиг"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт:

Зам, тээврийн хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын зам, тээврийн салбарт 2021-2024 онд хамтран ажиллахаар байгуулсан "Санамж бичиг"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тус газраас хариуцан хэрэгжүүлэх 5 арга хэмжээ байгаагаас "үр дүнтэй" буюу 100 хувьтай 2, "тодорхой үр дүнд хүрсэн" буюу 70 хувьтай 1, "үр дүнгүй" буюу 30 хувьтай 2 арга хэмжээ байгаа ба хэрэгжилтийн дундаж **66.0** хувьтай байна.

| Нийт арга хэмжээ | Хэрэгжилт (хувиар) | | | | | | | Биелэлт (Хувиар) |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 100 | 90 | 70 | 50 | 30 | 0 | Хугацаа болоогүй | |
| 5 | 2 | - | 1 | - | 2 | - | - | **66.0** |

***"Үр дүнгүй" буюу 30 хувьтай 2 арга хэмжээ:***

**1. Нийслэлд зорчигч тээврийн терминал байгуулна. (2.4)** *Зорилт:* 2022 он ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлүүлнэ.

***Биелэлт:** Короновируст халдвар COVID-19 цар тахлын нөлөөгөөр Монгол Улсын Засгийн газрын 2021.02.17-ны өдрийн 43 дугаар тогтоол, ТӨБЗГ-ын 2021.02.26-ны өдрийн А-*

*1/354 дүгээр албан даалгаврын дагуу ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах боломжгүй болсон.Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт "Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нийслэлд зорчигч тээврийн зориулалт бүхий терминалуудыг байгуулна" гэж тусгагдсаны дагуу "Концессын тухай хууль"-ийн 10.3 дах заалтын дагуу Улаанбаатар хотын Хан-Уул, Баянзүрх дүүрэгт байгуулагдах автобуудлын нөхцөл байдал, үр ашгийн тооцооллыг хийн 2021.10.29-ний өдрийн 2/1378 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн.*

**2. Ачаа болон такси үйлчилгээний тээврийн үйлчилгээнд одоо ашиглаж байгаа программаас мэдээлэл авч нэгдсэн тайлан гаргадаг систем хөгжүүлсэн байна.(2.5)**

*Зорилт:* Хот болон хот орчмын тээвэрлэгдэж байгаа ачаа тээврийн үйлчилгээг бүртгэлжүүлэх, хяналтыг хэрэгжүүлнэ. Такси үйлчилгээний компаниудын одоо ашиглаж байгаа програмуудаас мэдээлэл авч нэгдсэн тайлан гаргадаг систем хөгжүүлнэ.

***Биелэлт:*** *Тус үйлдвэрийн газар нь дотоодын ачаа тээврийг бүртгэлжүүлэх, програм хангамжийг улсын хэмжээнд нэвтрүүлэх, хэрэгжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд Дотоодын ачаа тээврийн цахим системийн мобайл апп хөгжүүлэлтийг Андройд болон IOS үйлдлийн системд зориулан хийж гүйцэтгэж дууссан.*

## 3.8. Ил тод, нээлттэй байдлын үнэлгээ:

Нийтийн мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг 46 шалгуур үзүүлэлтээр дүгнэхэд бүрэн хэрэгжсэн буюу 100 хувьтай 16, "хэрэгжих шатанд" буюу 70 хувьтай 8, "хэрэгжилт хангалтгүй" буюу 30 хувьтай 9, хэрэгжээгүй буюу 0 хувьтай 1, хугацаа болоогүй 12 арга хэмжээ байгаа ба хэрэгжилт **71.5** хувьтай байна.

| Шалгуур үзүүлэлтийн тоо | Үүнээс хэрэгжилт ( хувиар ) | | | | | Биелэлт ( хувиар ) |
|---|---|---|---|---|---|---|
| | 100 | 70 | 30 | 0 | Хугацаа болоогүй | |
| 46 | 16 | 8 | 9 | 1 | 12 | **71.5** |

**Хэрэгжилт хангалтгүй" буюу 30 хувьтай 9 арга хэмжээ:**

***Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах хүрээнд:***

1.Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж (1.3)

***Биелэлт:*** *2021 оны санхүүгийн аудитын тайланд хийсэн аудитын зөвлөмжийн биелэлтийг цахим хуудсанд байршуулсан. (мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, тайлан, акт, дүгнэлт зэрэг дутуу байна.)*

2.Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт (1.6)

***Биелэлт:****Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн актыг байгууллагын веб хуудасны Хууль эрх зүй цэсийн Хууль, дүрэм, журмын жагсаалт дэд цэсэд байршуулсан. (Жагсаалт биш, PDF file болгож оруулах)*

3. Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг (1.7)

***Биелэлт:*** *Бидний тухай цэсэд бүтцийн нэгжүүд гэсэн дэд цэс нээж алба, хэлтсээр ялган албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаягийг байршуулсан. (Албан тушаалын тодорхойлолт байхгүй, бусад мэдээ дутуу байна. Хуулиар бүгдийг ил тод байхаар зохицуулсан.)*

4.Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл (1.9)

***Биелэлт:*** *Улс хоорондын ачаа тээврийн статистик мэдээг тус үйлдвэрийн газрын цахим хаягийн мэдээ мэдээлэл цэсэнд тухай бүр байршуулан ажиллаж байна. (Улирал бүр файл байршуулах)*

***Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах хүрээнд:***

5. Ажлын байрны сул орон тооны талаар мэдээлэл (2.1)
***Биелэлт:*** *Тус үйлдвэрийн газрын "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг Захирлын 2022.01.03-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан. "Хөдөлмөрийн дотоод журам"-д сул орон тооны зарыг олон нийтэд нээлттэй зарлан мэдээлэх талаар тусгасан. Ажлын байрны сул орон тоо гарсан тохиолдол бүрт хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд нээлттэй зарлаж ажлын байрны шаардлага хангасан иргэнийг албан тушаалд томилсон байна.* (сайт дээр ажлын байрыг 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрөөс хойш мэдээлээгүй байна. Холбогдох линкийг байршуулаагүй, ил тод, нээлттэй өрсөлдөөнийг хангаагүй байна.)

6. Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам (2.4)
***Биелэлт:*** *Үйлдвэрийн газрын цахим хуудасны "Ил тод байдал" буланд "Хүний нөөц" цэсийн "Хүний нөөц стратеги бодлого" дэд цэс ажиллуулан тус үйлдвэрийн газрын хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх дараах журмуудыг байршуулсан.* (байгууллагын хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилт, хянаж үнэлэх журамтай байх)

***Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах хүрээнд:***

7.Шилэн дансны хэтлэлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл (3.9)
***Биелэлт:*** *Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг хоцроосон нэр бүхий албан хаагчдад сарын үндсэн цалинг 1 сар 20 /хорь/ хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсан байна. Үндэсний аудитын газраас тус үйлдвэрийн газарт 2020, 2021 онд хийгдсэн аудитын шалгалтаар өгөгдсөн зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гарган ажилласан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг гаргаж Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Зам, тээврийн хөгжлийн яам, Үндэсний аудитын газарт тус тус хүргүүлж тайлагнасан. (ил тод мэдээлэх)*

8.Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл (3.12)
***Биелэлт:*** *Тус үйлдвэрийн газрын сургалтын төлөвлөгөөний дагуу Худалдан авах ажиллагааны А3 сертификатын сургалтанд 21 албан хаагчдыг онлайнаар хамрагдсан бөгөөд 6 албан хаагч сертификатаа авсан.( буруу мэдээлэл байршуулсан байна.)*

***Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах хүрээнд:***

9. Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг, /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албан цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл (5.6)
***Биелэлт:*** *Тус үйлдвэрийн газрын Захирлын зөвлөлийн гишүүд болох 4 дэд захирлыг үүрэгт ажлаас чөлөөлсөн. Үйлдвэрийн газрын Захирлын 2022.03.14-ний өдрийн А/71 дүгээр тушаалаар Захирлын зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн баталсан.( мэдээлэх ёстой нэг ч мэдээ байхгүй, ил тод байх)*

***"Хэрэгжээгүй" тасарсан 1 арга хэмжээ:***

Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллгааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг (5.5)

***Биелэлт:*** *"АТҮТ" ТӨҮГ нь нэгдсэн төсөвт нийт 3,927,707,641.34 төгрөгийг төвлөрүүлж, 2,579,840,000.0 төгрөгийн ноогдол ашгийг ТӨБЗГ-ын дансанд төвлөрүүлэн ажилласан. / мэдээлэл дутуу, ил тод байх, олон нийтэд мэдээлсэн линк байршуулах/*

## 3.9. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:

"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ нь тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн веб сайтад төсөв, гүйцэтгэлийн чиглэлээр 7, хөрөнгө оруулалт, худалдан авалт, тендэрийн чиглэлээр 5, бусад чиглэлээр 6, нийт 3 чиглэлийн хүрээнд 18 төрлийн мэдээ байршуулахаас 13 төрлийн мэдээг цаг хугацаанд нь, 2 төрлийн мэдээг хугацаа хоцроож байршуулсан, 1 мэдээллийн байршуулах хугацаа болоогүй байгаа ба хэрэгжилт **94.7** хувьтай байна.

| № | Мэдээллийн агуулга | Байршуулбал зохих мэдээллийн төрөл | Байршуулсан мэдээллийн төрөл | Тайлант хугацаанд байршуулсан | Хугацаа хоцроож байршуулсан | | | | Биелэлт ( хувиар ) |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 100 | 70 | 30 | 0 | Хугацаа болоогүй | |
| 1. | Төсөв, гүйцэтгэл | 7 | 7 | 6 | 1 | - | - | - | 95.7 |
| 2. | Хөрөнгө оруулалт, тендэр, худалдан авалт | 5 | 4 | 4 | - | - | - | 1 | 100 |
| 3. | Бусад | 6 | 6 | 4 | 2 | - | - | - | 90.0 |
| | Дүн | 18 | 17 | 14 | 3 | - | - | 1 | **94.7** |

"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын үйл ажиллагааг 2022 оны жилийн эцсийн байдлаар үнэлэхэд "Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ"-г хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 85.8 хувьтай, МУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 72.5 хувьтай, МУ-ын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний биелэлт 70 хувьтай, Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлт 67.5% хувьтай, сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт 90.4 хувьтай, сайдын зөвлөлийн хуралдааны шийдвэрийн биелэлт 100 хувьтай, Зам, тээврийн хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга нарын хооронд байгуулсан санамж бичгийн биелэлт 66.0 хувьтай, Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтийн үнэлгээ 71.5 хувьтай, Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ 94.7 хувьтай байна.

**"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын үйл ажиллагаанд 2022 оны жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн дүнг хүснэгтээр харуулбал:**

| № | Хяналтанд байх арга хэмжээ | 2022 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ | Үүнээс | | Биелэлт /Хувиар/ | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ | Тухайн улиралд тасарсан арга хэмжээ | Дундаж хувь | 100 | 90 | 70 | 50 | 30 | 0 |
| 1 | "Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ"-г хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт | 72 | 72 | - | 85.8 | 30 | 18 | 20 | 2 | 2 | - |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | 4 | 4 | - | 72.5 | 1 | - | 2 | 1 | - | - |
| 3 | МУ-ын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний биелэлт | 1 | 1 | - | 70.0 | - | - | 1 | - | - | - |
| 4 | Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлт | 5 | 4 | - | 67.5 | 1 | - | 2 | - | 1 | - |
| 5 | Сайдын тушаалын биелэлт | 80 | 77 | | 90.4 | 55 | - | 20 | - | 2 | - |
| 6 | Сайдын зөвлөлийн хуралдааны шийдвэрийн биелэлт | 1 | 1 | - | 100 | 1 | - | - | - | - | - |
| 7 | ЗТХСайд, Нийслэлийн ЗД-тай байгуулсан "Санамж бичиг"-ийн биелэлт | 5 | 5 | - | 66.0 | 2 | - | 1 | - | 2 | - |
| 8 | Ил тод нээлттэй байдлын үнэлгээ | 46 | 34 | 1 | 71.5 | 16 | - | 8 | - | 9 | 1 |
| 9 | Шилэн дансны хэтлэлтийн үнэлгээ | 18 | 17 | - | 94.7 | 14 | - | 3 | - | - | - |
| | Дүн | **232** | **215** | **1** | **84.8** | **120** | **18** | **57** | **3** | **16** | **1** |

**Дээрх 9 үзүүлэлтийн үнэлгээг өмнөх улиралтай харьцуулбал:**

| № | Хяналтад байгаа арга хэмжээ | 2022 оны үнэлгээ | | Өмнөх улиралтай харьцуулбал (хувиар) |
|---|---|---|---|---|
| | | Жилийн эцэс (хувиар) | 3 дугаар улирал (хувиар) | |
| 1 | "Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ"-г хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт | 85.8 | 71.0 | 14.8 |
| 2 | Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт | 72.5 | 62.5 | 10.0 |
| 3 | Монгол улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт | 70.0 | 0.0 | 70.0 |
| 4 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт | 67.5 | 67.5 | - |
| 5 | Сайдын тушаалын биелэлт | 90.4 | 84.2 | 6.2 |
| 6 | Сайдын зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэрийн биелэлт | 100 | 70.0 | 30.0 |
| 7 | Нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлт | 66.0 | 62.5 | 3.5 |
| 8 | Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлт | 71.5 | 84.5 | (13) |
| 9 | Шилэн дансны хэтлэлтийн үнэлгээ | 94.7 | 93.0 | 1.7 |
| | **Дундаж үнэлгээ** | **84.8** | **78.3** | **6.5** |

## Дөрөв. Дүгнэлт

Дээрх 9 үзүүлэлтийн хүрээнд нийт 232 арга хэмжээний хэрэгжилтийг дүгнэхэд "үр дүнтэй" буюу бүрэн хэрэгжсэн 120, "тодорхой үр дүнд хүрсэн" буюу 90 хувьтай 18, "хэрэгжих шатанд" буюу 70 хувьтай 57, хэрэгжилт хангалтгүй, "эрчимжүүлэх шаардлагатай" 50 хувьтай 3, "хэрэгжилт хангалтгүй" 30 хувьтай 16, "үр дүнгүй" буюу хэрэгжээгүй тасарсан 1, хэрэгжилтийн хугацаа тооцох болоогүй 17 арга хэмжээ байгаа ба дундаж үнэлгээ **84.8%**-тай байна. Энэ нь өмнөх улиралтай харьцуулахад **6.5** хувиар, өмнөх оны мөн үетэй харьцуулахад **2.6** хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Тус газрын үйл ажиллагааг 9 үзүүлэлтээр үнэлэхэд долоон үзүүлэлтийн үнэлгээ өмнөх улирлаас өссөн, нэг үзүүлэлтийн үнэлгээ өмнөх улиралтай адил, нэг үзүүлэлтийн үнэлгээ буурсан үзүүлэлттэй байна.

"Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ"-г хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд 72 арга хэмжээ тусгаснаас 76.4 хувь буюу 55 арга хэмжээ нь гэрээний үндсэн дээр чиг үүрэг шилжсэн 7 ажил, үйлчилгээ байна. Үүнд:

-Улс хоорондын ачаа, зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээг зохион байгуулах чиглэлээр 34;

-Жуулчин тээвэрлэлтийн үйлчилгээг зохион байгуулах чиглэлээр 1;

-Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох үйл ажиллагааг зохион байгуулах чиглэлээр 11;

-Автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажлыг зохион байгуулах чиглэлээр 5;

-Автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолоочийн шалгалт авах, үнэмлэх олгох ажлыг зохион байгуулах чиглэлээр 2;

-Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох үйл ажиллагааг аймаг, орон нутагт зохион байгуулах чиглэлээр 2 арга хэмжээ байна.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд улсын чанартай авто замын дагуу 150-200 км тутамд үйлчилгээний цогцолбор байгуулах арга хэмжээг Засгийн газрын 2016-2020, 2020-2024 оны мөрийн хөтөлбөрт удаа дараа тусгасан ба энэ хугацаанд 20 орчим цогцолборыг хувийн хэвшлийнхэн өөрийн хөрөнгөөр барьж байгуулсан. Харин ашиглалтад орсных нь дараа тэднийг төрөөс бодлогоор дэмжих, хамтарч ажиллах ажил хангалтгүй байна. Тухайлбал: Тус газрын "Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ" болон гэрээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд улс, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээг иргэдэд шуурхай, хүртээмжтэй хүргэх, зөвхөн стандартын шаардлага хангаж буй авто замын дагуух үйлчилгээний байгууламжаар дамжуулан үйлчилгээг зохион байгуулах гэж тусгадаг. Үүний дагуу тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан "Хот хоорондын нийтийн тээвэрлэлтийг зохион байгуулах, гүйцэтгэх гэрээ"-нд тээвэрлэлт гүйцэтгэх цагийн хуваарь, жолоочийн хөдөлмөр амралтын горимд чиглэл, маршрутыг тусгаж өгдөг ч хот хооронд зорчигч тээвэрлэгч аж ахуйн нэгжийн удирдлага, жолооч нар гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлдэггүй, төрийн бодлогыг үл тоомсорлон өөрсдийн ашиг сонирхол, лоббигоор дулаан, халаалтгүй, зөөврийн устай, боловсон ариун цэврийн өрөөгүй зэрэг эрүүл ахуйн наад захын шаардлага хангаагүй газраас зорчигчдод үйлчилгээ авсаар байна. Гэрээний үүргээ олон жил биелүүлээгүй хот хооронд зорчигч тээвэрлэгч аж ахуйн нэгжүүдэд ямар ч хариуцлага тооцдоггүй, хяналт, зохицуулалт сул байгаагаас төрийн бодлого өнөөдрийг хүртэл хэрэгжихгүй байна.

Хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулж буй авто зам дагуух үйлчилгээний байгууламжууд барьсан аж ахуйн нэгжүүдтэй "Хамтран ажиллах гэрээ"-г байгуулж, хот хоорондын нийтийн тээврээр үйлчлүүлж буй зорчигчдыг эрүүл ахуй, стандартын шаардлага хангасан үйлчилгээ авах боломжийг бүрдүүлж, гэрээний хэрэгжилтийг хангуулахад анхаарч дотоод хяналтаа сайжруулах шаардлагатай байна.

Байгаль орчин, аялал, жуулчлалын сайдын 2017 оны А/107 дугаар тушаалаар баталсан "Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тус салбараас толгойлон хэрэгжүүлэх 25, бусад яамд, байгууллагатай хамтран хэрэгжүүлэх 12, нийт 37 арга хэмжээ тусгагдсаныг 2022 оны жилийн эцсийн байдлаар үнэлж үзэхэд хэрэгжилтийн дундаж 56.3 хувьтай үнэлэгдсэн. Иймээс тус хөтөлбөрт автотээврийн салбарын чиглэлээр тусгагдсан арга хэмжээг 2023 оны төлөвлөгөөнд тусгаж хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байна.

"Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ"-г хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний зорилтот түвшинг томьёолохдоо чанар, үр дүнд суурилсан оновчтой төлөвлөлт хийхгүй байна. Тухайлбал:

-Албан хаагчдын мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх гэсэн арга хэмжээний зорилтот түвшинг сургалт зохион байгуулсан болон сургалтад хамрагдсан ажилтны тоо гэж томьёолсон байна. 2023 оны төлөвлөгөөнд нийт албан хаагчид (Автотээврийн салбарын инженер, техникийн болон мэргэжилтэй ажилтныг мэргэшүүлэх гэх мэт)-ын хэдэн хувийг сургалтад хамруулах, сургалтад

хамрагдсанаар шаардлагатай мэргэжлийн хүний нөөц бэлтгэгдэх эсэх, гарах үр дүнгийн талаар төлөвлөх нь зүйтэй.

-Улс, хот хоорондын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгчийг сонгон гэрээ байгуулан батлагдсан тээвэрлэлтийн чиглэл, үйлчилгээний давтамж, цагийн хуваарийн дагуу үйлчилгээг зохион байгуулах гэсэн арга хэмжээний зорилтот түвшинг батлагдсан зарим чиглэлүүдэд үйлчилгээг эхлүүлсэн байна гэж томьёолжээ. Зорчигчийн урсгал, хүн амын өсөлт, дэд бүтэц, зорчин явалтын эрэлт, хэрэгцээ, тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжийн чадамж (стандартын шаардлага хангаж буй автобусны тоо, матераиллаг баазаар хангагдсан гэх мэт) -д дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан төлөвлөлт хийх шаардлагатай.

-Жуулчин тээврийн үйлчилгээг Төрийн үйлчилгээний нэгдсэн портал /www.e-mongolia.mn/-аар дамжуулан зохион байгуулах гэсэн 1 арга хэмжээ төлөвлөсөн нь хангалтгүй байна. Цаашид томоохон боомт болон аялал жуулчлалын бүсүүдийг түшиглэн жуулчин тээврийн үйлчилгээг хөгжүүлэх, олон улсын аялал жуулчлалын сүлжээнд холбох, улс, хот хооронд, жуулчин тээврийн VIP үйлчилгээг нэвтрүүлэх чиглэлээр төлөвлөж жуулчин тээвэрлэлтийн үйлчилгээг сайжруулахад анхаарлаа хандуулах нь нэн чухал байна.

-Мэргэшсэн жолоочийн үнэмлэх олгосон тоогоор бус мэргэшсэн жолоочийн сургалт зохион байгуулах, шалгалт авах үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэх, сургалтын тогтолцоог сайжруулах талаар тодорхой ажил зохион байгуулах шаардлагатай байна.

-Олон улс, улсын чанартай авто замаар ачаа тээвэрлэлт хийж буй тээврийн хэрэгсэл стандартын шаардлага хангаж байгаа эсэхэд тавих хяналтыг сайжруулах хүрээнд ачаа тээврийн тэдэн тээврийн хэрэгслийг шалгаж төчнөөн төгрөгийн торгууль ногдуулж, төлөвлөгөөний хэрэгжилт хангагдсан болно гэж тайлагнаж байгаа нь учир дутагдалтай. Зөрчил дутагдал гаргасан тээврийн хэрэгслийн жолоочийг торгохдоо гол нь биш, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, зөрчлийг бууруулах, арилгахад чиглэсэн ямар ажил зохион байгуулах шаардлагатай байгаа талаар судалгаа, дүн шинжилгээ хийж (холбогдох дүрэм, журамд өөрчлөлт оруулах, тээврийн хэрэгслүүдийг шинэчлэх, замаа сайжруулах гэх мэт) санаачлагатай ажиллах шаардлагатай.

-Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд улсын чанартай авто замын дагуу 150-200 км тутамд үйлчилгээний цогцолбор байгуулах гэсэн арга хэмжээний зорилтот түвшинг үйлчилгээний цогцолбор байгуулсан байна гэж томьёолсон оновчгүй. Хувийн хэвшлийнхэн өөрсдийн хөрөнгөөр авто замын дагуу үйлчилгээний цогцолбор барьж байгуулсаар ирсэн.

Харин ашиглалтад орсных нь дараа төрөөс үйл ажиллагаанд нь ямар дэмжлэг үзүүлж яаж хамтарч ажиллах талаар төлөвлөх нь зүйтэй.

Аймгуудын Засаг дарга нартай байгуулсан гэрээг дүгнэхдээ сайдтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-нд автотээврийн чиглэлээр хичнээн арга хэмжээ тусгаж хэрэгжилтийг хэрхэн хангасантай уялдуулж дүгнэх талаар өмнө нь зөвлөж байсан ч энэ талаар огт тайлагнаагүй.

-Улс, хот хоорондын зорчигч тээврийн жолооч нарт зориулсан мэдвэл зохих хууль, дүрэм, журам болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах талаар гарын авлага боловсруулах гэсэн арга хэмжээний зорилтот түвшинг улс, хот хоорондын зорчигч тээврийн жолооч нар гарын авлагаар хангагдсан байна гэсэн байна. Жолооч нар гарын авлагаар хангагдсанаар замын хөдөлгөөний дүрэм зөрчих болон осол зөрчил төчнөөн хувиар буурна гэж томьёолсон бол илүү оновчтой байсан.

Зам, тээврийн хөгжлийн сайдын шуурхай хуралдаанаас 2022 онд "АТҮТ" ТӨҮГ-т давхардсан тоогоор нийт 56 үүрэг даалгавар өгсөн ба бүрэн биелээгүй 4 үүрэг даалгавар хяналтад байна. Үүнд:

1.Засгийн газрын 100 хоногт багтаан “АТҮТ” ТӨҮГ-ын үйлчилгээг бүрэн цахимжуулах, ажлын явцыг танилцуулж, үр дүн гаргах.

2.Автотээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл хийх бэлтгэл ажлыг хангах, нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, орон даяар эхлүүлэх ажлыг зохион байгуулах, уг асуудлаар олон нийтэд мэдээлэх, ТЗУГ-аас хяналт тавих.

3.Олон Улсын тээвэрлэлтийн “С” төрлийн зөвшөөрлийг И-Монголиа системд оруулах ажлыг зохион байгуулж, үр дүнг танилцуулах.

4.Өмнөговь аймгийн Тавантолгойн уурхайгаас Чойр, Мааньт, Олон-Овоот өртөө чиглэлд нүүрсний тээвэрлэлтийг бүрэн зогсоох, эдгээр өртөөдөд автотээврийн хэрэгслээр нүүрс нэмэлтээр татаж авахгүй байх, Дорноговь аймгийн Замын-Үүд чиглэлд даац хэтрүүлэн нүүрсний тээвэрлэлт хийхийг бүрэн зогсоох талаар ажлын хэсэг байгуулж, зохион байгуулалтын арга хэмжээ авч, танилцуулах.

Монгол Улсын Засгийн газрын 11-11 төвд автотээвэртэй холбоотой 245 санал, хүсэлт, гомдол ирсэнд цаг хугацаанд нь хариу өгсөн ба өргөдөл гомдлын шийдвэрлэлт 100%-тай байна.

Зам, тээврийн хөгжлийн яамнаас тус үйлдвэрийн газарт 2022 онд нийт 262 албан бичиг хүргүүлснээс хариутай 193 албан бичиг байгаа ба 180 албан бичгийн хариуг хугацаанд нь ирүүлсэн, 13 албан бичиг шийдвэрлэх шатанд байна. "АТҮТ" ТӨҮГ-аас 2022 онд тус яаманд 247 албан бичиг ирүүлсэн байна.

Тус газраас 2022 онд хийж хэрэгжүүлсэн томоохон ажлуудаас дурдвал:

1. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны А/207 дугаар тушаалаар баталсан "Тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын дуудлага худалдааг зохион байгуулах журам"-ын дагуу тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн 10 серийн 4576 улсын дугаарын дуудлага худалдааг амжилттай зохион байгуулж, 1895 дугаарыг 7,8 тэрбум төгрөгөөр борлуулж, орлогыг "Хүүхдийн төлөө сан"-д төвлөрүүлсэн байна.

2."Алсын хараа 2050", "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төрөөс үзүүлэх үйлчилгээг цахимжуулах ажлын хүрээнд авто тээврийн олон үйлчилгээг үе шаттайгаар цахимжуулж байгааг дурдах нь зүйтэй. Үүнд:

-Нотариатчдын танхимтай хамтран нотариатын серверийг бүртгэлийн програмтай холбон үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.

-Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тээврийн хэрэгсэл бүртгүүлэх хүсэлтийг тоон гарын үсгээр баталгаажуулан цахимаар авах боломжийг бүрдүүлсэн.

-Хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын тээвэрлэлтийн гэрээ дүгнэх, албан хүсэлт авах, шийдвэрлэх үйл ажиллагааг цахимжуулан Тээврийн нэгдсэн системийг нэвтрүүлсэн.

-Дотоодын ачаа тээврийн logistic.transdep.mn сайтын гар утасны аппликейшнийг андройд гар утсанд зориулагдсан хувилбарыг гаргасан.

-Улс болон хот хоорондын зорчигч тээвэрлэлтийн тасалбар борлуулалтыг сайжруулах чиглэлээр төр болон хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд TAPATRIP гар утасны аппликэйшн-ээр дамжуулан тасалбар борлуулалтыг нэмэгдүүлэн ажиллаж байгаа бөгөөд цаашид автотээврийн хэрэгслийн гэрчилгээ, мэргэшсэн жолоочийн үнэмлэхийг цахим болгохоор бэлтгэл ажлыг хангаж байна.

3. Автотээврийн нэгдсэн лавлах "1900-1-2-3-4" тусгай дугаарын үйлчилгээ нь 24 цагаар ажиллаж 651.886 дуудлага хүлээн авсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 31.7% хувиар өссөн үзүүлэлттэй байна.

4. Салбарын хэмжээнд ашиглагдаж байгаа хэмжих хэрэгсэлд Олон улсын нэгжийн СИ системийн дагуу нэгж дамжуулах зорилгоор техникийн хяналтын төвүүдийн 328 багаж, 12 аж ахуй нэгж байгууллагын 58 багажид шалгалт тохируулга хийсэн байна.

5. MNS ISO 17020:2013 стандартын дагуу чанарын удирдлагын тогтолцоог Автотээврийн үндэсний төвийн 25 техникийн хяналтын үзлэгийн төвд нэвтрүүлсэн. Цаашид хууль эрх зүйн орчинг сайжруулах, инженер техникийн ажилтнуудыг мэргэшүүлэх, байр талбай, техникийн хяналтын үзлэгийн төвийн тоног төхөөрөмжийг үе шаттайгаар шинэчлэх зорилгоор KOIKA олон улсын байгууллагатай хамтран ажиллахаар болсон байна.

**Тав. Санал, зөвлөмж**

1."Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх 2023 оны гэрээ"-г цаг хугацаанд нь байгуулах, гэрээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулах;

2."Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ"-г хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан, бүрэн хэрэгжээгүй арга хэмжээг 2023 оны төлөвлөгөөнд тусгах, арга хэмжээний зорилтот түвшин (хүрэх түвшин)-г томьёолохдоо нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөө, гарах үр дүнг тооцож зөв төлөвлөх;

3."Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд автотээврийн чиглэлээр тусгагдсан ажлуудыг 2023 онд эрчимжүүлэхэд анхаарах;

4.Зорчигч урсгалын хэтийн төлөв, дэд бүтэц, хүн амын өсөлт, зорчин явалтын эрэлт хэрэгцээ, үүсч болох эрсдэлт хүчин зүйлүүдийг тооцох замаар тээвэрлэлтийн үр ашгийг тооцон тээврийн төлөвлөлтийг хийж, тээвэрлэлтийн чиглэл, үйлчилгээний давтамж, цагийн хуваарийг өөрчлөх эсэх талаар санал боловсруулж танилцуулах;

5.Нийтийн мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг тайлагнах шалгуур үзүүлэлтийн дагуу холбогдох мэдээллийг тухай бүр байгууллагын сайт дээрээ ил тод, бүрэн гүйцэд байршуулах, хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах хүрээнд "Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам" болон "Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам"-ыг 2023 онд боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах;

6.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд улсын чанартай авто замын дагуу үйлчилгээний цогцолбор байгуулсан аж ахуйн нэгж болон хот хоорондын нийтийн тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжтэй гурвалсан "Хамтран ажиллах гэрээ" байгуулж, зорчигчдыг зөвхөн стандартын шаардлага хангасан гэрээтэй байгууламжаар үйлчлүүлэх боломжоор хангах, жолоочийн хөдөлмөр амралтын горимыг сахиулах, гэрээний хэрэгжилтэд тавих дотоод хяналтаа сайжруулах, төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд анхаарах;

7. Жуулчин тээврийн үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр тодорхой ажлууд төлөвлөж, хэрэгжилтийг зохион байгуулах;

8. Аймгуудын Засаг дарга нартай 2023 онд байгуулах гэрээг сайдтай 2023 онд байгуулах "Хамтран ажиллах гэрээ"-тэй уялдуулах талаар яамтай хамтран ажиллах;

9. Зам, тээврийн хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын зам, тээврийн салбарт 2021-2024 онд хамтран ажиллахаар байгуулсан "Санамж бичиг"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан хэрэгжилт хангалтгүй 2 арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх;

10. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн дүгнэлт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг зөвлөж байна.

Тус газрын 2022 оны "Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ"-г хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг 2022 оны жилийн эцсийн байдлаар ирүүлснийг хавсаргав.

**ТАНИЛЦСАН:**

САЙД С.БЯМБАЦОГТ

ДЭД САЙД Л.ХАЛТАР

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА С.БАТБОЛД

“АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ”
ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ Б. ГҮРСОРОНЗОН

АВТОТЭЭВРИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ
ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ДАРГА Ё.ЖАРГАЛСАЙХАН

**ХЯНАСАН:**

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА А.МӨНХБАТ

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:**

АВТОТЭЭВРИЙН САЛБАРЫН БОДЛОГО,
ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙН ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ О.НЯМХҮҮ

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНААС “АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨҮГ-ТАЙ БАЙГУУЛСАН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭГ ХАРИУЦУУЛАН ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ГЭРЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2022.12.14 Улаанбаатар хот

| Гэрээнд заасан чиглэлүүд | | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Төсөв /сая.төг/ | Хариуцах нэгж | Биелэлт | ХШҮ |
|---|---|---|---|---|---|---|
| № | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 1.1 | Автотээврийн салбарын хууль, тогтоомж, дүрэм, журам, стандарт, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, үүрэг даалгавар, хөгжлийн бодлогын баримт бичиг, төлөвлөгөө, төсөл, хөтөлбөр болон салбарын сайдаас гаргасан тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг хангах; | 1.1.1 Дээд газрын тогтоол шийдвэр, салбарын яамнаас гаргасан тушаал, шийдвэр, яамны удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, тайлагнах<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Үүрэг даалгаврын хэрэгжилт 90-ээс дээш хувь хангагдсан байна.** | - | ЗСХНХ АЛБА, ТӨВ, ХЭЛТЭС | Монгол улсын хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл, албан даалгавраар тус үйлдвэрийн газар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг 2022 оны 1-р улирлын байдлаар гаргаж, 2022.03.22-ний өдрийн 1/365, эхний хагас жилийн байдлаар 2022.06.07-ний өдрийн 1/772, 3-р улирлын байдлаар 2022.09.22-ний өдрийн 1/119, жилийн эцсийн байдлаар 2022.12.09-ний өдрийн 1/1556 тоот албан бичгээр тус тус хүргүүлж, тайлагнасан.<br>ЗТХЯ-ны ХШҮДАГ-аас 2022 оны 3-р улирлын байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр 5 заалт хяналтад байгаагаас 100% хэрэгжсэн 3, 70%-1, 30%-1 ажил үнэлгээний дунджаар 80%-тай байна.<br>Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар тус үйлдвэрийн газарт өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг гаргаж, 2022 оны 1-р улирлын байдлаар 2022.03.24-ны өдрийн 1/380, эхний хагас жилийн байдлаар 2022.06.08-ний өдрийн 1/781, 3-р улирлын байдлаар 2022.09.23-ны өдрийн 1/1205, жилийн эцсийн байдлаар 2022.12.09-ний өдрийн 1/1555 тоот албан бичгээр ЗТХЯ-ны ХШҮДАГ-т тус тус хүргүүлж тайлагнасан.<br>ЗТХЯ-ны ХШҮДАГ-аас 2022.09.28-ний өдрийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр 72 заалт хяналтад байгаагаас 100% хэрэгжсэн 40, 70%-20, 30%-7, хугацаа болоогүй-4, хүчингүй болсон-1 ажил, үнэлгээний дунджаар 83,7%-тай дүгнэсэн байна. | 90 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөлийн хуралдаанаас тус үйлдвэрийн газарт өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг 2022 оны 1-р улирлын байдлаар 2022.03.28-ны өдрийн 1/394, эхний хагас жилийн байдлаар 2022.06.15-ний өдрийн 1/807, 3-р улирлын байдлаар 2022.09.22-ний өдрийн 1/1198 тоот албан бичгээр ЗТХЯ-ны ХШҮДАГ-т хүргүүлж, хэрэгжилт, үр дүнг тайлагнасан. ЗТХЯ-ны Сайдын зөвлөлийн 3 удаагийн хуралдаанаас тус үйлдвэрийн газарт өгсөн 4 үүрэг хяналтад байсан бөгөөд ХШҮДАГ-аас 2022 оны 1-р улиралд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр 3 үүргийг 100% хэрэгжсэнд тооцож, хяналтаас хассан бөгөөд 1 үүрэг даалгавар 70%-ийн хэрэгжилттэй байна.<br>Сайдын зөвлөлийн хуралдаанаас өгсөн үүргийн хэрэгжилт 2022 оны жилийн эцсийн байдлаар дунджаар 70,%-тай байна. Дээрх үүрэг даалгавруудын хэрэгжилт 2022 оны 3-р улирлын байдлаар 77,9 хувийн хэрэгжилттэй байна. Жилийн эцсийн байдлаар үнэлгээ гараагүй байгаа. | |
| | | 1.1.2 “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-т тусгагдсан Автотээврийн үндэсний төвөөс хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, улирал бүр яаманд тайлагнах<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**2022 оны зорилтот ажлуудын биелэлт 90-ээс доошгүй хувь хангагдсан байна.** | - | ЗСХНХ | “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээний төлөвлөгөө”-ний биелэлтийг нэгтгэн гаргаж, ЗТХЯ-нд 2022 оны 1-р улирлын байдлаар 2022.03.24-ны өдрийн 1/379, эхний хагас жилийн байдлаар 2022.06.13-ний өдрийн 1/791, 3-р улирлын байдлаар гарган 2022.09.23-ны өдрийн 1/1204, жилийн эцсийн байдлаар 2022.12.09-ны өдрийн 1/1554 тоот албан бичгээр хүргүүлж, хэрэгжилт, үр дүнг тайлагнасан.<br>Тус хөтөлбөрт үйлдвэрийн газраас хэрэгжүүлэхээр нийт 14 ажил хяналтад байгаагаас бүрэн хэрэгжсэн 100%-5, 70%-тай 6, 30%-тай 3 ажил байна. Дунджаар 72,3 хувийн хэрэгжилттэй байна. | 70 |
| | | 1.1.3 Зам, тээврийн хөгжлийн сайдын албан даалгавруудыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, улирал бүр яаманд тайлагнах<br>**Шалгуур үзүүлэлт:** | | ЗСХНХ | Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 01 дүгээр албан даалгавраар тус үйлдвэрийн газарт өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг 2022 оны эхний хагас жилийн байдлаар гаргаж, ЗТХЯ-ны ХШҮДАГ-т 2022.06.13-ны өдрийн 1/797 тоот албан бичгээр хүргүүлж, тайлагнасан. Мөн сайдын 2020 оны А/125, 2021 оны 02 дугаар албан | 90 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Үүрэг даалгаврын хэрэгжилт 90-ээс доошгүй хувь хангагдсан байна.** | | | даалгаврын хэрэгжилтийг гаргаж, ЗТХЯ-ны ХШҮДАГ-т 2022.06.13-ний өдрийн 1/798 тоот албан бичгээр хүргүүлж, хэрэгжилт, үр дүнг тайлагнасан.<br>Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021.09.15-ны өдрийн 07 дугаар албан даалгавраар тус үйлдвэрийн газарт өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг 2022 оны 1-р улирлын байдлаар гаргаж, ЗТХЯ-ны ХШҮДАГ-т 2022.03.22-ны өдрийн 1/366, 2022.06.13-ний өдрийн 1/798 тоот албан бичгээр тус тус хүргүүлж, тайлагнасан.<br>ЗТХЯ-ны ХШҮДАГ-ын 2022 оны эхний хагаж жилийн үнэлгээгээр Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 01, А/125, 2021 оны 02, 07 дугаар албан даалгавраар тус газарт нийт 64 үүрэг даалгавар өгөгдсөнөөс "бүрэн хэрэгжсэн" буюу 100%-тай 40,хэрэгжих шатанд буюу 70%-ийн хэрэгжилттэй 21, "хэрэгжилт хангалтгүй" буюу 30%-тай 3 арга хэмжээ байгаа ба Сайдын 4 албан даалгаврын хэрэгжилтийн дундаж 92,7%-тай зорилтот түвшиндээ хүрсэн байна. | |
| | | 1.1.4 Зам, тээврийн хөгжлийн сайдын "Зорчигч тээврийн үйлчилгээг сайжруулах тухай" 2020.10.22 №А/200 тушаалын хэрэгжилтийг бүрэн хангуулж тайлагнах<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Сайдын тушаалын хэрэгжилтийн хувь<br>**Хугацаа:**<br>I-II улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Тушаал хэрэгжсэн байна.** | | ЗТХ<br>ХУХ | **ЗТХ:** Зам, тээврийн хөгжлийн сайдын "Зорчигч тээврийн үйлчилгээг сайжруулах тухай" 2020.10.22 №А/200 тушаалд зорчигч тээвэртэй холбоотой 2 заалт тусгагдсан.<br>**Тушаалын 1.1-д** "Хот хоорондын нийтийн тээвэрлэлтийн дундын зогсолтын тарифыг тогтоон мэдээллийн санд оруулах, орон нутгийн зорчигч тээврийн тасалбарыг цахимжуулах, кассын машинаар хэвлэх, НӨАТ-ын баримт олгох ажлыг 2020.12.25 өдрийн дотор зохион байгуулах" гэж заасны дагуу үйлчилгээ үзүүлж буй 54 чиглэлийн дундын зогсоолын тарифуудыг тогтоон Зорчигч тээврийн бүртгэлийн системд бүрэн оруулж мэдээллийн санг үүсгэсэн. Мөн орон нутгийн нийтийн тээвэрлэлтийг зохион байгуулах, гүйцэтгэх гэрээ байгуулсан 55 чиглэлийг зорчигч тээврийн бүртгэлийн системд оруулан орон нутгийн зорчих тасалбарыг цахимжуулан кассын машинаар хэвлэж НӨАТ-ын баримт олгон ажиллаж байна.<br>**Тушаалын 1.2-т** "Нийтийн тээврийн үйлчилгээнд ашиглаж байгаа их багтаамжийн автобусыг холбогдох стандарт болон замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлага хангаж буй эсэхэд хяналт тавих, тухайн тээврийн хэрэгслийн жолоочийн хажууд нэмэлт суудал суурилуулахыг зогсоох" гэж заасны дагуу улс, хот | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хоорондын зорчигч тээврийн автобусны жолоочийн хажуугийн нэмэгдэл суудлыг зориулалтын дагуу ашиглахгүй зорчигч суулгаж байгаа тул ААНБ -уудад тус суудлыг авах талаар АТХУБ-ийн албан шаардлагыг хүргүүлэн, жолоочийн хажуугийн нэмэгдэл суудлыг бүрэн авахуулсан.<br>**Тушаалын 1.3-т** “Улс хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээний зорчигчдын ачаа тээш илгээмжийг хүлээн авах, хадгалах, тээвэрлэх, хүлээлгэн өгөх үйл ажиллагааг хяналт, бүртгэлд оруулан тасалбар олгох зохицуулалтыг 2020.12.25-ны өдрийн дотор зохион байгуулах гэж заасны дагуу Улсын онцгой комиссын 2021.05.19-ны өдрийн 46 дугаар тушаал, ЗТХЯ-ны 2021.05.20-ны өдрийн 07/2182 тоот албан бичгээр хот хоорондын нийтийн тээврийн хөдөлгөөнийг эхлэх болсонтой холбогдуулан 2021.05.23-ны өдрөөс эхлэн илгээмжийн ачааг хүлээн авах, түр хадгалах, бүртгэлжүүлэх ажил хийгдэж эхэлсэн. Ачаа тээшийг бүртгэлжүүлэх, түр хадгалах зорилгоор тус үйлдвэрийн газрын дотоод сүлжээнд /ERP/ суурилсан ачаа тээшний бүртгэлийн цэсийг хөгжүүлэх ажил хийгдсэн. Дээрх ажлын хүрээнд ачаа тээш хариуцан ажиллах 21 аймгийн бүх тээвэр зохицуулагч, тээврийн мэргэжилтэн нарт ачаа тээш бүргэлжүүлэх эрх нээсэн. 2022 оны жилийн эцсийн байдлаар Улаанбаатар хотын 2, орон нутгийн 17 автобуудалтай салбар төвөөс 7 аймгийн автобуудлаар дамжуулан илгээмжийн ачаа тээшийг хүлээн авах, бүртгэлжүүлэх, түр хадгалах, хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.<br>**Тушаалын 1.4-т** “Осол зөрчлийн талаарх мэдээллийг шуурхай дамжуулж ажиллах тухай” Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 30 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах, мэдээллийг шуурхай дамжуулах арга хэмжээ авч ажиллаагүй албан хаагчдад тухай бүр хариуцлага тооцох гэж заасны дагуу мэдээ, мэдээллийг цаг тухай бүрт нь шуурхай дамжуулж ажиллаж байна.<br>Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018.10.29-ний өдрийн 235 дугаар тушаалаар батлагдсан “Гамшиг, осол, зөрчил, саатлыг мэдээлэх схем”-ийн дагуу мэдээллийг шуурхай дамжуулан ажиллаж байгаа бөгөөд дээрх тушаал гарснаар 2016 оны 30 дугаар тушаал нь хүчингүй болсон. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2022.01.01-2022.12.05-ны өдрүүдэд нийт 55,340 тээврийн хэрэгслээр 1,276,521 зорчигч тээвэрлэсэн бөгөөд тээврийн хэрэгслийг 24 цагийн турш хянаж, шуурхай зохицуулалтаар хангаж ажилласан. Тус хугацаанд 363 удаагийн саатал, 20 удаагийн /14 нь шүргэлцэх төрлийн осол/ осолд холбогдсон тохиолдол бүртгэгдсэн. Улс хоорондын байнгын ачаа тээврийн үйлчилгээнд гарсан 36 ослын мэдээллийг бүртгэл хөтлөн холбогдох байгууллагуудад шуурхай мэдээлэн ажилласан.<br>**Тушаалын 1.5-д** "Холбогдох стандартын шаардлага хангасан авто замын дагуух үйлчилгээний байгууламжтай ААН-тэй гэрээ байгуулж ажиллах, сум суурин газарт зорчигчдыг буулгах, суулгах цэг/автобуудал/-ыг тодорхой болгож хяналт тавьж ажиллах, зөрчил гаргаж байгаа үйлчилгээ эрхлэгчдэд хариуцлага тооцох" гэж заасны дагуу стандартын шаардлага хангасан 1 аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд 7 хоног бүр мэдээ мэдээлэл солилцон хяналт шалгалтыг улирал тутам зохион байгуулан ажиллаж байна. Гэрээ байгуулах хүсэлт гаргасан 2 аж ахуйн нэгж байгууллагад зөвлөмж хүргүүлээд байна.<br>"Нутаг Ус" цогцолбор нь 2022.07.15-ний өдрөөс үйл ажиллагаагаа эхлүүлэн "УБ хот – Ув.Улаангом сум", "УБ хот – Ув.Өмнөговь сум", "УБ хот – Ув.Зүүнговь сум", "УБ хот – Ув.Өндөрхангай сум" 4 чиглэлийн 4 аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж байна.<br>Гэрээ байгуулах хүсэлт гаргасан 1 аж ахуйн нэгж байгууллагад зөвлөмж хүргүүлсэн бөгөөд тушаалын хэрэгжилт 100% хэрэгжсэн болно. | |
| | | 1.1.5 Зам, тээврийн хөгжлийн сайдын "Хот хоорондын зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай" 2021.04.27 №А/63 дугаар тушаалын хэрэгжилтийг бүрэн хангуулж тайлагнах<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Сайдын тушаалын хэрэгжилтийн хувь<br>**Хугацаа:** | | ЗТХ<br>ХУХ<br>ЗСХНХ | **ЗТХ:** Зам, тээврийн хөгжлийн сайдын "Зорчигч тээврийн үйлчилгээг сайжруулах тухай" 2020.10.22 оны А/63 дугаар тушаалд зорчигч тээвэртэй холбоотой 6 заалт тусгагдсан. Хот хоорондын нийтийн тээвэрлэлтийг зохион байгуулах, гүйцэтгэх гэрээний шинэчилсэн төсөл, хот хоорондын нийтийн тээврийн үнэ, тасалбар борлуулалт болон үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр хийж хэрэгжүүлэхээр тусгагдсан 6 заалт бүрэн хэрэгжсэн. /Тайланг хавсаргав/<br>**ХУХ:** Зам, тээврийн хөгжлийн сайдын "Зорчигч тээврийн үйлчилгээг сайжруулах тухай" 2020.10.22 оны А/63 дугаар тушаалд хөдөлгөөний хяналттай холбоотой 3 заалт | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | I-II улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Тушаал хэрэгжсэн байна.** | | | тусгагдсан. Нийтийн тээврийн үйлчилгээнд оролцож буй тээврийн хэрэгслүүдэд автотээврийн хяналтын улсын байцаагч нар холбогдох стандарт болон замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлага хангаж буй эсэхэд дүгнэлт гарган тогтмол хяналт шалгалт хийж, цар тахлын үед зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, жолооч нарын хөдөлмөр амралтын горимыг баримталсан эсэхэд хяналт шалгалт хийх чиглэлээр тусгагдсан ажлуудыг бүрэн хэрэгжүүлсэн болно. /Тайланг хавсаргав/ | |
| | | 1.1.6 Үйлдвэрийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийх<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Үйлдвэрийн газрын нийт салбар, төвүүдэд санхүүгийн аудит хийгдсэн байх<br>**Хугацаа:**<br>II-III улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Захирлын зөвлөлд тайлагнаж, холбогдох нэгжид зөвлөмж хүргүүлсэн байна.** | - | ХШДАА | Хяналт-шинжилгээ, дотоод аудитын албаны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.1.3, 1.1.4 дэх заалт, дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөний 1.3, 1.6 дахь заалтуудыг үндэслэн дараах нэгжүүдийн санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийгдсэн. Үүнд:<br>• Зорчигч тээврийн хэлтсийн Мэргэшсэн жолоочийн тасагт 2022.03.23-наас 2022.04.01-ний өдрүүдэд,<br>• Сонгинохайрхан зорчигч тээврийн төвд 2022.05.03-05-ны өдрүүдэд,<br>• Сонгинохайрхан техникийн хяналтын үзлэгийн төвд 2022.06.06-08-ний өдрүүдэд санхүүгийн аудит хийж холбогдох зөвлөмжүүдийг хугацаатай өгч ажиллаж байна.<br>• Захиргаа, сургалт, хүний нөөцийн хэлтсийн Худалдан авах үйл ажиллагаанд 2022.06.27-2022.07.05-ний өдрүүдэд<br>• Баянзүрх техникийн хяналтын үзлэгийн төвд 2022.10.10-12-ний өдрүүдэд<br>Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус санхүүгийн аудитыг гүйцэтгэхэд НББ-ийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог үндэслэл болно." заалтыг мөрдөн ажиллах, Нягтлан бодогч, нярав нарын хоорондын ажлын уялда<br>аг сайжруулах, санхүүгийн анхан шатны баримт, агуулахын бүртгэл хөтлөлтөд анхаарах, үнэт цаасыг дугаарын дагуу тухай бүр нь хяналт тавьж гарын үсэг зурж байх, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн | 30 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна." гэсэн заалтуудыг мөрдөж ажилладаггүй зэрэг нийтлэг алдаа дутагдлууд гарч нийт-14 зөвлөмж өгч алдаа дутагдлаа сайжруулан ажиллахыг зөвлөн ажиллалаа | |
| | | 1.1.7 Байгууллагын дотоод хяналтыг Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "ААНБ-ын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын хүрээнд нийцүүлэн төрийн өмчийн ашиглалт, захиран зарцуулалтын байдалд дотоод хяналт шалгалтыг үр дүнтэй зохион байгуулж, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Төлөвлөгөөнд тусгагдсан ажил 90-ээс дээш хувь биелсэн байна.** | - | ХШДАА | 2022.01.05-ны өдөр Үйлдвэрийн газрын "2022 оны дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө"-г батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2022 онд үйлдвэрийн газрын захирлын баталсан удирдамжийн хүрээнд дараахь хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:<br>• 2022.03.23-ны өдрөөс 2022.04.01-ний өдрүүдэд Мэргэшсэн жолоочийн сургалтын тасагт<br>• 2022.05.03-05-ны өдрүүдэд Сонгинохайрхан зорчигч тээврийн төвд<br>• 2022.06.06-08-ны өдрүүдэд Сонгинохайрхан техникийн хяналтын үзлэгийн төвд<br>• Үйлдвэрийн газрын ЗСХНХ-ийн Худалдан авах үйл ажиллагаанд 2022.06.27-2022.07.05-ний өдрүүдэд<br>• Замын үүд салбарт 2022.08.11-14-ний өдрүүдэд,<br>• Баянзүрх техникийн хяналтын үзлэгийн төвд 2022.10.10-12-ний өдрүүдэд<br>Дээрх салбар, нэгжүүдэд нийт 51 зөвлөмж хүргүүлж ажилласан. 2022.12.10-ны байдлаар "Хөдөлмөрийн дотоод журам" зөрчсөн албан тушаал /ажлын байр/-ны тодорхойлолтын холбогдох заалтуудыг биелүүлээгүй 21 албан тушаалтныг сахилгын шийтгэл ногдуулах тухай санал дүгнэлтийг ЗСХНХ-т хүргүүлсэн.<br>Мөн дотоод хяналт шалгалтын хүрээний 36 өргөдөл гомдол ирснийг холбогдох журмын хүрээнд хяналт шалгалт хийж, хариуг тухай бүр хүргүүлэн ажиллалаа.<br>Мөн инженер, техникийн ажилтнууд болон бүртгэлийн ажилтнуудын ажлын байранд шалгалт хийж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөөг өгч ажилласан. | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2022 оны Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөнд нийт 10 ажил тусгагдсанаас 2022.12.10-ны байдлаар 70%-тай хэрэгжиж байна. | |
| 1.2 | Мэргэжлийн хүний нөөцийг бүрдүүлэн ажиллах ба инженер техникийн болон тээвэр зохион байгуулалт хариуцсан ажилтнуудыг хөгжүүлэх, чадавхжуулах чиглэлээр холбогдох сургалтыг байгууллагынхаа хэмжээнд тогтмол зохион байгуулах, тээвэрлэлттэй холбоотой хууль эрх зүйн болон техникийн талаарх мэдээллийг тогтмол хүргэж байх | 1.2.1 Албан тушаалын тодорхойлолтод тавигдсан шаардлагад нийцсэн мэргэжлийн хүний нөөцийг бүрдүүлэх<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Мэргэжлийн шаардлагад нийцсэн хүнийг томилсон тоо<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Ажлын байрны мэргэжлийн шаардлагад нийцсэн хүнийг томилсон байна.** | - | ЗСХНХ | ТӨБЗГ-ын 2022.11.22-ны өдрийн 510 дугаар тогтоолоор "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн баталсан. Үүнд:<br>Захирал-1, 1 алба, 8 хэлтэс, 4 тасаг, Улаанбаатар хот дахь Судалгаа, хөгжил, чанарын удирдлагын 1 төв, техникийн хяналтын үзлэгийн 3 төв, зорчигч тээврийн 2 төв, аймгийн автотээврийн 21 төв, Замын-Үүд, Цогтцэций салбар болно. Орон тооны дээд хязгаарыг 775 ажилтан, албан хаагчтай байхаар тогтоосон.<br>2022.12.10-ны өдрийн байдлаар 1 алба, 8 хэлтэс, 4 тасаг, 285 орон тоо баталсанаас 254 албан хаагч, Улаанбаатар хот дахь Судалгаа, хөгжил, чанарын удирдлагын төв, зорчигч тээврийн 2 төв, техникийн хяналтын үзлэгийн 3 төвд 187 орон тоо баталсанаас 175 албан хаагч, аймгийн автотээврийн 21 төв, Замын-Үүд, Цогтцэций салбарт нийт 320 орон тоо баталсанаас 308 ажилтан, албан хаагч тус тус томилогдон, үйлдвэрийн газарт нийт 737 албан хаагч ажиллаж байгаагаас албан тушаалын тодорхойлолтод тавигдсан шаардлагад нийцсэн 63 мэргэжлийн ажилтанг үндсэн ажилтнаар томилсон. Үүнд:<br>Ахлах нягтлан бодогч 6,<br>Бүртгэлийн мэргэжилтэн 1,<br>Төвийн дарга 7,<br>Лавлах үйлчилгээний мэргэжилтэн 4<br>Мэргэжилтэн 6,<br>Нягтлан бодогч 1,<br>Нярав 2,<br>Сахиул 3,<br>Тасалбар түгээгч 5,<br>Техникийн хяалтын үзлэгийн инженер 5,<br>Техникийн хяалтын үзлэгийн техникч 4,<br>Тээвэр зохицуулагч 11,<br>Үйлчлэгч 8 | 70 |
| | | 1.2.2 Ажилтны мэргэжил боловсролыг дээшлүүлэх, мэргэшүүлэх 2022 оны сургалтын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх, сургалт зохион байгуулах | - | ЗСХНХ | Үйлдвэрийн газраас 2022.12.10-ны өдрийн байдлаар дараах төлөвлөгөөт сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд: | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | **Шалгуур үзүүлэлт:**<br>Төлөвлөгөөнд тусгагдсан сургалтын тоо<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Төлөвлөгөөнд тусгагдсан 30 сургалт зохион байгуулагдсан байна.** | | | 1.Хуулийн мэргэжилтэн Б.Батцэцэг Монголын хуульчдын холбооноос зохион байгуулсан захиргаа, эрх зүйн чиглэлийн 3 багц цагийн сургалтад хамрагдсан.<br>2.2022.03.04-ний өдөр ЗТХЯ-тай хамтран "Жендэрийн ялгаварлан гадуурхалт, жендэрт суурилсан хүчирхийлэл түүнээс урьдчилан сэргийлэх, эмэгтэйчүүдийн эрх зөрчигдөж буй тодорхой асуудлаар хэлэлцэх үндэсний хэмжээний цахим хэлэлцүүлэг /сургалт/-т 34 ажилтан хамрагдсан.<br>3.И-Монголиа академийн Цахим ур чадвар хөгжүүлэлтийн албатай хамтран "Цахим иргэн", "Цахим хөгжлийн багц хуулийн танилцуулга", "Тоон гарын үсэг, түүний хэрэгцээ" сэдвээр 2022.11.03-04-ний өдрүүдэд үйлдвэрийн газрын нийт албан хаагчдыг онлайн, танхимаар хослуулан 431 ажилтан хамруулсан.<br>4.Авлигатай тэмцэх газартай хамтран 2022.02.23-нд үйлдвэрийн газрын шинээр томилогдсон удирдах албан хаагчид болон ашиг сонирхлын мэдүүлэг гаргадаг албан хаагч нарт авлигын эсрэг хууль тогтоомж, авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор цахим сургалт зохион байгуулсан. Мөн үйлдвэрийн газрын удирдах ажилтнууд болон аймгийн Автотээврийн төв, Замын-үүд, Цогтцэций салбарын дарга, нягтлан бодогч нарт 2022.03.03-04-ний өдрүүдэд "Авлигын гэмт хэрэг" сэдэвт сургалтыг зохион байгуулсан.<br>5.Хүний хөгжил, судалгаа, сургалтын төвтэй хамтран 2022.03.15-17-ны өдрүүдэд худалдан авах ажиллагааны А3 сертификатын цахим сургалтад 21 ажилтан хамрагдаж, 12 ажилтан шалгалт өгснөөс 6 ажилтан шалгалтад тэнцэж сертификат олгосон.<br>6. Microsoft excel програмыг үр дүнтэй ашиглах, томъёогоор тооцооллыг автоматаар гүйцэтгэн төрөл бүрийн функц ашиглан боловсруулалт хийж сургах, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор төв болон 10 салбарын алба хаагчдад зориулсан цахим сургалтыг 2022.04.29-2022.05.06-ны өдрүүдэд зохион байгуулсан.<br>6. Тээвэр зохицуулагч нарын ур чадварыг нэмэгдүүлэх, ухаалаг тээврийн системийг хөгжүүлэх чиглэлээр мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулж нийт тээвэр зохицуулалт, зохион байгуулалт хариуцсан 160 ажилтан | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хамруулсан. Мөн ШУТИС-ийн МИС-тай хамтарсан үйлдвэрийн газрын нийт 130 тээвэр зохицуулагчийг 24 цагийн мэргэшүүлэх /сертификаттай/ сургалтад хамруулахаар төлөвлөгөөг баталсан.<br>7. Техникийн хяналтын үзлэгийн техникчийн ажлын байранд шинээр томилогдсон 7 албан хаагчийг 14 хоногийн үйлдвэрийн дадлага, сургалтад, СХЧУТ-ийн лабораторид Улаанбаатар хотын 21 техникийн хяналтын үзлэгийн техникчийг мэргэшүүлэх сургалтад, "Үйлчилгээний ажилтны соёл, үйлчлүүлэгчтэй харьцах арга" гэсэн сэдэвт сургалтад 42 техникчийг, давхардсан тоогоор нийт 70 техникчийг мэргэшүүлэх сургалтанд хамруулсан.<br>8. Удирдлагын академитай хамтран 2022.12.01-07-ны өдрүүдэд "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах арга зүй", "Системийн сэтгэлгээ" сэдэвт сургалтуудад үйлдвэрийн газрын Улаанбаатр хот дахь 36 албан хаагчийг танхимаар, орон нутгийн 44 албан хаагчийг цахимаар хамруулж нийт 80 албан хаагчид сертификат олгосон.<br>10. Монголын бүтээмжийн төвтэй хамтран 2022.06.06.07-ний өдрүүдэд "Ажлын соёл 5S кайзен саналын систем" сэдэвт сургалтыг зохион байгуулж 45 ажилтан хамруулсан.<br>11. ХАБЭА-н ажилтны сургалтыг батлагдсан хөтөлбөр, хуваарийн дагуу 18 удаа зохион байгуулж үйлдвэрийн газрын 316 ажилтан, аж ахуйн нэгж, байгууллагын 36 ажилтан хамрагдсан.<br>12. Монголын бүтээмжийн төвтэй хамтран 2022.10.25-ны өдөр "Байгууллагын менежмент, маркетингийн гүйцэтгэлийг сайжруулах бүтээмжийн тогтолцоо" сэдэвт сургалтад танхимаар 45 албан хаагч, онлайнаар 55 албан хаагч хамрагдаж нийт 100-н албан хаагч хамрагдсан.<br>13."IMACO" сургалтын төвтэй хамтран лавлах үйлчилгээний ажилтнуудыг чадавхижуулах, мэдээ мэдээллээр хангах сургалтыг 2022.03.05-ны өдөр зохион байгуулж 12 алба хаагч, 2022.05.22-ны өдөр "Харилцааны ёс зүйн сургалт"-ыг зохион байгуулж, лавлах үйлчилгээний 13 мэргэжилтэн, 8 автотээврийн хяналтын мэргэжилтэн, тээврийн хэрэгслийн бүртгэлийн хэлтсийн 58 мэргэжилтэн хамрагдсан. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 14. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн кримналистик шинжилгээний газрын ахлах шинжээч Батмөнх, ахмад Пүрэвсүрэн нараар ТХБХ-ийн нийслэл орон нутгийн нийт мэргэжилтнүүдэд хуурамч бичиг баримт, тамга тэмдэг хэрхэн таних талаар сургалтыг 2022.04.20-ны өдөр цахимаар зохион байгуулж бүртгэл, архивын 64 мэргэжилтэн хамрагдсан.<br>15.Үйлдвэрийн газрын Мэдээллийн технологийн хэлтсээс "Тээврийн хэрэгслийн гэрчилгээг цахимжуулах нь" сэдэвт сургалт зохион байгуулж, 74 ажилтан хамрагдсан.<br>16.СХЧУТ-ийн ахлах мэргэжилтэн А.Батчулуун, Н.Мөнхзул, мэргэжилтэн О.Бат-Эрдэнэ нар Стандарт, хэмжил зүйн газраас зохион байгуулсан "Баталгаажуулалтын шинжээчийн эрх олгох сургалт MNS ISO 17065:2013"-н сургалтад 2022.04.11-15-нд хамрагдаж шинжээчийн эрхээ 4-н жилээр сунгуулсан.<br>17.2022.11.9-11.10-ны өдрүүдэд MNS ISO 19011:2016 Удирдлагын тогтолцоонд дотоод аудит хийх заавар стандартын танилцуулах сургалтад Судалгаа, хөгжил, чанарын удирдлагын төвийн хэмжил зүйн мэргэжилтэн Б.Хишигболд, Лабораторын чанарын ахлах мэргэжилтэн Н.Алтанхуяг нар хамрагдсан.<br>18.СЭЗХ-ийн 14, Улаанбаатар хот дахь зорчигч тээврийн болон техникийн хяналтын үзлэгийн төвийн 8, орон нутгийн 23 нягтлан бодогч нийт 45 нягтлан бодогч нягтлан бодох бүртгэлийн сэдэвчилсэн бодлого бодох хөдөлгөөн өрнүүлэн ажиллаж байна.<br>19.2022.08.23-24-ний өдрүүдэд Удирдлагын академиас Засгийн газрын 2022.08.17-ны өдрийн 41 дүгээр хуралдаанаар өгсөн үүргийн дагуу "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилтыг сурталчлан таниулах сургалтыг Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагын албан хаагчдад амжилттай зохион байгуулж. Үйлдвэрийн газраас 16 албан хаагч хамрагдсан.<br>20. ISACA Certified information systems Audutor сургалтад МТХ-ийн мэргэжилтэн Б.Гантогтох 2022.12.09-ний өдөр хамрагдсан. Төлөвлөгөөт 30 сургалтаас 2022.12.10-ний өдрийн байдлаар 20 сургалт зохион байгуулсан бөгөөд удирдах ажилтнууд болон автотээврийн хяналтын мэргэжилтнүүд, техникийн хяналтын үзлэгийн инженер, | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | техникийн ажилтнууд, тээвэр зохицуулагч нарыг хамруулан нийт 21 удаагийн төлөвлөгөөт бус сургалтыг зохион байгуулж ажиллалаа. | |
| | | 1.2.3 Инженер, техникийн болон мэргэжилтэй ажилтныг мэргэшүүлэх<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Сургалтанд хамрагдсан инженер, техникийн ажилтны тоо<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин: Шаардлагатай ажилтнуудыг сургалтад хамруулж, мэдлэг олгосон байна.** | - | ЗСХНХ ТХХ | Үйлдвэрийн газраас Инженер, техникийн болон мэргэжилтэй ажилтныг мэргэшүүлэх чиглэлээр дараахь сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд:<br>• 2022.01.28-ны өдөр Тээврийн хэрэгсэлтэй харьцах журам, Шударга байдал сэдэвт сургалтад нийт инженер техникийн ажилтнуудыг хамруулсан.<br>• 2022.02.11-ний өдөр “Тоног төхөөрөмжийн, ашиглалт, хамгаалалт, арчлалт”-ын талаарх мэргэжил, арга зүйн сургалтыг нийслэлийн 3 төв, хөдөө орон нутгийн нийт инженер, техникийн ажилтнуудыг хамруулан зохион байгууллаа.<br>• 2022.03.03-ны өдөр “Техникийн хяналтын үзлэгийн үйл ажиллагааны итгэмжлэл” сэдвээр Улаанбаатар хотын техникийн хяналтын үзлэгийн төвүүдийн дарга, аймгуудын автотээврийн төвийн дарга нарыг тус тус сургалтанд хамруулсан.<br>• 2022.03.25-ны өдөр техникийн хяналтын үзлэгийн төвүүдийн инженер, техникч нарт “Авто хийн алдагдал шалгагч тоног төхөөрөмж ашиглах, ажиллуулах” сургалтыг зохион байгуулсан.<br>• 2022.04.28-ны өдөр “Техникийн хяналтын үзлэгийг тогтоосон дүрэм журам стандартын хүрээнд хийх, хууль бус дүгнэлт гаргахгүй байх” сэдвээр нийт инженер техникийн ажилтнуудыг сургалтанд хамруулсан.<br>• 2022.05.18-ны өдөр “Тоног төхөөрөмжийн ашиглалт, арчлалт, хамгаалалт” сэдвээр нийт инженер, техникийн ажилтнуудыг сургалтанд хамруулсан.<br>• 2022.09.19-21-ний өдрүүдэд Аймгийн автотээврийн төвүүдийн техникийн хяналтын үзлэгийн үйл ажиллагаанд MNS ISO 17020:2013 стандартын дагуу чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх ажлын хүрээнд Баян-Өлгий, | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорноговь, Дорнод, Замын-Үүд, Дундговь, Сүхбаатар, Төв, Хэнтий, Өвөрхангай, Өмнөговь аймгийн автотээврийн төвийн техникийн хяналтын үзлэгийн инженер, техникийн ажилтнуудад 3 хоногийн 15 цагийн багц сургалтыг зохион байгуулсан.<br>• Мэргэшсэн инженерийн зэрэг олгох мэргэшүүлэх сургалтад Сонгинохайрхан техникийн хяналтын үзлэгийн төвийн техникийн хяналтын үзлэгийн инженер Э.Мөнхсайхан, техникийн хяналтын үзлэгийн техникч Б.Цэлмэг, Говь-Алтай аймгийн Автотээврийн төвийн автотээврийн хяналтын мэргэжилтэн Д.Бат-Эрхэм, техникийн хяналтын үзлэгийн техникч Д.Бат-Ирээдүй нар хамрагдсан.<br>• 2022.10.04-24-ний өдрүүдэд Улаанбаатар хотын нийт инженер, техникийн ажилтнуудад Техникийн хяналтын үзлэгийн технологи үйл ажиллагааны талаар мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулж, 2022.12.05-ны байдлаар нийт 54 алба хаагч хамрагдаад байна.<br>• 2022.11.09-12-ны өдрүүдэд Үйлчилгээний ажилтны соёлын, үйлчлүүлэгчтэй харьцах арга сэдэвт сургалт зохион байгууулж, нийт 96 инженер техникийн ажилтан хамрагдсан. | |
| | | 1.2.4 Тээвэр зохион байгуулалт хариуцсан ажилтнуудыг хөгжүүлэх, чадавхжуулах<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Автотээврийн салбарын мэргэжилтэй ажилтны эзлэх хувь<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Сургалтанд 80 ажилтан хамрагдсан байна.** | - | ЗСХНХ<br>ЗТХ | Тээвэр зохион байгуулалт хариуцсан ажилтнуудыг хөгжүүлэх, чадавхжуулах чиглэлээр тус үйлдвэрийн газраас дараахь сургалтуудыг зохион байгуулсан.<br>Үүнд:<br>• Нийслэлийн прокурорын газар, "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ, Нийтийн тээврийн газрын хамтарсан "Хяналтын мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх" сургалт зохион байгуулж 16 автотээврийн хяналтын мэргэжилтэн хамрагдсан.<br>• Тээвэр зохицуулагчийн мэргэшүүлэх сургалтад Говь-Алтай аймгийн Автотээврийн төвийн тээвэр зохицуулагч А.Мөнхзулцацрах, Хөвсгөл аймгийн Автотээврийн төвийн тээвэр зохицуулагч Э.Нямдорж, Орхон аймгийн Автотээврийн төвийн | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тээврийн мэргэжилтэн Б.Алтантуяа, тээвэр зохицуулагч Д.Эрдэнэчимэг нар хамрагдсан.<br>Зорчигч тээврийн хэлтсийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд "Тээвэр зохицуулагч нарын ур чадварыг нэмэгдүүлэх, ухаалаг тээврийн системийг хөгжүүлэх" тухай онол, практик хослуулсан бүсчилсэн сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах" гэж төлөвлөсний дагуу бүсчилсэн сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд.<br>• 2022.03.30–2022.04.05-ний өдрүүдэд Зүүн бүсийн 3 аймгийн тээвэр зохицуулагч нарт сургалт хийсэн. Сургалтад 17 тээвэр зохицуулагч 6 гэрээт ажилтан хамрагдсан бөгөөд нийт 23 ажилтан хамрагдсан.<br>• 2022.04.11–12-ний өдрүүдэд Улаанбаатар хот дахь Сонгинохайрхан, Баянзүрх зорчигч тээврийн төвийн 33 тээвэр зохицуулагч, лавлах үйлчилгээний 11 ажилтан хамрагдсан.<br>• 2022.04.13-23-ний өдрүүдэд Баруун бүсийн 8 аймгийн тээвэр зохицуулагч нарт сургалт хийсэн. Сургалтад 35 тээвэр зохицуулагч, 1 гэрээт ажилтан, 4 тасалбар түгээгч хамрагдсан бөгөөд нийт 40 ажилтан хамрагдсан.<br>• 2022.04.26–2022.05.03-ний өдрүүдэд Хойд бүсийн 5 аймгийн тээвэр зохицуулагч нарт сургалт хийсэн. Сургалтад 36 ажилтан хамрагдсан.<br>• 2022.09.26-2022.10.03-ний өдрүүдэд Зүүн бүсийн /Дорноговь, Говьсүмбэр/ 2 аймаг, Замын-Үүд салбарын тээвэр зохицуулагч нарт сургалт хийсэн. Сургалтад 15 тээвэр зохицуулагч, 2 тасалбар түгээгч хамрагдсан.<br>• 2022.10.25-ний өдөр үлдсэн 4 салбарын 20 ажилтанд цахимаар сургалт зохион байгуулсан.<br>2022.12.10-ний өдрийн байдлаар 21 аймаг, 4 салбарын 180 ажилтан албан хаагч 100% сургалтад хамрагдсан. | |
| | | 1.2.5. Албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээг тогтмол зохион байгуулах | - | ЗСХНХ | Тус үйлдвэрийн газрын 2022 оны авлигын эсрэг төлөвлөгөөг батлуулсан. Төлөвлөгөөний дагуу Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | **Шалгуур үзүүлэлт:**<br>Авлига, ашиг сонирхлын зөрчлийн тоо<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Авлига, ашиг сонирхлын зөрчилгүй хамт олон болсон байна.** | | | ✓ 2022.02.23-нд үйлдвэрийн газрын шинээр томилогдсон удирдах албан хаагчид болон ашиг сонирхлын мэдүүлэг гаргадаг албан хаагч нарт авлигын эсрэг хууль тогтоомж, авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор цахим сургалт зохион байгуулсан.<br>✓ 2022.03.04-нд үйлдвэрийн газрын нийт удирдах албан тушаалтнуудад "Авлигын гэмт хэрэг" сэдэвт сургалтыг зохион байгуулсан. | |
| | | | | | Авлигын гэмт хэрэг, зөрчлийн илрүүлэлт, авлигын эсрэг үйл ажиллагаанд иргэдийн идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор техникийн хяналтын үзлэгт орж байгаа тээврийн хэрэгслүүдэд иргэд, аж ахуйн нэгжээс өргөдөл гомдол хүлээн авах 110 дугаарын утасны сурталчилгаа бүхий авто стикерийг улсын хэмжээнд 35,000 ширхэгийг байршуулан ажилласан. Мөн үйлдвэрийн газарт шинээр томилогдсон, албан тушаал дэвшсэн, өөрчлөгдсөн ажилтан бүрт тухай бүр авлигын эсрэг хуулийг дахин танилцуулж, баталгаажуулж ажиллаж байна. | |
| | | 1.2.6 Автотээврийн нэгдсэн лавлах 1900-1234 тусгай дугаараар иргэдэд хүргэх үйлчилгээг өргөжүүлж, үйлчилгээг 24 цагаар ажиллуулж эхлэх<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>24 цагийн хуваарьт шилжсэн байх<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин: Автотээврийн нэгдсэн лавлах 1900-1234 тусгай дугаараар үйлчлүүлсэн иргэдийн тоо нэмэгдсэн байна.** | | ХУХ | Үйлдвэрийн газар нь Автотээврийн нэгдсэн лавлах 1900-1234 тусгай дугаараар иргэдэд хүргэх үйлчилгээг өргөжүүлж, үйлчилгээг 2022.04.11-ний өдрөөс 24 цагаар ажиллуулж эхэлсэн.<br>"Автотээврийн нэгдсэн лавлах 1900-1234" тусгай дугаарын үйлчилгээ нь 2022.12.05-ны өдрийн байдлаар нийт 651,886 дуудлага хүлээн авч, 2683 гомдлыг утсаар шийдвэрлэж 57 гомдлыг санал, хүсэлт, гомдлын хуудсаар бүртгэж холбогдох хэлтэст шилжүүлсэн. Тайлант хугацаанд шөнийн цагаар буюу 22:00-07:00 цагийн хооронд нийт 34390 дуудлага хүлээн авсан.<br>Автотээврийн нэгдсэн лавлах 1900-1234 тусгай дугаараар 2021 онд 411,174 иргэн холбогдож, дуудлагыг хүлээн авсан бөгөөд 2022.12.10-ны өдрийн байдлаар нийт 662,663 иргэн холбогдож дуудлагыг нь хүлээн авсан нь өмнө жилийн мөн үетэй харьцуулахад /251,489 дуудлага/ 37.98% -иар өссөн дүнтэй байна. | 100 |
| 1.3 | Улс хот хоорондын ачаа, зорчигч тээвэрлэлтийн | 1.3.1. Улс, хот хоорондын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгчийг сонгон гэрээ байгуулан | | ЗТХ | 2022.12.10-ний өдрийн байдлаар хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээг 50 чиглэлд 58 аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулан 708 тээврийн хэрэгсэл | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/24 дүгээр тушаалаар батлагдсан "Автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрэм" -ийн дагуу зохион байгуулах | батлагдсан тээвэрлэлтийн чиглэл, үйлчилгээний давтамж, цагийн хуваарийн дагуу үйлчилгээг зохион байгуулах;<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Үйлчилгээнд ашиглагдаж байгаа том оврын автобусны эзлэх хувь<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Батлагдсан зарим чиглэлүүдэд үйлчилгээг эхлүүлсэн байна.** | | | болон 1477 жолоочтойгоор тээвэрлэлтийг гүйцэтгэж байгаа бөгөөд 22 чиглэлийн үйлчилгээ зорчигч урсгалтай холбоотойгоор түр зогссон. Батлагдсан 72 чиглэлд үйлчилгээг зохион байгуулсан.<br>Улс хоорондын нийтийн тээврийн үйлчилгээг 3 чиглэлд 6 ААНБ-тай гэрээ байгуулан давхардсан тоогоор 35 тээврийн хэрэгсэл болон 99 жолоочтойгоор тээвэрлэлтийг гүйцэтгэж байгаа бөгөөд 10 чиглэлийн үйлчилгээ хил хаалттай холбоотойгоор түр зогссон.<br>Улс, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээнд нийт 743 тээврийн хэрэгсэл тээвэрлэлт гүйцэтгэж байгаа бөгөөд үүний 85% нь том оврын тээврийн хэрэгсэл байна. | |
| | | 1.3.2. Хот хоорондын нийтийн тээврийн замналын паспорт хөтлөх<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Замналын паспортод баяжуулалт хийгдэж, хөтөлсөн тоо<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Замналын паспортод баяжуулалт хийгдсэн байна.** | 10 сая.төг | ЗТХ | Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар хот хооронддын нийтийн тээврийн 109 чиглэл батлагдсан бөгөөд 104 замналын паспортод баяжуулалт хийгдэж бүрэн хөтлөгдсөн. | 90 |
| | | 1.3.3 Автозамаар олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрлийн бичгүүдийг бэлтгэн хэвлүүлж, холбогдох улсуудад хүргүүлж, тээвэрлэлтийн хэвийн нөхцөлийг бүрдүүлэх<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Зөвшөөрлийн бичгүүд бэлтгэгдэж, тээвэрлэлт явагдах нөхцөл бүрдүүлэх<br>**Хугацаа:**<br>II-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Зөвшөөрлийн бичгүүдийг хэвлүүлж, холбогдох улсуудад хүргүүлсэн байна.** | 10 сая.төг /Монголын автотээвэрчдийн нэгдсэн холбоо/ | АТХ | Автозамаар олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрлийн бичгүүдийг хэвлүүлэх болон холбогдох улсуудад хүргүүлэх ажлыг Монголын автотээвэрчдийн нэгдсэн холбооноос зохион байгуулж байна.<br>Зам, тээврийн хөгжлийн сайд Монголын автотээвэрчдийн нэгдсэн холбоотой 2022.08.12-ны өдөр байгуулсан Ажил гүйцэтгүүлэх гэрээний 4.4-т " Дараа онд ашиглагдах зөвшөөрлийн бичгүүдийг тохиролцон төрөл, тоо, хэмжээ, яамнаас баталсан загварын дагуу өмнөх оны 12 сарын 01-ны дотор бэлтгэж, яаманд ирүүлэх" заасан.<br>Иймд Зөвшөөрлийн бичгүүдийг хэвлүүлэх үүрэг Монголын автотээвэрчдийн нэгдсэн холбоонд, холбогдох улсуудад хүргүүлэх үүргийг ЗТХЯ-ны АТБХЗГ хариуцан ажиллаж байна. | 90 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 1.3.4 Монгол, Хятадын хилийн Замын-Үүд-Эрээн автозамын боомтын дундын бүсэд чингэлэг солилцох үйл ажиллагааг зохион байгуулах<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Улс хоорондын ачаа тээвэрлэлт саадгүй явагдах нөхцөл бүрдсэн байх<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Бүх төрлийн бараа ачсан автомашиныг улсын хилээр нэвтрүүлсэн байна.** | Засгийн газрын нөөц хөрөнгө, 700 сая.төг | АТХ | 2022.05.16-ны өдрөөс эхлэн иргэдийн 30, хил хамгаалахын 30, нийт 60 тээврийн хэрэгсэл хоосон чингэлэг ачиж 0 цэгт хүргэж өгч ажиллаж байна. 2022.12.05-ны өдрөөр өссөн дүнгээр нийт 23,643 тээврийн хэрэгслээр 571,208.5 тонн ачаа тээвэрлэгдэж, Эрээн боомтоос 20 тн чингэлэгийн 8,943, 40тн чингэлэгийн 18,690, Эрээн боомт руу буцсан 20тн чингэлэгийн 4,129, 40тн чингэлэгийн 12,926 ширхэг тээвэрлэгдсэн байна.<br>Замын-Үүд сумаас задгай тээврийн 7,581 тээврийн хэрэгслээр 153,505 тн ачаа, чингэлэг тээврийн 15,376 тээврийн хэрэгслээр 353,573 тн ачааг Улаанбаатар хот болон бусад аймгийн чиглэлд тээвэрлэсэн байна. Улс хоорондын ачаа тээвэрлэлт саадгүй явагдах нөхцөл бүрдсэн.<br>Үйлдвэрийн газраас 2022 оны 7-р сард Хил хамгаалах ерөнхий газартай уулзалт хийж, Замын-Үүд -Эрээн авто замын боомтоор овор ихтэй ачааг хүлээн авах хугацааг тохирч, 08.00-12.00 цагт ачаатай чингэлэг хүлээн авч, 14.-16.00 цагт Монгол улсын гаалийн хяналтын талбайд чингэлэгээ байршуулан ажиллаж байна. Мөн үдээс хойш 16.30 цагт импортын тээврийн хэрэгслүүдийг Монгол улсын гаалийн хяналтын талбайд байршуулдаг. Монгол улсын гаалийн хяналтын талбайд чиргүүлийн бөөгнөрөл үүсээгүй бөгөөд өдөрт дунджаар иргэдийн 100 хүртэл тээврийн хэрэгслээр 2000 тн ачаа бараа нэвтрүүлж байна. Монгол улсын талаас БНХАУ-д өдөрт бог малыг амьдаар 330 -г тээвэрлэж гаргаж байсан бол энэ тоог нэмэгдүүлж, өдөрт 1000 бог тээвэрлэж чиргүүл солилцож байна. Чиргүүл солилцох ажлын эхний туршилтыг хийсэн. Манай талаас шалтгаалж, ачаа тээвэрлэлт тасалдсан, зогссон асуудал гараагүй болно. | 90 |
| | | 1.3.5 Замын-Үүд – Эрээн боомтоос бусад БНХАУ-тай хиллэдэг Бичигт, Булган боомтоор импортын ачаа нэвтрүүлэх чиглэлээр тээвэр зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх<br>**Шалгуур үзүүлэлт:** | | АТХ | 2022.12.05-ны өдрийн байдлаар Ховд аймгийн Булган, Сүхбаатар аймгийн Бичигт хилийн боомтоор импортын ачаа бараа саадгүй нэвтэрч байна.<br>Ховд аймгийн Булган боомтоор бараа, материалыг 2022.01.17-ны өдрөөс эхэлж тээвэрлэсэн ба өссөн дүнгээр нийт 956 т/х-ээр 18,323.23 тн ачаа тээвэрлэсэн байна. Сүхбаатар аймгийн Бичигт боомтоор 2022.07.25-ны өдрөөс бараа материалыг тээвэрлэж эхэлсэн бөгөөд | 90 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Бичигт, Булган боомтоор импортын тээвэрлэлт явагдсан байх<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Тээвэрлэлт тасралтгүй хэвийн явуулсан байна.** | | | нийт 135 тээврийн хэрэгслээр 51 тн ачаа бараа тээвэрлэсэн байна. | |
| | | 1.3.6 Монгол Улсын хилээр нэвтрэн тээвэрлэлт хийж буй гадаадын тээврийн хэрэгсэлд тавих хяналт, шалгалтыг сайжруулж, хариуцлага тооцож ажиллах<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Гадаадын тээвэрлэгчид зөвшөөрлийн бичиггүйгээр хил нэвтэрч тээвэрлэлт хийх явдал арилсан байх<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Зөвшөөрлийн бичгийн 4-р улирлын мэдээ тайланг ЗТХЯ-нд хүргүүлсэн байна.** | | ХУХ | Сэлэнгэ аймгийн Алтанбулаг боомтоор нэвтэрч буй тээврийн хэрэгслийг хилийн бүсийн гадна хяналт шалгалт хийж байгаа учраас хариуцлага тооцох боломжгүй байна. Монгол улсын Хилийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1-д "Мэргэжлийн хяналтын байгууллага улсын хилээр нэвтрүүлэх үеийн хяналт шалгалтыг хийнэ" гэж заасан байдаг. Алтанбулаг хилийн боомтоор 2022.12.10-ны байдлаар ОХУ-руу гарсан ачааны тээврийн хэрэгсэл 7520, ОХУ-аас Монгол улс руу орж ирсэн 7602 том оврын ачааны тээврийн хэрэгсэл шалгаснаас зөвшөөрлийн бичиггүй нийт 817 тээврийн хэрэгсэл орж ирсэн байна. Зөвшөөрлийн бичгийг "Монголын автотээвэрчдийн нэгдсэн холбоо"-оос олгож байгаа болно. Зөвшөөрлийн бичгийн тайланг Монголын Автотээвэрчдийн нэгдсэн холбооноос яаманд хүргүүлдэг.<br>Үйлдвэрийн газраас тус боомтоор нэвтэрсэн тээврийн хэрэгслийн мэдээг 2022.12.08-ны өдөр ЗТХЯ-ны ХШҮДАГ-ын Хяналтын хэлтсийн дарга Д.Энх-Амгаланд хүргүүлж, тайлагнасан.<br>БНХАУ-ын Эрээн хот-? | 90 |
| | | 1.3.7 Олон улсын, улсын чанартай авто замаар ачаа тээвэрлэлт хийж буй тээврийн хэрэгсэл стандартын шаардлага хангаж байгаа эсэхэд тавих хяналтыг сайжруулах, ЗТХЯ, мэргэжлийн хяналт, Тээврийн цагдаагийн албатай хамтран компанит ажил зохион байгуулах<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Хяналт, шалгалтын ажил зохион байгуулагдаж, тодорхой үр дүн гарсан байх | | ХУХ | 2022 онд олон улсын, улсын чанартай авто замаар ачаа тээвэрлэлт хийж буй тээврийн хэрэгсэл стандартын шаардлага хангаж байгаа эсэхэд тавих зорилгоор дараахь хяналт шалгалтуудыг зохион байгуулсан. Үүнд:<br>-ЗТХЯ, "ЗТХТ" ТӨҮГ-тай, ТЦА-тай хамтарсан "Саадгүй тээвэр-Сайн замаар" нэгдсэн арга хэмжээг 2022.04.01-2022.05.01-ний өдрүүдэд,<br>-Булган аймгийн Рашаант сумын Замын цагдаагийн алба хаагч нартай хамтран тус сумын Замын цагдаагийн тасгийн постонд 2022.08.11-14-ний өдрийн хооронд,<br>-Багануур дүүргийн ТЦА болон "ЗТХТ" ТӨҮГ-тай хамтран Багануур дүүргийн Хэрлэнгийн постонд 2022.09.13-19-ний өдрүүдэд, | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | **Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Төлөвлөгөөний хэрэгжилт хангагдсан байна.** | | | -Өмнөговь аймгийн Цогтцэций сумаас Улаанбаатар хотыг чиглэсэн тээврийн үйл ажиллагаанд 2022.08.24-2022.09.09-ний өдрүүдэд,<br>-НТГ, "ЗТХТ" ТӨҮГ-тай хамтран Сэлэнгэ Аймгийн Баруунтуруунын шалган нэвтрүүлэх цэгт 2022.09.15-ны өдрөөс 14 хоногийн хугацаатай,<br>-Дархан-Уул аймгийн шалган нэвтрүүлэх цэгт АТХУБ нар 2022.10.17-2022.11.19-ний өдрийн хооронд тус тус хяналт шалгалтаар ажилласан.<br>-Өмнөговь аймгийн Цогтцэций сум болон Өлзийтийн шалган нэвтрүүлэх цэг, 4-р зөрлөг дээр АТХУБ нар 2022. оны 11 дүгээр сараас эхлэн тогтмол хяналт шалгалт хийж ажиллаж байна.<br>Тайлант хугацаанд ачаа тээврийн 16394 тээврийн хэрэгсэл шалгаж 346 тээврийн хэрэгсэлд 51.900.000 төгрөгийн торгууль ноогдуулж, төлөвлөгөөний хэрэгжилт хангагдсан болно. | |
| 1.4 | Улс хоорондын тээвэрлэлтийн эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр олон улсын гэрээ хэлэлцээр байгуулах, хамтын ажиллагааг өргөжүүлэх | 1.4.1 Монгол, Хятадын хилийн авто замын боомтуудаар хийгдэх уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийг тасралтгүй хэвийн явуулах чиглэлээр шаардлагатай арга хэмжээг авч ажиллах<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Тээвэрлэлт хэвийн явагдсан байх<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Тээвэрлэлтийн тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангасан байна.** | 38 сая.төг | АТХ | Сүхбаатар аймгийн Бичигт боомтын чиглэлийн тээвэрлэлт 2022.07.25-ны өдөр эхэлсэн ба 2022.12.10-ны өдрийн байдлаар нийт 1133 тээврийн хэрэгсэл, 2201 чингэлэгээр 68,981 тн нүүрс экспортлосон ба 135 тээврийн хэрэгслээр 51 тн ачаа бараа импортлосон байна. Тээвэрлэлт хэвийн үргэлжилж байна.<br>Өмнөговь аймгийн Гурван тэс сумын Шивээхүрэн хилийн боомтын үйл ажиллагаа 2022.05.25-ны өдөр эхэлсэн ба халдвар, хамгааллын дэглэмийг сахиулан хилийн 0 цэг дээр чингэлэг солин тээвэрлэлтийг гүйцэтгэж байна. Тээвэрлэлт эхэлснээс хойш өссөн дүнгээр нийт 32,160 тээврийн хэрэгсэл, 128,640 чингэлэгээр 4,810,570.2 тн нүүрс тээвэрлэсэн байна. Одоогийн байдлаар тээвэрлэлт хэвийн үргэлжилж байна.<br>Дорноговь аймгийн Ханги хилийн боомтын тээвэрлэлт хэвийн үргэлжилж байгаа бөгөөд өссөн дүнгээр 35,625 тээврийн хэрэгсэл, 71,250 чингэлэгээр 2,619,852.6 тн нүүрс, 604 тээврийн хэрэгслээр 44,494.5 тн төмрийн хүдэр, 83 тээврийн хэрэгслээр 6,051.4 тн жонш тус тус тээвэрлэсэн үзүүлэлттэй байна. | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 1.4.2. Монгол Улс болон БНХАУ-ын ӨМӨЗО, ШУӨЗО-ны Автотээврийн төлөөлөгчдийн 2022, 2023 онд ашиглах зөвшөөрлийн бичиг солилцох уулзалтуудыг тус тус зохион байгуулах<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Улс хоорондын тээвэрлэлтэд үүсч буй асуудлууд шийдэгдсэн байх<br>**Хугацаа:**<br>III-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**БНХАУ-ын 2023 онд ашиглагдах зөвшөөрлийн бичгийг солилцсон байна.** | 17.3 сая.төг | АТХ | Тус үйлдвэрийн газраас БНХАУ-ын Хөх хот дахь Ерөнхий консулын газраар дамжуулан 2022 онд зөвшөөрлийн бичиг солилцох тухай 3/1647 тоотыг 2021.12.28-ны өдөр ӨМӨЗО-ны ЗХТТ-д хүргүүлсэн. ӨМӨЗО-ны ЗХТТ-аас 2021.12.29-ний өдрийн (2021)1340 тоотоор 2022 оны зөвшөөрлийн /А-80, А-С-30, С-38000, D-50000, E-1000, F-4000 ширхэг/ бичгийг Монгол Улсаас ӨМӨЗО-ны Хөх хотод суугаа консулаар дамжуулан солихыг зөвшөөрсөн тухай бичгийг ирүүлсэн. Зөвшөөрлийн бичгийг Өмнөговь аймгийн Гашуунсухайт хилийн боомтоор хүлээн авсан.<br>БНХАУ-ын ШУӨЗО-ны ЗХТТ-аас 2021.10.08-ны өдрийн 2021М004 тоотоор 2022 онд ашиглагдах зөвшөөрлийн /C-6000, F-100/ бичгийг солилцох бусад зөвшөөрлийн бичгийг үргэлжлүүлэн ашиглах тухай саналыг ирүүлсэн. Тус үйлдвэрийн газраас ШУӨЗО-ны ЗХТТ-аас ирүүлсэн саналыг зөвшөөрсөн тухай 3/1295 тоотыг 2021.10.14-ний өдөр хүргүүлсэн. ШУӨЗО-ны ЗХТТ-аас 2021.11.16-ны өдрийн 2021М005 тоотоор ковид-19 өвчний нөхцөл байдлаас шалтгаалан өөрсдийн хэвлэсэн зөвшөөрлийн бичиг /C-6000, F-100/-ийг ашиглах талаар албан тоот ирүүлсэн. Тус үйлдвэрийн гзраас 2021.12.08-ны өдрийн 3/1538 тоотоор ковид-19 өвчний нөхцөл байдлаас шалтгаалан өөрсдийн хэвлэсэн зөвшөөрлийн бичгийг ашиглахыг дэмжсэн тухай тоотыг ШУӨЗО-ны ЗХТТ-д хүргүүлсэн.<br>БНХАУ-ын ӨМӨЗО-ны ЗХТТ-д 2023 онд ашиглах зөвшөөрлийн бичиг хэвлүүлэх болон солилцох тухай албан бичгийг 2022.09.21-ний өдрийн 1/1192 тоотоор, ШУӨЗО-ны ЗХТТ-д 2022.09.21-ний өдрийн 1/1191 тоотыг тус тус хүргүүлсэн. ШУӨЗО-ны ЗХТТ-аас хариуг 2022.10.10-ны өдрийн 2022М004 тоотоор ирүүлсэн.<br>Зөвшөөрлийн бичгийн тоог хоёр талаас тохиролцсон ба 2022.12.10-ны өдрийн байдлаар зөвшөөрлийн бичгийг хэвлэлийн газраар хэвлүүлж байна. Зөвшөөрлийн бичгийг 2022.12.25-ны өдөр солилцохоор тохирсон. | 90 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 1.4.3 Европын холбооны улсууд, ОХУ-тай байгуулсан засгийн газар хоорондын автотээврийн хэлэлцээрийн хэрэгжилтийг хангуулах ээлжилт уулзалтад оролцох<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Уулзалт зохион байгуулагдсан байх<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Ээлжит уулзалтад оролцсон байна.** | 30 сая.төг | АТХ | Зам, тээврийн хөгжлийн яамнаас Европын холбооны улсууд, ОХУ-тай байгуулсан засгийн газар хоорондын автотээврийн хэлэлцээрийн хэрэгжилтийг хангуулах ээлжилт уулзалтын товын талаар мэдээлэл ирүүлээгүй байна. Европын холбооны улсууд, ОХУ-тай байгуулсан засгийн газар хоорондын автотээврийн хэлэлцээрийн хэрэгжилтийг хангуулах ээлжит уулзалтыг ЗТХЯ-наас зохион байгуулдаг.<br>Бүгд Найрамдах Беларусь Улсын Минск хотод 2022.09.28-ны өдрөөс 2022.10.04-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Монгол, Беларусийн Автотээврийн харилцааны хамтарсан комиссын 2 дугаар хуралдаанд үйлдвэрийн газрын МТХ-ийн дарга Ц.Эрдэнэчулуун оролцож, Зөвшөөрлийн бичгийг гуравдагч улсын болон хоёр талын дамжин өнгөрөх гэсэн төрлөөр ангилах, зөвшөөрлийн бичгийн тоог шинэчлэн тохирох асуудлыг хэлэлцсэн. | 100 |
| | | 1.4.4 "Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийн хүрээнд хамтарсан хорооны хурлыг ЗТХЯ-тай хамтран зохион байгуулах<br>**Хугацаа:**<br>III-IV улирал<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>**Хамтарсан хорооны хуралд оролцсон байна.** | 20 сая.төг | АТХ | Коронавируст цар тахал болон Украин Улсад үүссэн нөхцөл байдлын улмаас "Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийн хэрэгжилтийг хангах Хамтарсан хорооны гуравдугаар хурлын бэлтгэл хангах гурван талын шинжээчдийн уулзалтыг НҮБ-ын АНДЭЗНК-ийн дэмжлэгтэйгээр зохион байгуулсан. Хамтарсан хорооны хурлыг зохион байгуулах талаар ОХУ болон БНХАУ-ын Тээврийн дэд сайд нарт албан бичиг хүргүүлсэн. Үүний хариуд ОХУ-ын Тээврийн нэгдүгээр орлогч сайдаас 9-1259 дугаартай албан бичгээр хурлыг 2023 оны эхний хагаст зохион байгуулах саналыг ирүүлсэн талаар ЗТХЯ-наас мэдэгдсэн. | 70 |
| | | 1.4.5 "Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийн хүрээнд Монгол Улс, БНХАУ, ОХУ-д ашиглах зөвшөөрлийн бичиг хүлээн авах;<br>**Хугацаа:**<br>IV улирал<br>**Шалгуур үзүүлэлт:** | - | АТХ | "Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийн хүрээнд Монгол Улс, БНХАУ, ОХУ-д ашиглах зөвшөөрлийн бичгийг үргэлжлүүлэн ашиглахаар тохиролцсон.<br>Ковидын нөхцөл байдлын улмаас Монгол болон ОХУ-ын тээврийн хэрэгсэл БНХАУ-ын нутаг дэвсгэрт нэвтрэн тээвэрлэлт хийх боломжгүй байгаа учраас зөвшөөрлийн бичиг солилцох хугацааг хойшлуулсан. | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | **ОХУ-аас 2023 онд ашиглах зөвшөөрлийн бичгийг хүлээн авсан байна.** | | | "Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийн хүрээнд Монгол Улс, БНХАУ, ОХУ болон гуравдагч орнуудад ашиглах зөвшөөрлийн бичгийг Монголын Автотээвэрчдийн нэгдсэн холбооноос олгож байгаа болно.<br>Азийн авто замын сүлжээ АН-4 автозам нь баригдаж дууссан боловч тээвэрлэлт эхлээгүй байгаа учир БНХАУ-ын талаас зөвшөөрлийн бичгийг манай байгууллагад олгоогүй байгаа болно | |
| 1.5 | Жуулчин тээвэрлэлтийн үйлчилгээг зохион байгуулах, бүртгэл хяналтын тогтолцоог бүрдүүлэх; | 1.5.1. Жуулчин тээврийн үйлчилгээг Төрийн үйлчилгээний нэгдсэн портал /www.e-mongolia.mn/-аар дамжуулан зохион байгуулах<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>www.e-mongolia.mn –д бүртгэлтэй жуулчин тээвэрлэгчийн тоо<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Төрийн үйлчилгээний нэгдсэн порталд /www.e-mongolia.mn/ жуулчин тээврийн үйлчилгээг зохион байгуулж жуулчин таних тэмдгийг олгосон байна.** | - | ЗТХ | Төрийн үйлчилгээний нэгдсэн портал /www.e-mongolia.mn/-аар дамжуулан **6** аж ахуйн нэгж байгууллага хүсэлт гаргасан бөгөөд шаардлага хангасан тул гэрээ байгуулсан. Нийт 128 "ЖУУЛЧИН" таних тэмдгийг Төрийн үйлчилгээний нэгдсэн портал /www.e-mongolia.mn/-аар дамжуулан аж ахуйн нэгж байгууллагуудад олгосон. | 90 |
| 1.6 | Иргэдэд тээврийн үйлчилгээг ойртуулах зорилгоор тээшний хэмжээг тогтоох жин хэмжүүр, тээш хадгалах зориулалтын байрыг бий болгох, тээшний тасалбар олгох | 1.6.1 Илгээмжийн ачааг хүлээн авах, бүртгэлжүүлэх, хадгалах, тээвэрлэх, хүлээлгэн өгөх үйлчилгээг автобуудалтай аймгуудад зохион байгуулах;<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Зорчигчийн тээш хүлээн авах цэгүүдийн тоо<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Орон нутгийн салбаруудад илгээмжийн ачааг бүртгэлжүүлж, тээвэрлэх,** | - | АТХ | Илгээмжийн ачааг хүлээн авах, бүртгэлжүүлэх, хадгалах, тээвэрлэх, хүлээлгэн өгөх үйлчилгээг Улаанбаатар хот дах Баянзүрх, Сонгинохайрхан зорчигч тээврийн төв, Өвөрхангай, Баянхонгор, Баян-Өлгий, Увс, Завхан, Архангай, Хөвсгөл, Дархан-Уул, Өмнөговь аймгийн автобуудлуудаар дамжуулан зохион байгуулан ажиллаж байна. 2022.12.10-ны өдрийн байдлаар нийт 161,9 сая.төг орлого төвлөрүүлэн ажиллаж байна. | 90 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | **хүлээлгэн өгөх үйлчилгээг автобуудалтай аймгуудад зохион байгуулсан байна.** | | | | |
| 1.7 | Мэргэшсэн жолоочийн шалгалт авах, үнэмлэх олгох үйл ажиллагааг зохих журамд заасны дагуу зохион байгуулах; | 1.7.1. Автотээврийн тухай хууль, ЗТБХБЯам, БСШУЯ-ны хамтарсан 2010 оны 161/229 тоот тушаалын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Мэргэшсэн жолоочийн шалгалт авч, үнэмлэх олгосон тоо<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:** /3-Р УЛИРАЛ/ **Мэргэшсэн жолоочийн 25000 удаагийн шалгалтыг авч, 10400 үнэмлэх хэвлэн олгосон байна.** | - | ЗТХ-ийн МЖСТ | Авто тээврийн тухай хууль, Боловсролын тухай хууль болон Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 05 дугаар сарын 07-ний өдрийн 161/229 тоот хамтарсан тушаалаар батлагдсан "Автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолоочийн шалгалт авах, үнэмлэх олгох журам"-ын дагуу "Автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолоочийн шалгалт авах, үнэмлэх олгох мэргэжлийн шалгалтын комиссыг "Зам тээврийн хөгжлийн сайд"-ын 2021.11.04-ны өдрийн А/176 дугаар тушаалаар шинэчлэн батлуулсан.<br>2022.12.10-ны байдлаар **31,439** жолоочоос давхардсан тоогоор **57,938** удаа шалгалт авч, **26,958** жолооч шалгалт тэнцсэнээс **14,922** жолоочид мэргэшсэн жолоочийн үнэмлэх хэвлэж олгосон. 2022 оны зорилтод түвшин тусгагдсан тоон үзүүлэлтээс давуулан биелүүлсэн. | 100 |
| 1.8 | Ачаа, зорчигч тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тээврийн байгууллагад сахилга хариуцлагыг дээшлүүлэх, тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангуулах ажлыг зохион байгуулах | 1.8.1. Улс, хот хоорондын зорчигч тээврийн жолооч нарт зориулсан мэдвэл зохих хууль, дүрэм, журам болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах талаар гарын авлага боловсруулах<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Гарын авлага бэлэн болж, жолооч нарт хүргэгдсэн байх<br>**Хугацаа:**<br>II-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Улс, хот хоорондын зорчигч тээврийн жолооч нар гарын авлагаар хангагдсан байна.** | - | ХУХ | Осол, саатал, зөрчлийг бууруулах зорилгоор улс, хот хоорондын зорчигч тээврийн жолооч нарт зориулсан мэдвэл зохих хууль, дүрэм, журам болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах талаар гарын авлагыг үндсэн 8 бүлэг 34 сэдвийн хүрээнд боловсруулж, 2000 ширхэг бэлтгэн гаргаж, 60 ААНБ-ын 1043 жолоочид тараасан. | 100 |
| | | 1.8.2 Онцгой нөхцөл байдал буюу зам тээврийн осол, цаг агаар замын нөхцөл байдлын хүндрэл болон техникийн эвдрэл, гэмтлээс шалтгаалсан саатал, бүх нийтийг хамарсан халдварт өвчний | - | ХУХ | Тайлант хугацаанд тээвэрлэлтийн үеийн саатал 363 бүртгэгдсэн бөгөөд цаг агаар, замын нөхцөл байдлаас шалтгаалсан 31, техникийн саатал 253, бусад төрлийн саатал 79 тус тус бүртгэгдсэн байна. Үүнд:<br>2022.03.22-24-ний өдрүүдэд Баян-Өлгий аймагт хүчтэй цасан болон шороон шуурга шуурч, цаг агаарын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | улмаас хөдөлгөөн хязгаарлагдсан тохиолдлуудад зорчигчдын аюулгүй байдлыг хангах чиглэлээр шуурхай ажиллагаа зохион байгуулах, нэгдсэн судалгаа гаргах<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Шуурхай арга хэмжээ авагдсан байх<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Тээвэрлэлтийн явцад гарсан осол, саатлын үед шуурхай арга хэмжээ зохион байгуулж, зорчигчдын ая тухтай зорчих нөхцөлийг хангаж мэдээллийг холбогдох газруудад мэдэгдсэн байна.** | | | хүндрэлээс шалтгаалан зорчигчдын амь нас, эрүүл мэндэд эрсдэл учирч болзошгүй нөхцөл үүссэн тул тээвэрлэлтийг шуурхай удирдлагаар хангах ажлыг зохион байгуулж 1 тээврийн хэрэгслийн 25 зорчигчийг Баян-Өлгий аймгийн Бураатын даваан зүүн талд Баян энгэр цайны газар байршуулж, 77 зорчигчтой 4 тээврийн хэрэгслийн тээвэрлэлтийг хойшлуулах арга хэмжээг авч ажилласан.<br>2022.04.10-ны өдөр нийт нутгаар орсон цасны улмаас бүх чиглэлийн замууд халтиргаа гулгаа үүссэн. Архангай аймгийн Түвшрүүлэх сумын нутагт байдаг Шар булгийн давааид халтиргаа хулгаа үүсч тээврийн хэрэгслүүд шороон замаар явж уруудах үедээ УБ-Ар.Эрдэнэбулган чиглэлд гарсан 86 зорчигчтой 2 автобус шаварт суусан. Аймгийн онцгой байдлын албаны Зил-131 маркийн тээврийн хэрэгсэл болон АЗЗА ажиллаж замыг хэвийн болгосон. Мөн Өвөрхангай аймгийн Хархорин сум гарах хөдөлгөөнөө түр хаасантай холбоотойгоор 2 чиглэлийн 65 зорчигчтой 2 автобусыг Архангай аймгийн төв дээр зочид буудалд байрлуулсан. 2 чиглэлийн 52 зорчигчтой 2 тээврийн хэрэгслийг Архангай аймгийн төв дээр түр зогсоож Шар булгийн даваа хэвийн болж Хархорин сум тээврийн хэрэгсэл хэвийн нэвтрүүлж эхэлмэгц 04:00 цагт чиглэлийн дагуу хөдөлгөөнөө үргэлжлүүлсэн.<br>Хойд болон баруун зүгийн нутгаар 2022.04.13-ны өдөр их хэмжээний цас орсны улмаас Дарханы Цайдамаас Хустайн даваа, Сэлэнгэ аймгийн Баянгол сумын хойд хэсгээр замын нөхцөл байдал хүндэрч, том оврын ачааны машинууд зам, гүүр хөндөлсөж түгжрэл үүссэн. Мөн хүчтэй цасан шуурга шуурч тээвэрлэлт гүйцэтгэхэд хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн тул зорчигчдын ая тухтай зорчих, аюул осолгүй тээвэрлэлт гүйцэтгэх зорилгоор болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлж 2022.04.13-ны өдрийн Да.Дархан-УБ-Да.Дархан, УБ-Да.Шарын гол, Ор.Баян Өндөр-УБ-Ор.Баян Өндөр, Хө.Мөрөн-УБ-Хө.Мөрөн, УБ-Бу.Булган чиглэлүүдэд 12:00 цагаас хойш тээвэрлэлт гүйцэтгэхээр төлөвлөгдсөн нийт 8 чиглэлийн 215 зорчигчтой 29 тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг цаг агаар, замын нөхцөл байдал сайжиртал түр хязгаарласан. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Өвөрхангай, Баянхонгор аймгийн нутгаар 2022.04.13-15-ны өдрүүдэд их хэмжээний нойтон цас орж, цасан шуурга шуурсаны улмаас Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сумаас Нарийнтээл сумын хоорондох улсын чанартай А0302 авто зам хаагдсан тул авто зам, замын байгууламжийг түр хаах ЗТХ-ийн сайдын тушаал гарч 2022.04.16-ны өдрийн 14:00 цаг хүртэл хаасан. Зам хаагдаж, тээвэрлэлт гүйцэтгэх боломжгүй болсонтой холбоотойгоор 2022.04.13-15-ны өдрүүдэд нийт 19 чиглэлийн 640 зорчигчтой 45 тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг цаг агаар, замын нөхцөл байдал сайжиртал түр хязгаарласан. Орон нутгаас тээвэрлэлтэд гарсан 125 зорчигчтой 3 чиглэлийн 5 тээврийн хэрэгслийг Баянхонгор аймагт, 44 зорчигчтой 3 тээврийн хэрэгслийг Говь-Алтай аймагт, Улаанбаатар хотоос тээвэрлэлтэд гарсан 194 зорчигчтой 5 чиглэлийн 8 тээврийн хэрэгслийг Өвөрхангай аймагт тус тус түр байршуулах, зорчигчдыг хоол унд, орон байраар хангах ажлыг зохион байгуулсан бөгөөд нийт 333 зорчигчтой 16 тээврийн хэрэгслийг /давхардсан тоогоор 27 тээврийн хэрэгслийн 653 зорчигч/ түр байршуулан холбогдох 25,887,000 төгрөгийн зардлыг даатгалын байгууллагаас гаргуулан ажилласан.<br>Нийт нутгаар 2022.10.07-08-ны өдрүүдэд их хэмжээний нойтон цас орж, цасан шуурга шуурсаны улмаас улсын чанартай А0603 дугаартай Цэцэрлэг–Тосонцэнгэл, А0902 дугаартай Булган–Мөрөн, А1002 дугаартай Эрдэнэт–Булган чиглэлийн авто зам хаагдсан тул авто зам, замын байгууламжийг түр хаах ЗТХ-ийн сайдын тушаал гарч 2022.10.08-ны өдрийн 10 цаг 00 минут хүртэл хаасан. Зам хаагдаж, тээвэрлэлт гүйцэтгэх боломжгүй болсон тул 391 зорчигчтой 13 тээврийн хэрэгслийг Архангай, Булган, Орхон, Дархан-Уул, Дундговь аймгууд дээр байрлуулан, зорчигчдыг хооллох үйл ажиллагааг зохион байгуулж, холбогдох зардал 18,696,190 төгрөгийг даатгалын байгууллагаас гаргуулсан. Мөн 281 зорчигчтой 7 тээврийн хэрэгслийг буцаан татсан болно.<br>Төвийн болон зүүн аймгуудын ихэнх нутаг, говийн аймгуудын хойд хэсгээр 2022.10.30-ны өдөр их хэмжээний нойтон цас орж, цасан шуурга шуурсаны улмаас Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Дорноговь аймгуудын зам хаагдаж, тээвэрлэлт гүйцэтгэх боломжгүй | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | болсон тул 288 зорчигчтой 7 тээврийн хэрэгслийг Хэнтий аймгийн Өндөрхаан, Жаргалтхаан, Цэнхэрмандал сумууд болон Багануур дүүрэгт байрлуулан, зорчигчдыг хооллох үйл ажиллагааг зохион байгуулж, 35 зорчигчтой 1 тээврийн хэрэгслийг буцаан татсан болно.<br>Дээрх тохиолдлуудад үйлдвэрийн газрын захирлын 2022.10.07-ны өдрийн А/251 тушаалаар батлагдсан "Шуурхай ажиллагаа зохион байгуулах журам", "Шуурхай ажиллагааны бүлэг", "Мэдээлэл дамжуулах бүдүүвч"-ийг мөрдлөг болгон холбогдох газруудтай мэдээлэл шуурхай солилцон ажилласан. | |
| | | 1.8.3 Тээвэрлэгч ААНБ-ын өвөлжилтийн бэлтгэл ажлын явц техникийн бэлэн байдлыг хангуулах, сааталгүй үйлчлэх нөхцөл бүрдүүлсэн байдлыг газар дээр нь шалгах<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Техникийн бэлэн байдал хангагдсан байх<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Гүйцэтгэлийн шалгалт зохион байгуулж техникийн бэлэн байдлыг хангуулсан байна.** | - | ХУХ | 2022.09.05-16-ны өдрүүдэд ЗТХЯ-тай хамтран Улаанбаатар хот болон орон нутагт байршилтай зорчигч тээврийн ААНБ-уудын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хэрхэн хангасан байдалд гүйцэтгэлийн шалгалт хийсэн. Шалгалтын хугацаанд нийт 59 ААНБ-ыг шалгаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. Үүнд:<br>Хангалттай- 36 ААНБ<br>Албан даалгавар хүргүүлсэн- 14 ААНБ<br>Хангалтгүй- 5 ААНБ<br>Тээвэрлэлт гүйцэтгээгүй -3 ААНБ<br>Дүгнүүлээгүй-1 ААНБ<br>Өвөлжилтийн бэлэн байдлыг гүйцэтгэлийн хяналт шалгалтаар 2022.10.06-07-ны өдрүүдэд Улаанбаатар хот болон орон нутгийн АТХУБ нар хот хоорондын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхэлж байгаа ААНБ-уудын тээврийн хэрэгсэлд өвөлжилтийн бэлэн байдлыг хэрхэн хангаж тээвэрлэлт гүйцэтгэж байгаад шугам замын хяналт шалгалт хийж ажиллалаа. Шалгалтаар зорчигч тээврийн 529 тээврийн хэрэгсэл шалгаж, зөрчилтэй 32 тээврийн хэрэгсэлд 6,065,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, 192 иргэнд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажилласан. | 100 |
| | | 1.8.4. Салбар, төв, ААНБ-уудад зорчигч, ачаа тээвэр, мэргэшсэн жолоочийн шалгалтын үйл ажиллагааны талаар холбогдох эрх зүйн акт, төрийн захиргааны төв байгууллагаас батлан гаргасан шийдвэрийн талаар сурталчлах, сургалт зохион | 30 сая.төг | ЗТХ, АТХ | 1.Зорчигч тээврийн чиглэлээр аж ахуйн нэгж байгууллагуудад 2022.02.17-ний өдөр "Өртөө тээвэр" болон "Нэг чиглэлд нэг үйлчилгээ"-ний үр ашиг, боломжууд сэдэвт цахим сургалтыг хийсэн бөгөөд сургалтад гэрээт 58 аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөл бүрэн хамрагдсан.<br>Мөн 21 аймгийн Автотээврийн төв болон 4 салбарын 160 ажилтан албан хаагчдад "Тээвэр зохицуулагч нарын үр | 90 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Зохион байгуулсан сургалтын тоо<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Төлөвлөгөөнд тусгагдсан 4 сургалт зохион байгуулсан байна.** | | | чадварыг нэмэгдүүлэх, ухаалаг тээврийн системийг хөгжүүлэх" тухай онол, практик хослуулсан бүсчилсэн сургалтыг үе шаттайгаар зохион байгуулсан.<br>2. Мэргэшсэн жолоочийн чиглэлээр "Автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолооч бэлтгэх, мэргэшил дээшлүүлэх" сургалт явуулах зөвшөөрөл бүхий хот, орон нутгийг хамарсан 61 ААНБ-уудад цахим сургалтыг хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. Мөн Мэргэшсэн жолоочийн шалгалт зохион байгуулан авч байгаа аймгийн автотээврийн төвүүд дэх шалгалт хариуцсан 30 гаруй ажилтан албан хаагчидтай цаг үеийн асуудлаар онлайн | |
| | | | | | уулзалт, хэлэлцүүлгийг 2022.12.02-ний өдөр зохион байгуулж, мэргэшсэн жолоочийн шалгалтын үйл ажиллагааны талаар холбогдох эрх зүйн акт, төрийн захиргааны төв байгууллагаас батлан гаргасан шийдвэрийн талаар сурталчлан таниулан, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч мөн цаг үеийн болон ойлголтын зөрүүтэй асуудлуудын талаар санал авч нэгтгэн шийдвэрлүүлсэн.<br>3. Ачаа тээврийн чиглэлээр 2022.10.06-ны өдөр Өмнөговь аймгийн Гашуунсухайт-Ганц мод боомтын чиглэлд үйл ажиллагаа эрхэлдэг ачаа тээврийн нийт 85 ААНБ-уудын 93 ажилтанд "Тохирлын гэрчилгээ"-ний талаар сургалт зохион байгуулсан. Мөн Өмнөговь аймгийн Гашуунсухайт-Ганц мод боомтын чиглэлд үйл ажиллагаа эрхэлдэг нийт 213 ААНБ-уудад 2023 оны 1-р улирлын зөвшөөрлийн бичийн олголтын зохион байгуулалтын талаарх сургалтыг 2022.11.30-ны өдөр цахимаар зохион байгуулсан. | |
| | | | | | Ачаа тээврийн үйл ажиллагааг сурталчлах ажлын хүрээнд хийх ажлын төлөвлөгөө гарган олон нийтийн сүлжээгээр мэдээлэл өгч ажиллаж байна. 2022.12.10-ны байдлаар тус хэлтсийн үйл ажиллагааг сурталчлах 3 мэдээ /Улс хоорондын ачаа, авто үйлчилгээ, терминал/-г олон нийтийн сүлжээнд байршуулан ажилласан. Мөн авто үйлчилгээний талаарх ярилцлагыг www.ubn.mn сайтад 2022.10.20-ны өдөр өгсөн. | |
| 1.9 | Автотээврийн ажил үйлчилгээнд тавих төрийн хяналтыг тус | 1.9.1 ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын баталсан "Автотээврийн хяналтын чиглэлээр 2022 онд хамтран | - | ХУХ | ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын баталсан "Автотээврийн хяналтын чиглэлээр "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-тай хамтран ажиллах 2022 оны | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | яамтай байгуулсан “Автотээврийн хяналтыг хамтран хэрэгжүүлэх” гэрээний дагуу хэрэгжүүлэх; | ажиллах төлөвлөгөө”-ний биелэлтийг ханган ажиллах<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Төлөвлөгөө батлагдаж, түүний хэрэгжилтийн хувиар<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Төлөвлөгөөний хэрэгжилт хангагдсан байна.** | | | хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгасан 24 ажил бүгд хийгдэж, төлөвлөгөө 100 хувийн гүйцэтгэлтэй байна.<br>Тус үйлдвэрийн газрын Автотээврийн хяналтын улсын байцаагч нар 2022 оны жилийн эцсийн байдлаар 98337 жолооч, 173430 тээврийн хэрэгсэл, 194232 зорчигч шалгаснаас 9159 зөрчил илрүүлж, 7577 зөрчлийг газар дээр нь арилгуулж, 86 хуулийн этгээдэд 51.550.000, 1607 иргэнд 153.30.5000 буюу нийт 1693 зөрчилд 204.855.000 төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ оногдуулсан байна. 41 аж ахуйн нэгж байгууллагад зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж, 16368 иргэнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн байна. | |
| 1.10 | Техникийн хяналтын үзлэгийг тус яамтай байгуулсан “Автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажил эрхлэх гэрээ”-ний дагуу гүйцэтгэх; | 1.10.1 Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийх үйл ажиллагааг жилийн турш жигд зохион байгуулж, замын хөдөлгөөнд оролцож буй нийт тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт хамруулах<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан тээврийн хэрэгслийн тоо<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**617186 тээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэгт хамруулсан байна.** | - | ТХХ | Техникийн хяналтын үзлэгийг суурин болон явуулын 51 төвөөр дамжуулан 2022.12.10-ны өдрийн байдлаар 581,431 /94%/ тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт хамруулсан.<br>ЗТХЯ-ны улсын ахлах байцаагчийн 2022.01.17-ний өдрийн 38-07-001/006 тоот дүгнэлт, шалгалтын ажлын хэсгээс гаргасан санал, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/83 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн 2022.01.24-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022.01.28-ны өдрийн А/19 дүгээр тушаалаар үйлдвэрийн газрын Улаанбаатар хот дахь Баянгол, Сонгинохайрхан, Баянзүрх техникийн хяналтын үзлэг төв, Төв аймгийн Автотээврийн төвийн автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажил эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн.<br>ЗТХЯ-ны улсын ахлах байцаагчийн дүгнэлтийн дагуу тус үйлдвэрийн газраас зөрчлийг арилгах талаар төлөвлөгөө гаргаж, тодорхой ажил зохион байгуулж, яаманд тайланг хүргүүлсэн.<br>Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022.02.11-ний өдрийн А/27 дугаар тушаалаар үйлдвэрийн газрын Улаанбаатар хот дахь Баянгол, Сонгинохайрхан, Баянзүрх техникийн хяналтын үзлэг төв, Төв аймгийн Автотээврийн төвийн автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажил эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээсэн. | 90 |
| | | 1.10.2 Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээ (RFID)-г бүрэн | | ТХХ<br>ТХБХ<br>МТХ | Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.4-д “Автотээврийн үйлчилгээнд RFID | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | нэвтрүүлж, татвар даатгал, төлбөр тооцоо, бүртгэл хяналтын үйл ажиллагааг сайжруулах<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>/RFID/ ялтасыг автомашинуудад суурилуулах ажил эхэлсэн байх<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Улаанбаатар хотод бүртгэлтэй нийт автомашины 30-аас доошгүй хувьд RFID ялтсыг суурилуулсан байна.** | | | /Радио давтамжийг таних төхөөрөмж/ системийг нэвтрүүлэх" гэж заасны дагуу тус үйлдвэрийн газраас 2017 онд судалгаа хийж, уг системийг эхний ээлжинд Өмнөговь аймгийн Гашуун сухайт боомтын чиглэлд нэвтрүүлэхээр шийдвэрлэсэн.<br>Тус үйлдвэрийн газрын 2018 оны хөрөнгө оруулалтаар 4 ширхэг шошго уншигч RFID төхөөрөмж худалдан авсан. 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд RFID төхөөрөмжид шаардлагатай 8000 ширхэг шошго худалдан авахад шаардагдах зардлын саналыг тусган, ТӨБЗГ-т 2018.11.16-ны өдрийн 1/2292 тоот албан бичгээр хүргүүлж, ТӨБЗГ-ын 2018.12.18-ны өдрийн хуралдаанаар батлуулсан. Худалдан авах ажиллагааг зарлаж, шалгарсан компанитай гэрээ байгуулан, гэрээний дагуу 8000 шошгыг хүлээн авсан.<br>ЗТХЯ-ны урд зогсоолын нэвтрэх болон гарах хаалтан дээр туршилтын систем суурилуулан ЗТХЯ, АТҮТ-ийн 200ш тээврийн хэрэгсэл дээр туршилтын ажлыг хийсэн.<br>Үйлдвэрийн газрын 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 26 ширхэг RFID уншигч төхөөрөмж тусгагдсан боловч ТӨБЗГ-ын 2020.04.06-ны өдрийн А-1/574 дугаар албан даалгаврын дагуу энэхүү худалдан авах ажиллагааг зогсоож, 2020 онд хэрэгжих боломжгүй болсон.<br>Иймд үйлдвэрийн газраас Нийслэлийн засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Мэдээлэл технологийн газарт уншигч төхөөрөмжийг шийдвэрлүүлэх тухай хүсэлт явуулсан. Тус газраас RFID уншигч төхөөрөмжийг худалдан авах ажлыг зохион байгуулан, нэгдсэн програм хангамж тоног төхөөрөмж нийлүүлэх хаалттай тендер зарлаж, гүйцэтгэх компани шалгарсан тухай мэдэгдсэн.<br>Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2021 оны А/491 дүгээр захирамжаар "Нийслэл хотын хэмжээнд замын хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгсэлтэй холбоотой харилцааг технологийн шийдлийн тусламжтайгаар сайжруулах, зам, тээврийн ухаалаг нэгдсэн системийг нэвтрүүлэхэд шаардлагатай судалгаа тооцоог гаргах, техникийн даалгавруудыг нэгтгэх ажлыг хэрэгжүүлэх" үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд тус ажлын хэсгээс Улаанбаатар хотын шалган нэвтрүүлэх 7 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | товчоо болон нийслэлийн авто замын 153 уулзварт RFID төхөөрөмжүүд болон хяналтын камеруудыг суурилуулахаар ажиллаж байгаа.<br>2021 онд тус үйлдвэрийн газар нь зам, тээврийн салбарын харьяа байгууллагуудад ашиглагдаж буй тээврийн хэрэгслийн жагсаалтыг авч, шошго байршуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Мөн өөрсдийн нөхцөл боломжид тулгуурлан Улаанбаатар хотын Сонгинохайрхан техникийн хяналтын үзлэгийн төвд RFID уншигч төхөөрөмж суурилуулсан бөгөөд ААНБ-уудын том оврын автобуснуудад шошго байршуулах ажлыг хийж байна.<br>2022 онд Монгол улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоолын 4 дэх заалтын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд "Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээ /RFID/-г урьдчилан бэлтгэх, тээврийн хэрэгсэлд байрлуулах, бүртгэх үйл ажиллагааны 2022 оны нарийвчилсан төлөвлөгөө"-ний санал авах бичиг ЗТХЯ-наас 2022.02.18-ны өдрийн 04/728 тоотоор ирүүлсэн бөгөөд санал хүргүүлэн хамтран ажиллаж байна. Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан тээврийн хэрэгсэлд RFID шошго суурилуулах" ажлын хэсэг ЗТХЯ дээр байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд үйлдвэрийн газраас шаардлагатай мэдээллүүдийг гарган ажлын хэсэгт орж хамтран ажиллаж байна.<br>Ажлын хэсгээс RFID шошгоны загварыг батлан шошго нийлүүлэх сонгон шалгаруулах ажлыг Албан журмын даатгагчдын холбоотой хамтран зохион байгуулах бөгөөд 2023 оны 1-р улиралд тээврийн хэрэгслүүдэд байршуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна. | |
| 1.11 | Жил бүрийн зорилтот түвшинд авто буудал, техникийн хяналтын үзлэгийн төвийн барилга барих хөрөнгийг тусган батлуулж хэрэгжүүлэх, орон нутагт авто замын | 1.11.1 Ховд болон Орхон аймагт автобуудлын барилгыг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд барьж байгуулах<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:** | Төр хувийн хэвшлийн түншлэл | ЗСХНХ | Орхон аймгийн автотээврийн төвийн автобуудлын барилгын ажлыг тус аймгийн орон нутгийн санхүүжилтээр 2022-2023 онд барьж байгуулахаар төлөвлөж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг цахим хэлбэрээр 2022.01.18-ны өдөр зарлаж, 2022.02.18-ны өдөр нээсэн. Тендерт оролцогч "Шинжүү" ХХК шалгарсан. Гэрээний дагуу барилгын ажлыг 2022.05.18-ны өдөр эхлүүлсэн бөгөөд 621 м.кв талбайн суурийг ухаж ул бетон авах бэлтгэл ажил төлөвлөгөөний дагуу хийгдэж байна. | 50 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | дагуух үйлчилгээний цогцолбор, тээвэр логистикийн төв, терминал барьж байгуулах чиглэлээр Аймгийн Засаг дарга нар болон бусад байгууллагуудтай хамтран ажиллах; | **2 аймгийн Автобуудлын барилгыг ашиглалтад оруулсан байна.** | | | 2022.12.10-ны өдрийн байдлаар барилгын ажил 20 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Зоорийн болон 1-р давхар цутгагдсан. 2022 оны төлөвлөгөөт ажил хийгдэж, дууссан.<br>"Зорчигч тээврийн Ховд" ХХК нь компани гв өөрийн хөрөнгө оруулалтаар Ховд аймагт автобуудал барьж байна. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 85%-тай байна. | |
| | | 1.11.2 Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд улсын чанартай авто замын дагуу 150-200 км тутамд үйлчилгээний цогцолбор байгуулах<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Байгуулсан цогцолборын тоо<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин: Үйлчилгээний цогцолбор байгуулсан байна.** | 60 сая.төг Төр хувийн хэвшлийн түншлэл | ЗТХ ЗСХНХ | ЗТХЯ, БОАЖЯ, ХАҮТ-ын хамтарсан Ажлын хэсэг 2022.04.15-ны өдөр хуралдаж Архангай аймгийн Цэнхэр сум, Увс аймгийн Зүүнхангай сум, Хэнтий аймгийн Жаргалтхаан сум, Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумдад замын дагуух цогцолбор байгуулах 4 аж ахуйн нэгжийн ирүүлсэн санал, ТЭЗҮ, санхүүжилтийн асуудлыг хэлэлцэж, 2022.04.21-ний өдөр МҮХАТанхим "Заяын өгөөж" ХХК, "Драгон" холдинг, "Исун мод тур" ХХК, "Баян дойт" ХХК -тай хамтран ажиллах гэрээг байгуулсан.<br>Булган аймгийн Рашаант суманд байрлалтай "Хаан бууз" зам дагуух цогцолбороор баруун аймгийн 30 чиглэлд зорчиж буй иргэдэд үйлчлэн ажиллаж байна.<br>2022 онд Увс аймгийн Сонгино суманд байрлалтай "Нутаг-Ус" цогцолбор ашиглалтад орсонтой холбогдуулан Хамтран ажиллах гэрээ"-г байгуулан байнгын хяналт тавин ажиллаж байна. | 70 |
| 1.12 | Тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох үйл ажиллагааг зохих журамд заасны дагуу иргэдэд хүртээмжтэй, шуурхай хүргэх, цахим хэлбэрээр зохион байгуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах; | 1.12.1 Автотээврийн хэрэгслийн гэрчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Гэрчилгээ цахим хэлбэрт шилжсэн байх<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Цахим гэрчилгээг ашиглаж, цахимаар үйлчилгээ авах боломжийг бүрдүүлсэн байна.** | - | ТХБХ МТХ | Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээний үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсэгт холбогдох саналыг хүргүүлсэн.<br>Мөн автотээврийн хэрэгслийн цахим гэрчилгээний загвар болон техникийн шийдлийг боловсруулан 2022.10.18-ны өдөр ЗТХЯ-ны АТБХЗГ-т хүргүүлсэн. Цахим гэрчилгээг иргэд болон аж ахуйн нэгж байгууллагуудад цахимаар хүргэхээр бэлэн болсон. | 70 |
| | | 1.12.2 Төрийн цахим мэдээлэл солилцох системд холбох төрийн үйлчилгээний жагсаалтад тусгагдсан автотээврийн | | ТХБХ МТХ | Төрийн цахим мэдээлэл солилцох системд холбох төрийн үйлчилгээний жагсаалтад тусгагдсан автотээврийн салбарын үйлчилгээ, үйл ажиллагааг цахимжуулах хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2022 оны жилийн эцсийн | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | салбарын үйлчилгээ, үйл ажиллагааг цахимжуулах хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Жагсаалтад багтсан тээврийн хэрэгслийн бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулах<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Олон нийтэд сурталчлах, төрийн мэдээллийн нэгдсэн цонх (E-Mongolia)-той холбосон байна.** | | | байдлаар E-Mongolia системээс дараахь үйлчилгээг авах боломжийг бүрдүүлсэн.<br>1. Автотээврийн хэрэгсэл эзэмших, өмчлөх эрхийн лавлагаа (ААН өмнө өмчилж байсан)<br>2. Автотээврийн хэрэгсэл эзэмших, өмчлөх эрхийн лавлагаа (ААН одоо эзэмшиж байгаа)<br>3. Автотээврийн хэрэгсэл эзэмших, өмчлөх эрхийн лавлагаа (Иргэн одоо эзэмшиж байгаа)<br>4. Автотээврийн хэрэгсэл эзэмших, өмчлөх эрхийн лавлагаа (Иргэн өмнө өмчилж байсан)<br>5. Улс хоорондын ачаа тээвэрлэлтийн зөвшөөрлийн хүсэлт<br>6. Жуулчин тээврийн үйлчилгээ<br>7. Авто тээврийн хэрэгслийн гэрчилгээ солих үйлчилгээ<br>8. Авто тээврийн хэрэгслийн торгуулийн мэдээлэл<br>9. Мэргэшсэн жолоочийн үнэмлэхийн лавлагаа<br>10. Мэргэшсэн жолоочийн үнэмлэх нөхөн олгох хүсэлт хүлээн авах<br>11. Тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн<br>12. Автотээврийн хэрэгслийн гэрчилгээ нөхөн олгох хүсэлт<br>13. Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн лавлагаа<br>14. Техникийн хяналтын үзлэгийн мэдээлэл харах<br>15. Автотээврийн хэрэгслийг улсын бүртгэлээс хасуулах хүсэлт зэрэг үйлчилгээ, лавлагааг авах боломжтой юм.<br>Энэ талаар үйлдвэрийн газрын албан ёсны фэйсбүүк пэйж хуудсанд байршуулж, олон нийтэд мэдээлсэн. | |
| | | 1.12.3 Тээврийн хэрэгслийн бүртгэлийн программд нотариат, гааль, татвар, даатгал зэрэг байгууллагуудын сервирийг холбон иргэдэд цахимаар бүртгэлийн үйл ажиллагааг явуулах боломжийг бүрдүүлэх<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Цахимаар хүргэсэн үйлчилгээний тоо<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:** | - | ТХБХ<br>МТХ | Тээврийн хэрэгслийн бүртгэлийн програмд нотариатын сервис холбож дууссан. Уг сервисийг холбосноор иргэн гэрээний материал цаасаар авчирах шаардлагагүй болсон бөгөөд тухайн иргэнтэй хийсэн гэрээг цахимаар солилцдог болсон. Мөн бүртгэлийн мэргэжилтний ажлын үр бүтээмжийн дээшлүүлж аливаа хуурамч бичиг баримт, залилангаас хамгаалах үр ашигтай ажил болсон. Програмчлалын хувьд нотариатын сервистэй холбогдсоноор цахим маягт дээр тухайн А-тал, Б-талын мэдээллийг бүртгэлийн цахим архивт давхар хадгалж PDF форматаар автоматаар хадгалж архивладаг болсон. Тээврийн хэрэгслийн бүртгэлийн үйлчилгээг цахимжуулах ажлын хүрээнд холбогдох төрийн байгууллагууд болох Гаалийн ерөнхий газар, Татварын | 90 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | **Олон нийтэд хүргэж, сурталчилсан байна.** | | | ерөнхий газар, Тээврийн цагдаагийн алба, Монголын нотариатчдын танхимтай тээврийн хэрэгслийн бүртгэлийн системээр холбогдон мэдээлэл солилцож байна.<br>2022.05.20-ноос нотариатын сервесийг бүрэн холбож үйл ажиллагаанд нэвтрүүлсэн бөгөөд 2022.12.15-ны өдрийн байдлаар иргэд, ААНБ-д 79819 үйлчилгээг үзүүлсэн байна.<br>2022 оны 4-р улирлын байдлаар тээврийн хэрэгслийн албан журмын даатгал болон тээврийн хэрэгслийн даатгалыг холбох сервис хүлээгдэж байна.<br>2022.12.15-ны өдрийн байдлаар нийт 3089 иргэн, хуулийн этгээд цахим лавлагаа авсан. Олон нийтийн цахим сүлжээ болон И-Монголиагийн цахим хуудсаар иргэд олон нийтэд мэдээлж ажилласан. | |
| | | 1.12.4 Тээврийн хэрэгслийн бүртгэлийн үйл ажиллагаанд тоон гарын үсгийг нэвтрүүлэх<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Бүртгэлийн үйл ажиллагаанд тоон гарын үсэг нэвтэрсэн байх<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Цахим гарын үсгийн хүсэлт хүлээн авч эхэлсэн байна.** | - | ТХБХ МТХ | Тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн хийхэд шаардлагатай сервис солилцох тоон гарын үсгээр баталгаажсан албан хүсэлтийг хүлээн авч, гэрчилгээний төлбөрийг цахимаар гүйцэтгэх боломжийг бүрдүүлсэн.<br>Тээврийн хэрэгслийн бүртгэлийн VRS систем дээр цахим хүсэлтийн хөгжүүлэлтийг бүрэн хийж дуусгасан.<br>Тоон гарын үсгийн тест хийгдэж программ хөгжүүлэлт хийгдэж дууссан.<br>Монгол Улсын Засгийн Газраас баталсан Алсын хараа-2050 хөгжлийн бодлого, төрийн үйлчилгээг цахимжуулах ажлын хүрээнд Зам тээврийн хөгжлийн яам, "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ болон "ЭЙ АЙ ЛАБ" ХХК хамтран авто тээврийн хэрэгслийн өмчлөл шилжүүлэх үйлчилгээнд анх удаа цахим гарын үсгээр баталгаажилт хийх цахим системийг нэвтрүүллээ.<br>Банк санхүүгийн байгууллагуудаас "Инвескор" ББСБ нь өөрийн үйлчилгээндээ тоон гарын үсэг, цахим шилжилт хөдөлгөөний үйлчилгээг нэвтрүүлээд байна.<br>ЗТХС-ын 2020.11.18-ны өдрийн А/8222 тоот тушаалаар баталсан "Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх улсын дугаар олгох журам"-д нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулан ЗТХЯ-ны АТХБЗГ-т хүргүүлсэн. Тус газраас журмын урьдчилсан хэлэлцүүлэг зохион байгуулж, сайдын тушаалын төслийг яамны удирдлагуудад танилцуулан санал авч байна. | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Тээврийн хэрэгслийн өмчлөл шилжүүлэхтэй холбоотой тоон гарын үсгээр баталгаажсан цахим хүсэлт илгээх технологийн боломж бүхий цогц системийг боловсруулан хөгжүүлэх ажлын хүрээнд эхний ээлжинд "Инвескор" ББСБ-тай туршилтын гэрээг байгуулан цахим хүсэлтийг 2022 оны 7 дугаар сард нэвтрүүлсэн.<br>2022.12.10-ны өдрийн байдлаар системд нийт 529 цахим хүсэлт ирүүлснээс 365 цахим хүсэлтийг шийдвэрлэсэн байна. | |
| | | 1.12.5 Автотээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээлэл лавлагааг өмчлөгч, эзэмшигч болон эрх бүхий хууль хяналтын байгууллага цахимаар авах нөхцлийг бүрдүүлэх<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Ажлын явц<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин: Хуулийн этгээд, болон эрх бүхий хууль хяналтын байгууллагууд тээврийн хэрэгслийн лавлагааг нотлох баримтын хэмжээнд авах нөхцлийг бүрдүүлсэн байна.** | - | ТХБХ<br><br>МТХ | Төрийн цахим мэдээлэл солилцох системд холбох төрийн үйлчилгээний жагсаалтад тусгагдсан автотээврийн салбарын үйлчилгээ, үйл ажиллагааг цахимжуулах хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2022 оны жилийн эцсийн байдлаар E-Mongolia системээс дараахь мэдээлэл, лавлагааг авах боломжийг бүрдүүлсэн.<br>1. Автотээврийн хэрэгсэл эзэмших, өмчлөх эрхийн лавлагаа (ААН өмнө өмчилж байсан)<br>2. Автотээврийн хэрэгсэл эзэмших, өмчлөх эрхийн лавлагаа (ААН одоо эзэмшиж байгаа)<br>3. Автотээврийн хэрэгсэл эзэмших, өмчлөх эрхийн лавлагаа (Иргэн одоо эзэмшиж байгаа)<br>4. Автотээврийн хэрэгсэл эзэмших, өмчлөх эрхийн лавлагаа (Иргэн өмнө өмчилж байсан)<br>5. Мэргэшсэн жолоочийн үнэмлэхийн лавлагаа<br>6. Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн лавлагаа<br>"Төрийн мэдээллийн сангаас гарах лавлагаа, тодорхойлолтын нэгдсэн маягт"-ын дагуу дараах лавлагаануудыг иргэн болон ААНБ-уудад хүргэхээр 2022.11.08-ний өдрийн 2/361 тоот албан бичгээр И-Монгол академид хүсэлт хүргүүлээд байна.<br>Тус үйлдвэрийн газраас үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд иргэн болон хуулийн этгээдэд дараах үйлчилгээгээр лавлагаа авах боломж бүрдэх юм.<br>• Улс болон хот хоорондын зорчигч тээврийн тасалбарын лавлагаа<br>• Зорчигч болон ачаа тээврийн үйл ажиллагаа эрхлэгч ААНБ-ын лавлагаа<br>• Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын дүгнэлтийн хуудас лавлагаа | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | • Авто үйлчилгээний ангилал бүхий ААНБ-ын лавлагаа<br>• Жуулчин тээвэр гүйцэтгэх эрх бүхий ААНБ-ын лавлагаа<br>• Шинэ тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт бүртгэх хүсэлт илгээх /гаалийн бичиг, техникийн дагалдах бичиг баримт/<br>Тохирлын гэрчилгээтэй ААНБ-ын лавлагаа<br>Ast vision компаниас мэдээллийн сангаас гарах лавлагаа, тодорхойлолтын нэгдсэн маягт олгох үйлчилгээг нэвтрүүлсэн. Үүний дагуу үйлдвэрийн газар нь дээрх үйлчилгээнүүдийг нэвтрүүлж, Е-Монголиад холбоно. | |
| 1.13 | Зам, тээврийн хөгжлийн яамны захиалгаар болон гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний хүрээнд чиглэл тус бүрээр төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус судалгаа хийж, яам болон бусад төрийн байгууллагуудыг мэдээллээр хангах | 1.13.1 Автотээврийн хэрэгсэлд суурилуулах утаа шүүгчийг дотоодод үйлдвэрлэх боломжийг судлах<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Судалгааны хэрэгжилтийн хувиар<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Редакцийн саналыг тусгаж, эцсийн шатны тайланг ЗТХЯ-нд хүргүүлсэн байна.** | - | СХЧУТ | Судалгааны ажлын даалгаврын хүрээнд мэдээлэл цуглуулж эхний шатны тайланг боловсруулан 2022.02.23-ны өдрийн 1/239 тоот албан бичгээр ЗТХТ-д хүргүүлсэн. ЗТХТ-өөс судалгааны ажлын эхний шатны тайланг нэгтгэж, ЗТХЯ-нд хүргүүлсэн.<br>ЗТХЯ-наас ирсэн санал зөвлөмжийг тусгаж, эцсийн шатны тайланг 2022.10.03-ны өдрийн 1/1231 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлж, тайлагнасан. | 100 |
| | | 1.13.2 Гашуунсухайт боомтын чиглэлд ачаа тээвэрлэлт гүйцэтгэж байгаа тээврийн хэрэгсэлд байгаль орчинд ээлтэй технологи суурилуулах боломжийн талаар судалгаа хийх<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Судалгааны хэрэгжилтийн хувиар<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Редакцийн саналыг тусгаж, эцсийн шатны тайланг ЗТХЯ-нд хүргүүлсэн байна.** | - | СХЧУТ | Гашуунсухайт боомтын чиглэлд ачаа тээвэрлэлт гүйцэтгэж байгаа тээврийн хэрэгсэлд байгаль орчинд ээлтэй технологи суурилуулах боломжийг судлах судалгааны ажлын дизайныг 5 бүлэг, 23 дэд бүлэгт хуваан боловсруулсан.<br>Судалгааг нийслэлийн нийтийн тээвэр, хийн түлш борлуулагч ААНБ, тээврийн хэрэгсэл, автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, холбогдох хууль, стандарт, журам, олон улсын туршлага зэргийг хамруулж гүйцэтгэсэн.<br>Төлөвлөгөөт хугацаандаа судалгааны тайланг ЗТХЯ-нд 2022 оны 1/831 тоот албан бичгээр хүргүүлж, хэрэгжилт үр дүнг тайлагнасан. | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 1.13.3 Хот хоорондын зорчигч тээвэр төлөвлөлтийн математик загварчлал боловсруулах.<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Судалгааны хэрэгжилтийн хувиар<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Редакцийн саналыг тусгаж, эцсийн шатны тайланг ЗТХЯ-нд хүргүүлсэн байна.** | - | СХЧУТ | Хот хоорондын зорчигч тээвэр төлөвлөлтийн математик загварчлал боловсруулах" судалгааны ажлын дизайныг 5 бүлэг 32 гүйцэтгэх ажлын дэлгэрэнгүй төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байна. Үүнд:<br>- Олон улсын туршлага<br>- Хот хоорондын зорчигч тээвэр төлөвлөлтийн хууль эрх зүйн орчин<br>- Хот хоорондын зорчигч тээвэр төлөвлөлтийн өнөөгийн байдал<br>- Хөдлөх бүрэлдэхүүний тоон болон чанарын үзүүлэлтүүдэд тодорхойлох статистик шинжилгээ хийн үр дүнг боловсруулах<br>- Хот хоорондын зорчигч тээвэр төлөвлөлтийг сайжруулах аргачлал<br>Суурь судалгаар гаргаж судалгааны тайланг 2022 оны 1/832 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлж, тайлагнасан. | 100 |
| | | 1.13.4 ЗТХЯ болон үйлдвэрийн газрын гадна талбайд байрлуулсан нарны эх үүсвэрийн туршилт судалгааны ажил гүйцэтгэх<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Судалгааны хэрэгжилтийн хувиар<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Редакцийн саналыг тусгаж, эцсийн шатны тайланг ЗТХЯ-нд хүргүүлсэн байна.** | - | СХЧУТ | "ЗТХЯ-ны гадна талбайд 40квт нарны эх үүсвэр суурилуулах" төслийн гүйцэтгэгч "Дүйнхэр тэргүүн" ХХК-тай хамтран судалгааны ажлыг эхлүүлсэн.<br>Судалгааны ажлын даалгаврын хүрээнд ONGRID системийн цахилгаан үйлдвэрлэлийн өдөр тутмын үзүүлэлт, туршилтын хугацаан дах Улаанбаатар хотын цаг уур, агаарын бохирдолын хэмжээ, явган замын халаалтын системийн ажиллагаа зэрэг мэдээллийг цуглуулсан. Мөн нарны хавтан дээр унасан цас, түүний цэвэрлэх арга технологи зэргийг судлан боловсруулж байна. Тус яамны эрчим хүчний хэрэглээний талаар дэлгэрэнгүй мэдээллийг Засгийн газрын байрнуудын нийтлэг үйлчилгээний газар УТҮГ-аас авч судалгааны мэдээлэл боловсруулалт хийж байна. ЗТХЯ-нд 1/736 тоот албан бичгээр хугацаа сунгах хүсэлт явуулсан.<br>Судалгааны ажлын эцсийн шатны тайланг боловсруулан төлөвлөгөөт хугацаанд хүргүүлэхээр ажиллаж байна.<br>Судалгааны ажлын гүйцэтгэл 90 хувьтай хэрэгжиж байгаа бөгөөд хүлээгдэж буй гүйцэтгэлээр эцсийн шатны тайланг төлөвлөгөөт хугацаанд хүргүүлэхээр ажиллаж байна. | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1.14 | Автотээврийн салбарын ажил үйлчилгээнд баталгаат үйлчилгээний тогтолцоог нэвтрүүлэх; | 1.14.1 Нийтийн зорчигч тээвэр болон автотээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуй нэгж, байгууллагад тохирлын үнэлгээ хийж, баталгаажуулалтын шийдвэр гаргах<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Тохирлын үнэлгээ хийж, баталгаажуулалтын шийдвэр гарсан ААНБ-ын тоо<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Өссөн дүнгээр хүсэлт ирүүлсэн 21-ээс доошгүй ААНБ-д үнэлгээ хийж шийдвэр гарсан байна.** | - | СХЧУТ | Тайлант хугацаанд нийт 112 иргэн, ААНБ тохирлын үнэлгээ хийлгэх өргөдөл ирүүлсэн. Дээрх өргөдөл, холбогдох баримт бичигт дүн шинжилгээ хийж, баталгаажуулалтын үнэлгээг хийх боломжгүй 10, боломжтой 102 шийдвэр гаргасан байна. Баталгаажуулалтын үнэлгээг явуулах боломжтой нийт 87 иргэн, ААН-ийн үйлчилгээнд баталгаажуулалтын үнэлгээг хийж баталгаажуулалтын схемийн шаардлагыг хангасан 32 ААН-д тохирлын гэрчилгээ олгосон байна. | 100 |
| | | 1.14.2 Салбарын хэмжээнд ашиглагдаж байгаа хэмжих хэрэгсэлд Олон улсын нэгжийн СИ системийн дагуу нэгж дамжуулах<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Шалгалт тохируулга хийсэн хэмжих хэрэгслийн тоо<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Өссөн дүнгээр 486-аас багагүй хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга хийсэн байна.** | - | СХЧУТ | Үйлдвэрийн газрын техникийн хяналтын төвүүдэд нийт 428 ширхэг багажид шалгалт тохируулга хийж, хэмжил зүйн шаардлага хангуулан гэрчилгээ олгосон.<br>Мөн хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга хийлгүүлэхээр хүсэлт ирүүлсэн 12 ААНБ-ын 58 ширхэг багажид хэмжил зүйн ажил үйлчилгээ үзүүлж 1187700 төгрөгийг үйлдвэрийн газрын дансанд төвлөрүүлсэн. | 90 |
| 1.15 | Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох ажлыг зохих журамд заасны дагуу аймаг, орон нутагт зохион байгуулах; | 1.15.1. Авто үйлчилгээний байгууллагуудын судалгааг авч бүртгэлжүүлэх<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Судалгааг гаргаж, яамыг мэдээллээр хангасан байх<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин: Судалгааны үр дүнг яаманд тайлагнасан байна.** | | АТХ | Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй авто үйлчилгээ эрхлэгчдийг бүртгэлжүүлэх зорилгоор 2022 оны 06 дугаар сард судалгаа хийсэн. Судалгааг 2022.06.07-ны өдөр ЗТХЯ-ны авто үйлчилгээ хариуцсан мэргэжилтэнд цахимаар хүргүүлсэн.<br>Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй авто үйлчилгээ эрхлэгчдийг бүртгэлжүүлэх зорилгоор судалгааны маягт боловсруулан, Аймгийн Автотээврийн төвүүдэд хүргүүлж, судалгааг нэгтгэж авсан. Аймгийн төвүүдэд үйл ажиллагаа явуулдаг 99 ААНБ, 366 иргэн буюу нийт 465 авто үйлчилгээ эрхлэгч байна. Үүнээс агрегат засварын | 90 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үйлчилгээ үзүүлдэг 109, кузов засвар 36, явах эд ангийн засвар 145, цахилгаан засвар 38, дугуй засвар 81, авто угаалга 157, тос тосолгоо сэлбэгийн худалдаа 194, авто зогсоол 14, оёдол доторлогоо 6 тус тус үйл ажиллагаа явуулж байна.<br>Аймаг бүрээр авч үзвэл Архангай 41, Баян-Өлгий 17, Баянхонгор 18, Булган 6, Говь-Алтай 37, Говьсүмбэр 12, Дархан-Уул 35, Дорноговь 8, Дорнод 23, Дундговь 18, Завхан 22, Орхон 53, Өвөрхангай 24, Өмнөговь 30, Сүхбаатар 21, Сэлэнгэ 23, Төв 7, Увс 9, Ховд 14, Хөвсгөл 10, Хэнтий 13, Замын-Үүд 11, Цогтцэций 13 авто үйлчилгээ эрхлэгч тус тус бүртгэгдэж, судалгаанд хамрагдсан байна. | |
| | | 1.15.2. Ангилал тогтоох ажлыг аймаг орон нутагт зохион байгуулах<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Ангилал тогтоож, гэрээ байгуулсан ААНБ-ын тоо<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Орон нутагт 197 авто үйлчилгээний байгууллага зохих журмын дагуу ангилал тогтоолгож, үйлчилгээний төрлөөс хамааран 224 ангиллын гэрчилгээ авч гэрээ байгуулсан байна.** | - | АТХ | Авто үйлчилгээний мэдээллийн нэгдсэн сангаар дамжуулан тайлант хугацаанд давхардсан тоогоор 69 авто үйлчилгээний эрхлэгч ангилал тогтоолгох хүсэлтээ цахимаар ирүүлсэн.<br>-Орхон 17<br>-Завхан 5<br>-Баянхонгор 1<br>-Говь-Алтай 4<br>-Архангай 10<br>-Өвөрхангай 2<br>-Өмнөговь 10<br>-Дорноговь 11<br>-Хэнтий 5<br>-Говьсүмбэр 1<br>-Баян-Өлгий 3<br>Хүсэлтийг шалгаж үзэхэд холбогдох баримт бичгийн бүрдэл дутуу байсан тул орон нутгийн АТТ-үүдийн хариуцсан ажилтнуудтай холбогдон мэдэгдэж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.<br>Өссөн дүнгээр 192 авто үйлчилгээ эрхлэгчдэд 227 ангиллын гэрчилгээ олгосон. | 100 |
| 1.16 | Ашиглалтаас хасагдсан автомашин, түүний эд ангийг устгах, дахин боловсруулах талаар холбогдох | 1.16.1. Ашиглалтаас хасагдсан автомашин, түүний эд ангийг устгах, дахин боловсруулах талаар санал боловсруулах<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Судалгааны ажлыг хийж, тайлагнасан байх | - | АТХ | Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй авто үйлчилгээний байгууллага, уул уурхай, ашигт малтмал, хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудыг хамруулан тэдгээрийн ажил үйлчилгээний явцад үүссэн аюултай хог хаягдлыг судалгааг гарган санал боловсруулан 2021.06.02-ны | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | судалгааны ажлыг хийх, санал боловсруулах | **Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Судалгааны тайланг яаманд хүргүүлсэн байна.** | | | өдрийн 2/690 тоот албан бичгээр ЗТХЯ-ны АТБХЗГ-т хүргүүлсэн.<br>Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй авто үйлчилгээ эрхлэгчдийн ажил үйлчилгээнээс үүсч буй энгийн болон аюултай хог хаягдлын төрөл, тоон хэмжээн мэдээллийг нэгтгэх, үүсч буй хог хаягдлыг устгах, дахин боловсруулах талаар санал боловсруулах судалгааг 2022.09.05-15-ны өдрүүдэд хийсэн. Орон нутагт авто үйлчилгээ эрхлэгч ААНБ, иргэний 2022 оны тоон судалгаагаар 456 ААНБ, иргэн тоологдсон бөгөөд энэхүү судалгаанд 432 ААНБ, иргэн буюу 92,9%-тай хамрагдсан байна. Судалгааны тайланг 2022.09.22-ний өдрийн 1/1210 тоот албан бичгээр ЗТХЯ-ны АТБХЗГ-т хүргүүлж, тайлагнасан. | |
| 1.17 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, түүнд нийцүүлэн гарсан дүрэм, журам, стандартыг, мөрдүүлж, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | 1.17.1 "ХАБЭА-н мэдлэг олгох нийт ажилтны сургалт" зохион байгуулах<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Сургалтад хамрагдсан ажилтны тоо<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Сургалтанд өссөн дүнгээр 786 ажилтан хамрагдсан байна.** | - | СХЧУТ | "Автотээврийн үндэсний төв" /ТӨҮГ/-ын ХАБЭА-н чиглэлээр ажил олгогч, нийт ажилтны болон тусгай сургалт явуулах эрхийн хугацааг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвөөс 4 жилийн хугацаагаар сунгасан. 2022.12.10-ний байдлаар батлагдсан удирдамжийн дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шинэ болон нийт ажилтны 29 удаагийн 290 цагийн сургалтыг зохион байгуулж үйлдвэрийн газрын 789 ажилтанг сургалтад хамруулж, шалгалт авч гэрчилгээ олгосон. | 100 |
| | | 1.17.2 Улс, хот хоорондын ачаа, зорчигч тээврийн ААНБ-аас ирсэн хүсэлтийн дагуу "ХАБЭА-н мэдлэг олгох нийт ажилтны сургалт", "Ажил олгогч эздийн сургалт" зохион байгуулах.<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Сургалтад хамрагдсан ажилтны тоо<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Сургалтанд өссөн дүнгээр 200 ажилтан хамрагдсан байна.** | | СХЧУТ | 2022.12.10-ний байдлаар батлагдсан удирдамжийн дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажил олгогч болон нийт ажилтны 12 удаагийн 134 цагийн сургалтыг зохион байгуулж, ачаа болон хот хоорондын зорчигч тээврийн 21 аж ахуй нэгж байгууллагын 21 удирдах ажилтан, 27 аж ахуй нэгж байгууллагын 212 ажилтан нийт 233 ажилтан сургалтад хамруулж, шалгалт авч гэрчилгээ олгосон. | 100 |
| | | 1.17.3 ЗТХЯ-аас гаргасан шалгуур үзүүлэлт бүрийн дагуу үйлдвэрийн | - | | "АТҮТ" ТӨҮГ-ын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр 2022 онд хийж хэрэгжүүлэх ажлын | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | газраас 2022 онд ХАБЭА-н чиглэлээр хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө баталж, шаардлагатай нөөцөөр хангаж хэрэгжилтийг тухай бүр тайлагнах.<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**2021 оны зорилтот ажлуудын биелэлт 90-ээс доошгүй хувь хангагдсан байна.** | | СХЧУТ | төлөвлөгөөг ЗТХЯ-с гаргасан шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу боловсруулж Зам, тээврийн хөгжлийн дэд сайд, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хорооны дарга Ж.Бат-Эрдэнэд 2022 оны 1/242 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>Төлөвлөгөөнд тусгагдсан 3 зорилтын хүрээнд 24 арга хэмжээг хэрэгжүүлэх ба төлөвлөгөөний гүйцэтгэлийг 1 дүгээр улирлын байдлаар гаргаж, ЗТХЯ-нд 2022 оны 1/620 тоот албан бичгээр хүргүүлсэн. Төлөвлөгөөний гүйцэтгэл хагас жилийн байдлаар үнэлгээ хийж 46 хувь, 3 дугаар улиралд 75 хувьтай хэрэгжсэн.<br>ХАБЭА-н 2022 оны төлөвлөгөөний гүйцэтгэл 100 хувиар биелсэн ба гүйцэтгэлийг Зам, тээврийн хөгжлийн Дэд сайд, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хорооны дарга Л.Халтарт 2022 оны 1/1571 дугаар албан бичгээр хүргүүлж, хэрэгжилт үр дүнг тайлагнасан. | |
| 1.18 | "Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 259 дүгээр тогтоолын дагуу автотээврийн үйлчилгээг үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлэх; | 1.18.1 Дотоодын ачаа тээврийг бүртгэлжүүлэх, програм хангамжийг улсын хэмжээнд нэвтрүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Дотоодын ачаа тээврийн үйлчилгээг цахимаар авах боломж бүрдсэн байх<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Системүүдийг үйлчилгээнд бүрэн нэвтрүүлсэн байна.** | | АТХ<br>МТХ | Дотоодын ачаа тээврийн цахим системийн мобайл апп хөгжүүлэлтийг Андройд болон IOS үйлдлийн системд зориулан хийж гүйцэтгэж дууссан.<br>Андройд гар утсанд зориулагдсан хувилбар google playStore, IOS үйлдлийн системтэй гар утас болох iphone-д зориулагдсан хувилбар AppStore-д байршуулсан.<br>Орон нутгийн автотээврийн салбар төвүүдэд мэдээлэл хүргүүлсэн.<br>Дотоодын ачаа тээврийн цахим системийн гар утсанд суурилсан хувилбарыг үйлчилгээнд нэвтрүүлэн ажиллаж байна.<br>"Автотээврийн Үндэсний төв" ТӨҮГ-ын www.logistic.transdep.mn-ийг системийг ашиглан 2022 оны жилийн эцсийн байдлаар Дотоодын ачаа тээврийн системээр нийт тээвэрлэгчийн зар-35142, тээврийн хэрэгсэл - 8879, Жолооч-7132, Чиргүүл-10125 ширхэг бүртгэлтэй байна. Системүүдийг бүрэн нэвтрүүлж, дууссан. | 70 |
| | | 1.18.2 Авто үйлчилгээний мэдээллийн сангийн найдвартай ажиллагааг хангаж нэмэлт хөгжүүлэлт хийх<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Авто үйлчилгээний мэдээллийн санд хөгжүүлэлт хийсэн тоо | - | АТХ<br>МТХ | "Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журам" 2016 онд батлагдсан ба 2022.04.25-нд шинэчлэгдэн 2022.07.01-нээс дагаж мөрдөхөөр батлагдсан. Энэхүү журамтай нийцүүлэн www.autobox.mn сайтад доорх хөгжүүлэлтийг бүрэн хийж дуусгалаа.<br>1. Одоо байгаа мэдээллийн санд өмнөх журмаар бүртгэн ангилал тогтоосон ААНБ-ын мэдээллийг | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | **Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин: Авто үйлчилгээний мэдээллийн санд 2 нэмэлт хөгжүүлэлт хийсэн байна.** | | | засч, Мэдээллийн сангийн бүтцэд өөрчлөлт оруулсан<br>2. Ангилал тогтоох шинэчлэн батлагдсан цахим маягтыг шинэчилсэн.<br>3. Шинэ журмаар батлагдсан гэрчилгээнд мэдээллийн сангаас тохируулсан шууд хэвлэдэг болгон өөрчилсөн.<br>4. Үйлчилгээний нэр төрөл 8 байсан нь 21 болгон өргөтгөсөн<br>5. Цахим хүсэлт илгээж, нэвтрэх эрх авах хүртэл удирдлагын хэсгийн шат дараалалд өөрчлөлтүүд хийгдсэн.<br>6. Цахим хүсэлтийн үйлчилгээний сонголтуудаас олон сонголтыг нэг хүсэлтээр хүлээн авдаг болгон нэмэлт өөрлөлт хийгдсэн.<br>7. Нээлттэй үйлчилгээний каталоги-д өөрчлөлт хийсэн, 21 ангилал тус бүрээр гардаг болсон.<br>8. Үндэсний Дата төвийн Хур системийн 8 сервистэй холбогдон ажилладаг ба Хур системийн шинэчлэгдсэн сервисүүдийн холболтыг шинэчлэн хэвийн ажиллагаанд оруулсан.<br>9. Мэргэшсэн жолоочийн дэлгэрэнгүй мэдээллийг харах хэсгийн ажиллагаанд оруулсан. Энэ нь лавлах үйлчилгээний 1900-1234-ийн ачаалал бууруулах мөн иргэд биер ирэн шалгуулах алдаа залруулах хүндрэлийг бууруулах ач холбогдолтой ажил болсон.<br>Програм дахь тайлан мэдээлэл харах;<br>- Авто засварын мэдээллийг он оноор харах, татаж авах; /exl/<br>- Ангилал тогтоолгосон байдал он оноор харах, татаж авах; /exl/<br>- Засвар үйлчилгээний мэдээллийг байршил, байгууллага, огноогоор нь ялган харах, татаж авах; /exl/<br>- Ангилал тогтоолгох цахим хүсэлтийн шаардлага хангасныг Автотээврийн төв, салбарын дарга баталгаажуулдаг байхаар өөрчлөлт оруулсан. | |
| | | 1.18.3 Улс хоорондын байнгын ачаа тээврийн зөвшөөрлийг "е- | 40.0 сая төгрөг | АТХ<br>МТХ | Улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлт ашигладдаг хил нэвтрэх С төрлийн зорчих зөвшөөрлийн бичиг олгох ажлыг "e-mongolia" портал сайтаар дамжуулан олгох | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | mongolia" порталаар олгох нехцелийг бүрдүүлэх;<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Зөвшөөрлийг И-Монгол порталаар олгож эхэлсэн байх<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Системүүдийг үйлчилгээнд бүрэн нэвтрүүлсэн байна.** | /Улсын төсөв/ | | ажлын хүрээнд тус үйлдвэрийн газрын тээврийн нэгдсэн системийн мэдээллийн санг "e-mongolia" портал сайтын мэдээллийн сантай холбох ажлыг хийж дуусгасан.<br>ЗТХЯ-ны 2022.03.11-ний өдрийн 07/1099 тоот албан бичгээр "e-mongolia" портал сайтаар дамжуулан хил нэвтрэх С төрлийн зорчих зөвшөөрлийн бичгийг олгох ажлыг гадаадын иргэний бүртгэлтэй холбоотой асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран бүрэн шийдвэрлэсний дараа нэвтрүүлэх чиглэл өгсөн.<br>Хил нэвтрэх зориулалттай "С" төрлийн зорчих зөвшөөрлийн бичгийг И-Монголиа системд холбож хамтран ажиллах саналыг И-Монголиа академид 2022.12.13-ны өдрийн 1/1566 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>Гадаадын хөрөнгө оруулалттай ААНБ-ын гадаад захирал И-Монголиа системд нэвтэрч чадахгүй байгаагаас нэвтрүүлэлтийн ажил хойшлогдсон байсныг эхний ээлжинд Монгол захиралтай ААНБ-уудын мэдээллийг холбохоор Е-Монгол академитай зөвшилцсөн. | |
| 1.19 | Орон нутагт автотээврийн ажил үйлчилгээг хариуцан гүйцэтгэхдээ тухайн аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулан хэрэгжилтийг хангуулах үр дүнг тооцох | 1.19.1 Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээг дүгнэх, үр дүнг тооцох<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>21 аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээг дүгнэсэн байх<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**2021 оны гэрээг дүгнэж, үр дүнг тооцсон байна.** | - | ЗСХНХ | 2022 онд 21 аймгийн засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулсан бөгөөд 19 аймаг нийт гэрээг дунджаар 78,9 хувьтай дүгнэж, ажилласан байна. | 90 |
| | | 1.19.2 Аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулах<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>21 аймгийн Засаг даргатай гэрээ байгуулсан байх<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин: 21 аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулагдсан байна.** | - | ЗСХНХ | 2021 онд байгуулсан хамтран ажиллах гэрээ нь 2022.12.31-ныг хүртэл хүчинтэй бөгөөд 10 аймгийн засаг даргатай байгуулах гэрээ нь сунгагдаж, шинээр томилогдсон 11 орон нутгийн төвийн дарга нар хамтран ажиллах гэрээгээ шинэчлэн байгуулж, хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1.20 | Гэрээний үндсэн дээр хариуцуулан гүйцэтгэх ажил үйлчилгээг шуурхай зохион байгуулах зорилгоор бусад холбогдох эрх зүйн акттай уялдуулж шаардлагатай дүрэм, журам, стандартыг шинээр боловсруулах, шинэчлэн сайжруулах чиглэлээр санал гаргах, холбогдох дээд шатны байгууллагаар шийдвэрлүүлэх; | 1.20.1 Автотээврийн салбарын чанарын дэд бүтцийг бэхжүүлэх чиглэлээр 5 стандарт шинээр боловсруулах.<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Боловсруулсан стандартын тоо<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Стандартын техникийн хороонд хүргүүлсэн байна.** | | СХЧУТ | Тус үйлдвэрийн газар нь тайлант хугацаанд чанарын дэд бүтцийг бэхжүүлэх чиглэлээр нийт **7** үндэсний стандарт шинээр боловсруулсан ба авто үйлчилгээний чиглэлийн **3** стандартыг стандартчиллын техникийн хороо /ТХ-15/-ны 2022.03.04-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан.<br>Шинээр боловсруулан батлуулсан стандарт:<br>1. MNS 6969-2022 Тээврийн хэрэгслийн резин дугуй засварын үйлчилгээ. Ерөнхий шаардлага.<br>2. MNS 6970-2022 Автотээврийн хэрэгслийн их биеийн засвар, үйлчилгээний байгууллагад тавих шаардлага<br>3. MNS 6971-2022 Автотээврийн хэрэгслийг тос, тослогооны болон ашиглалтын материалаар цэнэглэх үйлчилгээ. Ерөнхий шаардлага.<br>Шинээр боловсруулсан стандарт:<br>1. Бензин хөдөргүүртэй автомашин- Утааны найрлага хэмжигч төхөөрөхмжийг шалгах арга,<br>2. Автомашин – Их гэрлийн цацрагийн тусгал хэмжигч төхөөрөмжийг шалгах арга, хэрэгсэл хэрэгсэл<br>3. Автомашин- тэнхлэгийн хажуу гулсалтыг хэмжигч төхөөрөмжийг шалгах арга, хэрэгсэл<br>4. Дизель хөдөлгүүртэй автомашин- Тортогжилт хэмжигч төхөөрөмжийг шалгах, арга хэрэгсэл<br>Салбарын хэмжил зүйн чиглэлийн дээрх **4** стандартын төслийг шинээр боловсруулж 2022.12.02-ны 01/1561 тоот албан бичгээр Стандарт хэмжил зүйн газарт хүргүүлсэн. | 100 |
| | | 1.20.2 Авто үйлчилгээ эрхлэгчдэд ангилал тогтоох, хяналт тавих журмыг шинэчлэн батлуулахтай холбогдуулан бусад дагаж мөрдөх бичиг баримтад өөрчлөлт оруулах<br>**Хугацаа:**<br>III-IV улирал<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Санал боловсруулж, холбогдох газарт хүргүүлсэн байх<br>**Зорилтот түвшин:** | - | АТХ | ЗТХС-ын "Журам шинэчлэн батлах тухай2022 оны А/112 дугаар тушаалаар Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журам шинэчлэгдсэн батлагдсан.<br>Уг журмыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан үйлдвэрийн газрын захирлын "Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох тухай" 2022.06.02-ны өдрийн А/145 дугаар тушаал батлагдан гарсан.<br>Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль болон Авто үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага MNS5025:2020 стандартад нийцүүлэн журамд өөрчлөлт оруулсан | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | **Холбогдох газарт хүргүүлсэн байна.** | | | ЗТХС-ын баталсан 2021 оны А/93 дугаар "Зам, тээврийн салбарын статистикийн мэдээлэл авах, мэдээллийн сан бий болгох заавар, маягт, нөхөх заавар, үзүүлэлт батлах тухай" тушаалын долдугаар хавсралтад өөрчлөлт оруулах саналыг 2022.10.05-ны өдрийн 1/1256 тоот албан бичгээр ЗТХЯ-ны БТГ-т хүргүүлсэн. | |
| | | 1.20.3 LPG хөдөлгүүр бүхий тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх стандартад холбогдах байгууллагуудаас саналыг авч Стандарт хэмжил зүйн газарт хүргүүлэх.<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Холбогдох байгууллагуудаас санал авч, СХЗГ-т хүргүүлсэн байх<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Стандарт хэмжил зүйн газарт хүргүүлсэн байна.** | - | ТХХ | Хийгээр ажилладаг автотээврийн хэрэгслийн хаягдал утаан дахь хорт бодис, нэмэлт шаардлагыг шалгах талаар "Шингэрүүлсэн шатдаг хийн түлшний системтэй автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх заавар" стандартын төслийг боловсруулсан.<br>Зам, тээврийн хөгжлийн яам, Хууль зүйн дотоод хэргийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Тээврийн цагдаагийн газар, Нийтийн тээврийн үйлчилгээний газруудаас стандартын төсөлд санал авч тусган 2022.10.07-ны өдрийн 1/1274 тоотоор Стандарт хэмжил зүйн газарт хүргүүлсэн. | 100 |
| 1.21 | Зам, тээврийн салбарын үйлчилгээ, үйл ажиллагааг цахимжуулах дунд хугацаа (2020-2024)-ны дэд хөтөлбөрийн хүрээнд: | 1.21.1 Зам, тээврийн салбарын энтерпрайз архитектур, төлөвлөлтийн нэгдсэн платформыг өөрсдийн үйл ажиллагаандаа иж бүрэн нэвтрүүлж, байгууллагынхаа энтерпрайз архитектурын чиг үүрэг, үйл ажиллагааг хариуцан ажиллах ажлын байр, албан тушаалтнуудыг тусгайлан томилж, эдгээр үйл ажиллагаагаа яамны бодлого, төлөвлөлттэй нягт уялдуулж, дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллах.<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Ажлын явц, хувиар<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:** | Улсын төсөв, дотоодын эх үүсвэр | МТХ | Үйлдвэрийн газраас "Интерактив" ХХК-тай байгуулсан Санамж бичгийн хүрээнд "Зам, тээврийн салбарын нэгдсэн платформ" хөгжүүлэх сургалтанд МТХ-ийн мэдээллийн аюулгүй байдлын мэргэжилтэн Б.Гантогтох, техник хангамжийн мэргэжилтэн Ц.Анхбаяр, програм хангамжийн мэргэжилтэн Д.Өсөхбаяр гэсэн 3 мэргэжилтэн хамрагдаж, тус системийн бүтэц зохион байгуулалтыг судалж өөрийн системүүдийг холбоход шаардлагатай бүтэц, архитектурын зохион байгуулалтыг хэрхэн үүсгэх, засварлах зэрэг мэдээллүүдийг суралцаж авсан. Уг сургалт дээр үндэслэн<br>ЗТХЯ-ны 2022.03.07-ны өдрийн 03/1024 тоот албан бичгийн дагуу тус үйлдвэрийн газрын МТХ-ийн мэргэжилтэн Б.Гантогтох, Д.Өсөхбаяр, СХЧУТ-ийн ахлах менежер А.Батчулуун, АТХ-ийн мэргэжилтэн Э.Ганзориг, ЗТХ-ийн ахлах мэргэжилтэн Б.Эрдэнэцэцэг гэсэн 5 мэргэжилтэн удирдамжийн дагуу 2022.07.01-ний өдрийг хүртэл хугацаа сунгагдан "Зам, тээврийн салбарын | 90 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | **Шилжилтийн архитектурын хувилбаруудыг бүрдүүлэн, үнэлж, зорилтот архитектураа эцэслэн тодорхойлж, шилжилтийн арга замаа тогтоон, холбогдох эрх зүй, бодлого, зохицуулалтын орчныг бүрдүүлсэн байна.** | | | нэгдсэн платформ"-ыг хөгжүүлэх ажилд оролцож хөгжүүлэлтийн ажлыг үргэлжлүүлэн хийж эхэлсэн.<br>Зам тээврийн салбарын нэгдсэн платформд үйлдвэрийн газраас<br>1. Тээврийн хэрэгслийн бүртгэл систем<br>2. Техникийн хяналтын үзлэгийн систем<br>3. Хүний нөөц систем<br>4. Тээврийн нэгдсэн систем<br>5. Авто үйлчилгээний систем<br>6. Мэргэшсэн жолоочийн систем<br>7. Дотоодын ачаа тээврийн системүүдийн өгөгдлүүдийг оруулахаар төлөвлөсөн.<br>Тус 7 системийн чиглэлээр үйлдвэрийн газрын статистикийн мэдээ боловсруулдаг мэргэжилтнүүдээс статистик мэдээллийн загвар хүснэгтийг гаргуулан уг загвар хүснэгтийн дагуу дээрх 7 системийн бүтэцтэй уялдуулан платформд үүсгэсэн системүүдийн бүтэц архитектурыг өөрчлөн шинэчлэх ажил явагдаж байна.<br>Загвар хүснэгтийн дагуу нэгдсэн платформд дээрх системүүдийн бүтцүүдийг үүсгэж үүнээс тээврийн хэрэгслийн бүртгэл, техникийн хяналтын үзлэг, хүний нөөц, тээврийн нэгдсэн системүүд дээр гараас файлаар өгөгдөл оруулан график үүсгэж 2022.06.20-ны өдөр ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболдод танилцуулсан.<br>Өгөгдлүүдийг автомат сервесийн аргаар платформд оруулах чиглэлээр үйлдвэрийн газраас тээврийн хэрэгслийн бүртгэл, техникийн хяналтын үзлэг, хүний нөөц, дотоодын ачааны системүүдийг амжилттай холбож өгөгдлийг нэгдсэн платформд оруулж тус өгөгдлийг ашиглан шаардлагатай төрлөөр графикуудыг үүсгэх боломжтой болсон.<br>Холбох 7 системээс үлдсэн гурван систем болох Тээврийн нэгдсэн, Мэргэшсэн жолооч, Авто үйлчилгээний системүүдээс сервес гарган нэгдсэн платформд үүсгэсэн бүтэцтэй холбож хэд хэдэн удаагийн туршилт, шинэчлэлтийн холболтыг хийж үзсэн.<br>Үүнээс мэргэшсэн жолоочийн системийг шалгалт болон ангилалаар тусд нь салгаж холбох, тээврийн нэгдсэн системийг зөвшөөрлийн бичиг зарцуулалт болон ачаа тээвэрлэлтийн гэсэн байдлаар салгаж сервесээр холбоод | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байна. Үүнээс ачаа эргэлтийн мэдээллийг Гаалийн ерөнхий газраас сервесийн аргаар тээврийн нэгдсэн системд холбож мэдээллийг боловсруулан нэгдсэн платформд холбох ажлыг хийхээр Гаалийн ерөнхий газарт 2 удаа очиж уулзан албан бичиг хүргүүлсэн боловч холбогдох хууль дүрэм журмаар хязгаарлагдсан тул хүлээгдсэн байдалтай байна. Одоо холбогдсон системүүд дээр нэмэлт шаардлагатай хөгжүүлэлтүүдийг хийн ажиллаж байна. | |
| | | 1.21.2 Байгууллагынхаа хэмжээнд кибер (мэдээллийн) аюулгүй байдлын эрсдэлийн иж бүрэн шинжилгээ, үнэлгээ хийлгэж, кибер (мэдээллийн) аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо бүрдүүлэх, аюулгүй байдлын архитектураа төлөвлөх талаар цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх.<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Ажлын явц, хувиар<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо бий болгоход шаардлагатай эрх зүй, бодлого, зохицуулалтын орчныг бүрдүүлсэн байна.** | Улсын төсөв, дотоодын эх үүсвэр, төр, хувийн хэвшлийн түншлэл | МТХ | Тус үйлдвэрийн газрын Мэдээллийн технологийн хэлтсээс "SSSC" ХХК-ийн мэдээллийн аюулгүй байдлын мэргэжилтэнтэй холбогдож, эрсдэлийн үнэлгээ хийх цар хүрээг тогтоосон. Уг зөвлөх үйлчилгээтэй холбоотой зардлыг шийдвэрлэхээр ТӨБЗГ-т 2022.02.18-ний өдрийн А-1/310 тоот бичгээр хүсэлт хүргүүлсэн. ТӨБЗГ-аас шаардлагатай тоног төхөөрөмжийг сонирхол татахуйц улсын бүртгэлийн дугаар борлуулсны орлогын эх үүсвэрээс санхүүжүүлэхийг чиглэл болгосон. Үүнтэй холбогдуулан ХНХЯ-нд 2022.04.15-ний өдрийн 2/490 албан бичгээр улсын дугаарын дуудлага худалдаанаас төвлөрсөн сангаас шийдвэрлүүлэхээр хүсэлт хүргүүлсэн. ХНХЯ-наас 2022.04.29-ний өдрийн 01/1176 тоот албан бичгээр дээрх зардлыг шийдвэрлэх хөрөнгийг автотээврийн хэрэгслийн сонирхол татахуйц улсын бүртгэлийн дугаар борлуулсны орлогоос санхүүжүүлэх нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нийцэхгүй байгаа тул боломжгүй байна гэсэн хариу ирүүлсэн.<br>Уг ажлын хүрээнд Кибер аюулгүй байдал, мэдээллийн технологийн аудит, консалтингийн чиглэлээр үйлчилгээ, сургалт явуулдаг "Систем центр" ХХК–ийн захиралтай уулзалт зохион байгуулан тус чиглэлийн өнөөгийн байдал болон цаашид ямар хандлага, технологиор явах талаар сургалтыг авсан. Үйлдвэрийн газрын мэдээллийн технологийн өнөөгийн байдал болон цаашид шаардлагатай байгаа чиглэлээ тодорхойлон тус компаниас систем, өгөгдлийн сангуудаа мэдээллийн технологи, кибер аюулгүй байдлын үнэлгээ, шинжилгээ хийлгэх үнийн санал авч удирдлагуудад танилцуулаад байна. | 50 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 1.21.3 Байгууллагынхаа нийт компьютерын 30-аас дээш хувийг албан ёсны байнгын ашиглах эрх (лиценз)-тэй үйлдлийн систем болон оффисын программ хангамжтай болгож, аюулгүй байдлыг хангах.<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Ажлын явц, хувиар<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Зорилт, арга хэмжээг 100% хэрэгжүүлсэн байна.** | Улсын төсөв, дотоодын эх үүсвэр | МТХ | Үйлдвэрийн газарт ашиглагдаж байгаа зөөврийн болон суурин компьютерүүдийн 30 хувь буюу 140 ширхэг компьютерт шаардлагатай лицензийн үнийн саналыг 3Zeissoftware Digital Limited3 LLC, 3Экзотик девелопмент3 ХХК, "Ашим" ХХК, "Мобинет" ХХК зэрэг албан ёсны лиценз нийлүүлэгч аж ахуй нэгжүүдээс үнийн санал аван төсөвт тодотгол оруулах саналыг хүргүүлээд байна. | 30 |
| | | 1.21.4 Зам, тээврийн салбарын мэдээллийн нэгдсэн платформ дээр суурилсан дэд систем, модуль хөгжүүлэлтүүдийг шуурхай хэрэгжүүлж, уг ажилд шаардлагатай платформ ашиглах эрх (лиценз)-ийг авч, өөрийн ажилтнуудыг энэ чиглэлээр сургаж мэргэшүүлэн, эдгээрт шаардлагатай санхүүжилт, хөрөнгө оруулалтаар нь хангаж, энэ талаар яамнаас хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаатай нягт уялдуулж, дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллах.<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Ажлын явц, хувиар<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин: Платформ дээр суурилсан дэд систем, модуль хөгжүүлэлтийг хэрэгжүүлж, эдгээрийг яамны бодлого, төлөвлөлттэй нягт уялдуулж, дэмжлэг үзүүлж, хамтарч ажилласан байна.** | Улсын төсөв, дотоодын эх үүсвэр, төр, хувийн хэвшлийн түншлэл | МТХ | Үйлдвэрийн газраас "Интерактив" ХХК-тай байгуулсан Санамж бичгийн хүрээнд "Зам, тээврийн салбарын нэгдсэн платформ" хөгжүүлэх сургалтанд МТХ-ийн мэргэжилтэн Б.Гантогтох, Ц.Анхбаяр, Д.Өсөхбаяр гэсэн 3 мэргэжилтэн хамрагдаж тус системийн бүтэц зохион байгуулалтыг судалж өөрийн системүүдийг холбоход шаардлагатай бүтэц, архитектурын зохион байгуулалтыг хэрхэн үүсгэх, засварлах зэрэг мэдээллүүдийг суралцаж авсан. Уг сургалт дээр үндэслэн ЗТХЯ-ны 2022.03.07-ны өдрийн 03/1024 тоот албан бичгийн дагуу тус үйлдвэрийн газрын МТХ-ийн мэргэжилтэн Б.Гантогтох, Д.Өсөхбаяр, СХЧУТ-ийн ахлах менежер А.Батчулуун, АТХ-ийн мэргэжилтэн Э.Ганзориг, ЗТХ-ийн мэргэжилтэн Б.Эрдэнэцэцэг гэсэн 5 мэргэжилтэн удирдамжийн дагуу 2022.07.01-ний өдрийг хүртэл хугацаа сунгагдан "Зам, тээврийн салбарын нэгдсэн платформ"-ыг хөгжүүлэх ажилд оролцож, хөгжүүлэлтийн ажлыг үргэлжлүүлэн хийж эхэлсэн.<br>Зам тээврийн салбарын нэгдсэн платформд үйлдвэрийн газраас<br>1. Тээврийн хэрэгслийн бүртгэл систем<br>2. Техникийн хяналтын үзлэгийн систем<br>3. Хүний нөөц систем<br>4. Тээврийн нэгдсэн систем<br>5. Авто үйлчилгээний систем<br>6. Мэргэшсэн жолоочийн систем | 90 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 7. Дотоодын ачаа тээврийн системүүдийн өгөгдлүүдийг оруулахаар төлөвлөсөн.<br>Тус 7 системийн чиглэлээр үйлдвэрийн газрын статистикийн мэдээ боловсруулдаг мэргэжилтнүүдээс статистик мэдээллийн загвар хүснэгтийг гаргуулан уг загвар хүснэгтийн дагуу дээрх 7 системийн бүтэцтэй уялдуулан платформд үүсгэсэн системүүдийн бүтэц архитектурыг өөрчлөн шинэчлэх ажил явагдаж байна.<br>Загвар хүснэгтийн дагуу нэгдсэн платформд дээрх системүүдийн бүтцүүдийг үүсгэж үүнээс тээврийн хэрэгслийн бүртгэл, техникийн хяналтын үзлэг, хүний нөөц, тээврийн нэгдсэн системүүд дээр гараас файлаар өгөгдөл оруулан график үүсгэж 2022.06.20 –ны өдөр ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболдод танилцуулсан. Өгөгдлүүдийг автомат сервесийн аргаар платформд оруулах чиглэлээр үйлдвэрийн газраас тээврийн хэрэгслийн бүртгэл, техникийн хяналтын үзлэг, хүний нөөц, дотоодын ачааны системүүдийг амжилттай холбож өгөгдлийг нэгдсэн платформд оруулж тус өгөгдлийг ашиглан шаардлагатай төрлөөр графикуудыг үүсгэх боломжтой болсон.<br>Холбох 7 системээс үлдсэн гурван систем болох Тээврийн нэгдсэн, Мэргэшсэн жолооч, Авто үйлчилгээний системүүдээс сервес гарган нэгдсэн платформд үүсгэсэн бүтэцтэй холбож хэд хэдэн удаагийн туршилт, шинэчлэлтийн холболтыг хийж үзсэн. Үүнээс мэргэшсэн жолоочийн системийг шалгалт болон ангилалаар тусд нь салгаж холбох, тээврийн нэгдсэн системийг зөвшөөрлийн бичиг зарцуулалт болон ачаа тээвэрлэлтийн гэсэн байдлаар салгаж сервесээр холбоод байна. Үүнээс ачаа эргэлтийн мэдээллийг Гаалийн ерөнхий газраас сервесийн аргаар тээврийн нэгдсэн системд холбож мэдээллийг боловсруулан нэгдсэн платформд холбох ажлыг хийхээр гаалийн ерөнхий газарт 2 удаа очиж уулзан албан бичиг хүргүүлсэн боловч холбогдох хууль дүрэм журмаар хязгаарлагдсан тул хүлээгдсэн байдалтай байна. Одоо холбогдсон системүүд дээр нэмэлт шаардлагатай хөгжүүлэлтүүдийг хийн ажиллаж байна. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 1.21.5 Тухайн байгууллага өөрсдийн чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд дэвшилтэд техник технологи, инновацын талаар туршлага судлах, хамтын ажиллагаа өргөжүүлэх, судалгаа хийх.<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Судалгааны ажлын тоо<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Нийтдээ 2-оос доошгүй судалгааны ажлын эцсийн тайланг яаманд танилцуулсан байна.** | Улсын төсөв, гадаад, дотоодын эх үүсвэр, төр, хувийн хэвшлийн түншлэл | СХЧУТ | Үйлдвэрийн газрын албан хаагчдын бүтээлч сэтгэхүй, санал санаачлагыг нэмэгдүүлэх замаар үйлчилгээний чанар, хүртээмж, аюлгүй байдлын түвшинг нэмэгдүүлэхээр ажиллаж байна. Энэ хүрээнд үйлдвэрийн газрын хэмжээнд "Зөв хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэхээр ажлын хэсгийг байгуулж, дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>1. Үйлдвэрийн газрын бүтцийн нэгжүүдийн оролцоог хангасан ажлын хэсгийг байгуулсан.<br>2. Зөв хөтөлбөрийг амжилттай нэвтрүүлсэн "Тэсо" ХХК, "АПУ" ХХК, ТЭЦ-3 зэрэг байгууллагуудын туршлагыг судалсан.<br>3. Монголын бүтээмжийн төвөөс 24 цагийн практик сургалтыг онлайн болон танхим хослуулан орон нутаг болон нийслэлийн нийт 150 албан хаагчийг хамруулан сургалтыг зохион байгуулсан.<br>4. Үйлдвэрийн газрын хэмжээнд 2022.10.15-наас эхлэн хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд Япон менежмент "5S"-ын 1S-САЙН АНГИЛАХ /хэрэгтэй, хэрэггүй, чухал, чухал бус/-ажлыг ажлын байрандаа 2022.12.05-ны өдрөөс 2022.12.20-ны өдрүүдэд хэрэгжүүлэх аяныг эхлээд байна<br>Үйлдвэрийн газраас "RMI Автотээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний мэдээллийн сан" судалгааны ажил хийж, тайланг ЗТХЯ-нд 2022.12.15-ны өдрийн 1/1586 тоот албан бичгээр хүргүүлж, танилцуулсан. | 70 |
| | | 1.21.6 Байгууллагынхаа ажилтан, албан хаагчдын тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэн, албан хэрэг хөтлөлтөд ашиглаж, тоон гарын үсэг болон QR кодоор баталгаажуулсан цахим албан бичиг солилцоог бүрэн хэмжээнд нэвтрүүлэх.<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Ажлын явц, хувиар<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:** | Улсын төсөв, дотоодын эх үүсвэр, төр, хувийн хэвшлийн түншлэл | МТХ | Тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн хийхэд шаардлагатай сервис солилцох тоон гарын үсгээр баталгаажсан албан хүсэлтийг хүлээн авч, гэрчилгээний төлбөрийг цахимаар гүйцэтгэх боломжийг бүрдүүлсэн. Тээврийн хэрэгслийн бүртгэлийн VRS систем дээр цахим хүсэлтийн хөгжүүлэлтийг бүрэн хийж дуусгасан.<br>Монгол Улсын Засгийн Газраас баталсан Тоон гарын үсгийн хууль 2022.05.01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөний үйл ажиллагаанд тоон гарын үсгийн үйлчилгээг амжилттай нэвтрүүлж, үйлдвэрийн газрын 125 албан хаагчдад тоон гарын үсгийг олгосон. | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | **Тоон гарын үсгийн хэрэглээг албан хэрэг хөтлөлтөд бүрэн ашигласан байна.** | | | Цахимаар тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн хийх 3 удаагийн сургалтыг нийт тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэргэжилтнүүдэд явуулсан. | |
| | | 1.21.7 Өөрсдийн чиг үүргийн хүрээнд цахимжуулсан үйлчилгээ, үйл ажиллагааныхаа талаар иргэд, олон нийтэд сурталчлан таниулах.<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Тухайн байгууллагын өнөөгийн түвшин<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Тухай бүр цахимжуулсан үйлчилгээ, үйл ажиллагааныхаа талаар иргэд, олон нийтэд сурталчлан таниулсан байна.** | Дотоодын эх үүсвэр | ЗСХНХ | Зам, тээврийн салбарын үйлчилгээ, үйл ажиллагааг цахимжуулах ажлын хүрээнд:<br>1. Дотоодын ачаа тээврийн цахим системийн мобайл апп хөгжүүлэлтийг Андройд болон IOS үйлдлийн системд зориулан хийж гүйцэтгэж дууссан. Андройд гар утсанд зориулагдсан хувилбар google playStore, IOS үйлдлийн системтэй гар утас болох iphone-д зориулагдсан хувилбар AppStore-д байршуулсан.<br>2. Нотариатчидын танхимтай хамтран нотариатын серверийг бүртгэлийн програмтай холбон үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.<br>3. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тээврийн хэрэгсэл бүртгүүлэх хүсэлтийг тоон гарын үсгээр баталгаажуулан цахимаар авах боломжийг бүрдүүлсэн.<br>4. Хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын тээвэрлэлтийн гэрээ дүгнэх, албан хүсэлт авах, шийдвэрлэх үйл ажиллагааг цахимжуулан Тээврийн нэгдсэн системийг бүрэн нэвтрүүлсэн.<br>5. Улс болон хот хоорондын зорчигч тээвэрлэлтийн тасалбар борлуулалтыг сайжруулах чиглэлээр төр болон хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд **TAPATRIP** гар утасны апплэкэйшн-ээр дамжуулан тасалбар борлуулалтыг нэмэгдүүлэн ажиллаж байгаа бөгөөд цаашид автотээврийн хэрэгслийн гэрчилгээ, мэргэшсэн жолоочийн үнэмлэхийг цахим болгохоор бэлтгэл ажлыг бүрэн хангаад байна.<br>Дээрх ажлыг олон нийтэд сурталчлах, таниулах ажлын хүрээнд тухай бүр нь үйлдвэрийн газрын албан ёсны веб сайт https://www.transdep.mn// болон, албан ёсны фейсбүүк хуудаст, мөн үйлдвэрийн газрын хамтран | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажилладаг www.bolod.mn, www.ergelt.mn, www.massnews.mn, www.asu.mn, www.ubn.mn, www.npost.mn, www.peak.mn, www.zarig.mn, www.key.mn болон авто радиа 99.7 зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран тухай бүрт сурталчлан ажиллаж байна. | |
| | | 1.21.8 Зорчигчийн нэгдсэн тасалбар нэвтрүүлж, уг ажлыг бусад байгууллага, нэгжүүдийн үйл ажиллагаатай нягт уялдуулж, дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллах.<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Цахим тасалбар худалдан авалтын эзлэх хувь<br>**Хугацаа:**<br>I-III улирал<br>**Зорилтот түвшин:**<br>**Зорчигчийн нэгдсэн тасалбар борлуулж эхэлсэн байна.** | Улсын төсөв, дотоодын эх үүсвэр, төр, хувийн хэвшлийн түншлэл | МТХ<br>ЗТХ | Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Tapatrip, Social Pay, SkyTicket зэрэг нэгдсэн платформууд дээр нэгэн зэрэг автотээвэр, иргэний нисэх, төмөр замын зорчигч тээврийн тасалбаруудыг борлуулж байна. Заавал 1 тасалбар дээр гаргах шаардлагагүйгээр 1 платформ дээрээс аль ч билетээ авах боломжоор хангасан. 2022.12.10-ний өдийн байдлаар 568,163 захиалгыг уг нээлттэй сервисээр дамжуулан хүлээн авсан байна.<br>Тасалбар захиалгыг онлайнаар хийх болон төлбөрийн системийг бүрэн цахимжуулсан. | 100 |
| | | 1.21.9 Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээ (RFID tag)-г бүрэн нэвтрүүлж, татвар даатгал, төлбөр тооцоо, бүртгэл хяналтын үйл ажиллагааг сайжруулах.<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Хэрэгжилтийн байдлаар<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин: Холбогдох шийдвэрийг үндэслэж техникийн хяналтын цахим гэрчилгээ (RFID tag)-г автотээврийн хэрэгсэлд байрлуулах ажлыг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн байна.** | Улсын төсөв, дотоодын эх үүсвэр, төр, хувийн хэвшлийн түншлэл | МТХ | Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.4-д “Автотээврийн үйлчилгээнд RFID /Радио давтамжийг таних төхөөрөмж/ системийг нэвтрүүлэх” гэж заасны дагуу тус үйлдвэрийн газраас 2017 онд судалгаа хийж, уг системийг эхний ээлжинд Өмнөговь аймгийн Гашуун сухайт боомтын чиглэлд нэвтрүүлэхээр шийдвэрлэсэн.<br>Тус үйлдвэрийн газрын 2018 оны хөрөнгө оруулалтаар 4 ширхэг шошго уншигч RFID төхөөрөмж худалдан авсан. 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд RFID төхөөрөмжид шаардлагатай 8000 ширхэг шошго худалдан авахад шаардагдах зардлын саналыг тусган, ТӨБЗГ-т 2018.11.16-ны өдрийн 1/2292 тоот албан бичгээр хүргүүлж, ТӨБЗГ-ын 2018.12.18-ны өдрийн хуралдаанаар батлуулсан. Худалдан авах ажиллагааг зарлаж, шалгарсан компанитай гэрээ байгуулан, гэрээний дагуу 8000 шошгыг хүлээн авсан. | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ЗТХЯ-ны урд зогсоолын нэвтрэх болон гарах хаалтан дээр туршилтын систем суурилуулан ЗТХЯ, АТҮТ-ийн 200ш тээврийн хэрэгсэл дээр туршилтын ажлыг хийсэн.<br>Үйлдвэрийн газрын 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 26 ширхэг RFID уншигч төхөөрөмж тусгагдсан боловч ТӨБЗГ-ын 2020.04.06-ны өдрийн А-1/574 дугаар албан даалгаврын дагуу энэхүү худалдан авах ажиллагаа зогсоож, 2020 онд хэрэгжих боломжгүй болсон.<br>Иймд үйлдвэрийн газраас Нийслэлийн засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Мэдээлэл технологийн газарт уншигч төхөөрөмжийг шийдвэрлүүлэх тухай хүсэлт явуулсан. Тус газраас RFID уншигч төхөөрөмжийг худалдан авах ажлыг зохион байгуулан, нэгдсэн програм хангамж тоног төхөөрөмж нийлүүлэх хаалттай тендер зарлаж, гүйцэтгэх компани шалгарсан тухай мэдэгдсэн.<br>Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2021 оны А/491 дүгээр захирамжаар "Нийслэл хотын хэмжээнд замын хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгсэлтэй холбоотой харилцааг технологийн шийдлийн тусламжтайгаар сайжруулах, зам, тээврийн ухаалаг нэгдсэн системийг нэвтрүүлэхэд шаардлагатай судалгаа тооцоог гаргах, техникийн даалгавруудыг нэгтгэх ажлыг хэрэгжүүлэх" үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд тус ажлын хэсгээс Улаанбаатар хотын шалган нэвтрүүлэх 7 товчоо болон нийслэлийн авто замын 153 уулзварт RFID төхөөрөмжүүд болон хяналтын камеруудыг суурилуулахаар ажиллаж байгаа.<br>2021 онд тус үйлдвэрийн газар нь зам, тээврийн салбарын харьяа байгууллагуудад ашиглагдаж буй тээврийн хэрэгслийн жагсаалтыг авч, шошго байршуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Мөн өөрсдийн нөхцөл боломжид тулгуурлан Улаанбаатар хотын Сонгинохайрхан техникийн хяналтын үзлэгийн төвд RFID уншигч төхөөрөмж суурилуулсан бөгөөд ААНБ-уудын том оврын автобуснуудад шошго байршуулах ажлыг хийж байна.<br>2022 онд Монгол улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоолын 4 дэх заалтын хэрэгжилтийг хангах ажлын | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүрээнд “Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээ /RFID/-г урьдчилан бэлтгэх, тээврийн хэрэгсэлд байрлуулах, бүртгэх үйл ажиллагааны 2022 оны нарийвчилсан төлөвлөгөө”-ний санал авах бичиг ЗТХЯ-наас 2022.02.18-ны өдрийн 04/728 тоотоор ирүүлсэн бөгөөд санал хүргүүлэн хамтран ажиллаж байна.<br>Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан тээврийн хэрэгсэлд RFID шошго суурилуулах" ажлын хэсэг ЗТХЯ дээр байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд үйлдвэрийн газраас шаардлагатай мэдээллүүдийг гарган ажлын хэсэгт орж хамтран ажиллаж байна.<br>Ажлын хэсгээс RFID шошгоны загварыг батлан шошго нийлүүлэх сонгон шалгаруулах ажлыг Албан журмын даатгагчдын холбоотой хамтран зохион байгуулах бөгөөд 2023 оны 1-р улиралд тээврийн хэрэгслүүдэд байршуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна. | |
| | | 1.21.10 Автотээврийн хэрэгслийн бүртгэлийн системийг сайжруулах, хөгжүүлэх талаар цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх.<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Хэрэгжилтийн байдлаар<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин: Судалгааны ажлын үр дүнгийн дагуу сайжруулах, хөгжүүлэх ажлыг хэрэгжүүлж, хэвийн тасралтгүй ажиллагааг хангасан байна.** | Дотоодын эх үүсвэр | МТХ | Тээврийн хэрэгслийн бүртгэлийн үйлчилгээг цахимаар үзүүлэх чиглэлээр “VRS” системд “Гааль”, “Татварын ноогдолтой эсэх”, “Нотариат”-ын сервис холбож дууссан. Уг сервисийг холбосноор иргэн гэрээний материал цаасаар авчирах шаардлагагүй болсон бөгөөд тухайн иргэнтэй хийсэн гэрээг цахимаар солилцдог болсон.<br>Мөн бүртгэлийн мэргэжилтний ажлын үр бүтээмжийн дээшлүүлж аливаа хуурамч бичиг баримт, залилангаас хамгаалах үр ашигтай ажил болсон. Програмчлалын хувьд нотариатын сервистэй холбогдсоноор цахим маягт дээр тухайн А-тал, Б-талын мэдээллийг бүртглийн цахим архивт давхар хадгалж, PDF форматаар автоматаар хадгалж архивладаг болсон.<br>2022.08.18-ны өдөр ЗТХЯ-ны АТБХЗГ-т Тээврийн хэрэгслийн бүртгэлийн VRS системийг шинэчлэн боловсруулах ажлын даалгавар болон мэдээллийн аюулгүй байдал, өгөгдлийн баазын найдвартай ажиллагааг хангах техник, тоног төхөөрөмийн саналыг хүргүүлээд байна.<br>Одоогийн байдлаар тээврийн хэрэгслийн даатгалтай эсэх сервис хүлээгдэж байна.<br>https://service.transdep.mn/ цахим хаягаар байгууллагын үйл ажиллагааны чиглэл тус бүрээр нээлттэй сервис гарган төр ба хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хамтран ажиллаж байна. "Инвескор" ББСБ ХХК-тай гэрээ байгуулан тоон гарын үсгийн албан хүсэлтийг туршилт хийж үйлчилгээг эхлүүлсэн.<br>Уг үйлчилгээг нэвтрүүлснээр ААНБ-г тоон гарын үсэг ашиглан тээврийн хэрэгслээ бүртгүүлэх, шилжүүлэх хүсэлтээ цахимаар илгээх боломжтой болсон.<br>2022.12.10-ны өдрийн байдлаар системд нийт 529 цахим хүсэлт ирүүлснээс 312 цахим хүсэлтийг шийдвэрлэсэн. | |
| | ДҮН | | | | | **85.8** |

Танилцсан:

"АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ" ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ Б.ГҮРСОРОНЗОН

Хянасан:

ЗАХИРГАА, СУРГАЛТ, ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Б.БААТАРЦОЛ

Нэгтгэсэн:

ЗАХИРГАА, СУРГАЛТ, ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН М.ЭНХЗАЯА